



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар A/110

Улаанбаатар хот

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа
(Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа)-ны үзэл
баримтлал, асуулга, нөхөн зааврыг батлах тухай

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 7 дугаар заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа (Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа)-ны үзэл баримтлалыг 1 дүгээр хавсралтаар, судалгааны асуулга, түүнийг нөхөн зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан үзэл баримтлал, асуулгын дагуу Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа (Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа)-ны бэлтгэл ажлыг ханган, чанартай зохион байгуулахыг Нийгмийн статистикийн газар (Э.Эрдэнэсан), Мэдээллийн технологийн газар (Ц.Эрдэнэмөнх)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар (Ч.Баянчимэг)-т үүрэг болгосугай.



Б.БАТДАВАА



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

Үндэсний статистикийн хорооны даргын
2023 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн
A/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА
(АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУДАЛГАА)-НЫ
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Улаанбаатар хот

2023 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
I. ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛИЙН СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР	6
1.1. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ	6
1.1.1. Хэрэгцээг тодорхойлох	6
1.1.2. Хэрэгцээг зөвлөлдөх, баталгаажуулах	7
1.1.3. Гарцын зорилгыг тодорхойлох	7
1.1.4. Ойлголт, тодорхойлолтыг тодорхойлох	8
1.1.5. Мэдээллийн бэлэн байдлыг шалгах	8
1.1.6. Бүтээгдэхүүний гарцыг төлөвлөх	10
1.1.7. Хувьсагчдыг тодорхойлж, төлөвлөх	10
1.1.8. Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх	11
1.1.9. Түүврийн хүрээ, дизайн	13
Хамрах хүрээ	13
Түүврийн нэгж	13
Судалгааны үр дунг тархаах түвшин	14
Түүврийн хэмжээг тодорхойлох	14
Түүврийн жин	16
1.1.10. Боловсруулалт, дүн шинжилгээг төлөвлөх	17
1.2. СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CYA)-НЫ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХ ҮЕ ШАТ 18	
1.2.1. Мэдээлэл цуглуулалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх	18
1.2.2. Мэдээлэл боловсруулалтын арга зүй, систем, программ хангамжийг бүрдүүлэх	18
1.2.3. Мэдээлэл тархаалтад ашиглах элементүүдийг бүрдүүлэх	19
1.2.4. CYA-г загварчлах	19
1.2.5. CYA-нд ашиглагдах элементүүдийг турших	19
1.2.6. CYA-ны загварыг бүхэлд нь турших	19
1.2.7. CYA-ны загварыг эцэслэх	19
1.3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ҮЕ ШАТ	20
1.3.1. Түүврийн хүрээг бүрдүүлэх, түүвэрлэлт хийх	20
1.3.2. Мэдээлэл цуглуулалтад бэлтгэх	21
1.3.3 Мэдээлэл цуглуулалтыг хэрэгжүүлэх	21
1.4. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ	22
1.4.1. Мэдээллийг нэгтгэх	22
1.4.2. Ангилах, кодлох	22
1.4.3. Хлигийн баталгаажуулах	22
1.4.4. Засварлах, нөхөн тооцох	23

<u>1.4.5.</u>	<u>Шинэ хувьсагч, нэгжийг гарган авах</u>	23
<u>1.4.6.</u>	<u>Жинг тооцож оруулах</u>	23
<u>1.4.7.</u>	<u>Нэгтгэсэн үзүүлэлтийг тооцох</u>	23
<u>1.4.8.</u>	<u>Өгөгдлийн файлыг эцэслэх</u>	24
<u>1.5.</u>	<u>ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ</u>	24
<u>1.5.1.</u>	<u>Гарцын төслийг бэлтгэх</u>	24
<u>1.5.2.</u>	<u>Гарцыг хянан баталгаажуулах</u>	24
<u>1.5.3.</u>	<u>Гарцыг тайлбарлах</u>	25
<u>1.5.4.</u>	<u>Мэдээллийн нууцлалыг хамгаалахад хяналт тавих</u>	25
<u>1.5.5.</u>	<u>Гарцыг эцэслэх</u>	25
<u>1.6.</u>	<u>ТАРХААХ</u>	26
<u>1.6.1.</u>	<u>Гарцын системийг шинэчлэх</u>	26
<u>1.6.2.</u>	<u>Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох</u>	26
<u>1.6.3.</u>	<u>Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд зарлах</u>	26
<u>1.6.4.</u>	<u>Статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах</u>	26
<u>1.6.5.</u>	<u>Хэрэглэгчидтэй харилцах</u>	27
<u>1.7.</u>	<u>ҮНЭЛЭХ</u>	27
<u>1.7.1.</u>	<u>Үнэлгээний орцыг цуглуулах</u>	27
<u>1.7.2.</u>	<u>Үнэлгээг хийх</u>	27
<u>1.7.3.</u>	<u>Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах</u>	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГХХЭС	Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа
АОАБС	Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа
ГХМБТГ	Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар
ГХСОУА	Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал
НиСГ	Нийгмийн статистикийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
CYAE3	Статистикийн үйл ажиллагааны өрөнхий загвар
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТГ	Тамгын газар
TX3	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
YCХ	Үндэсний статистикийн хороо
CYA	Статистикийн үйл ажиллагаа
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан

УДИРТГАЛ

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдэлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Гэмт хэргийн хохирогчийн эрхийн асуудал нь хүний эрхийн асуудал бөгөөд дэлхийн улс орнууд хүний эрх, түүний дотроос хохирогчийн эрхийн асуудлыг эртнээс судлан иргэдийнхээ эрхийг хамгаалж ирсэн түүхтэй.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр шийдвэрээр "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал" батлагдан гарсан нь дэлхийн улс орнуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон виктимологи/хохирогч судлал/-ийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл буй болсон. Энэ үеэс гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах тухай асуудал дэлхийн улс орнуудын хууль цаазын бодлогын нэг чухал хэсэг болон хувирч, эрүүгийн хянан шийдвэрлэх тогтолцоогоо бүхэлд нь өөрчлөх асуудал чухлаар тавигдах болжээ.

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа нь зөвхөн гэмт хэргийн хохирогч, хохирлын талаар судлаад зогсдоггүй, гэмт хэргийн түвшин, чиг хандлага, төрөл, гэмт хэрэг, аюулгүй байдал, айдсын талаарх ойлголт, нийгэм болон эмзээг бүлэгт гэмт хэргийн нөлөөлөл, гэмт хэргийн системийг хүлээн зөвшөөрөх эсэх, гэмт хэргийн талаарх мэдээлэх хандлага, хохирлоос зайлсхийх, эрсдэлийг бууруулах талаарх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээ хэрэгжиж байгаа байдал гэх мэт олон талаас нь нарийвчлан судалдгаараа бусад судалгаануудаас онцлогтой. Маш өргөн хүрээтэй мэдээллийг хамардаг учраас судалгааны зорилго маш тодорхой, оновчтой байх ёстой байdag.

Энэхүү судалгаа нь зөвхөн хохирогчийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх, хохирогчийн хохирлыг хэрхэн барагдуулах вэ гэдгээс гадна тухайн улс оронд хүний эрх ямар хэмжээнд хамгаалагдаж байдгийг илтгэдгээрээ олон улсад өндөр ач холбогдолтойд тооцогддог судалгаа юм.

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "м"-д заасны дагуу "Гэмт хэрэгт хохирох эрсдэл"-ийн судалгааг 2023 онд анх удаа зохион байгуулж байна. Энэхүү судалгаа нь хохирогч, хүний эрх, засаглал, аюулгүй байдал, айdas, хохирох эрсдэл, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудад иргэдийн итгэх итгэлийн талаарх өргөн мэдээллийг бий болгох юм. Мөн хууль зүйн салбарын Тогтвортой хөгжлийн зорилтын одоогоор мэдээллийн эх үүсвэргүй байгаа 4 үзүүлэлт, задаргаа нь гаражгүй байгаа 4 үзүүлэлт болон НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны гаражгүй байгаа мэдээллийг судалгаанаас гаргана.

Энэхүү судалгаанд НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын Эдийн засгийн комиссоос хамтран гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлагыг мөрдлөг болгон судалгааг зохион байгуулж, мэдээллийг цуглуулж, боловсруулж, анализ дүн шинжилгээ хийж, мэдээллийг нийтэд тархаана. Судалгаанд

8000 өрхийн 14 түүнээс дээш насын иргэдийг хамруулж, үр дүнг үндэсний болон бүсийн түвшинд, мөн байршилаар тооцон гаргана.

Энэхүү үзэл баримтлалыг статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (CYAE3)-ын дагуу боловсрууллаа.

Судалгааны нэршил: Монгол Улсын Статистикийн тухай хуульд заасан “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа” гэдэг нэрээр судалгааны мэдээллийг цуглуулахад уг нэрийг сонсоод иргэд судалгаанаас татгалзах магадлал өндөр, мэдээлэл цуглуулалтад эрсдэлтэй гэж үзсэн учраас судалгааны мэдээлэл цуглуулалтын үед нэрийг “Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа” нэршлээр явуулахаар судалгааны удирдах зөвлөл, ажлын хэсэг, олон улсын зөвлөхүүдтэй зөвшилцсөн. Судалгаагаар хохирогчийн эмзэг асуудлыг сануулах байдлаар асуудаг учраас бусад улс орнууд ч өөр нэрээр хохирогчийн судалгааг явуулсан туршлага байна. Үүнд: Солонгос улс – Олон нийтийн аюулгүй байдлын судалгаа, Герман улс- Амьдралын нөхцөл байдал, аюулгүй байдлын судалгаа нэрээр судалгааг зохион байгуулсан байна.

I. ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЭРСДЭЛИЙН СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР

1.1. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ

ГХХЭС-ны мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үйл ажиллагаа нь 1.1.1-1.1.5 дэд үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох

1.1 Хэрэгцээг тодорхойлох	1.2 Хэрэгцээг зөвлөлдөх, баталгаажуулах	1.3 Гарцын зорилтыг тодорхойлох	1.4 Ойлголт, тодорхойлолтыг тодорхойлох	1.5 Мэдээллийн бэлэн байдлыг шалгах	1.6 Статистикийн үйл ажиллагааны үзэл баримтлалыг боловсруулах
---------------------------	---	---------------------------------	---	-------------------------------------	--

1.1.1. Хэрэгцээг тодорхойлох

Судалгааг зохион байгуулах үндэслэл, хэрэгцээ:

- Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “м” заалт;
- “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд хийгдсэн “Swot” үнэлгээний үр дүнд мэдээллийг хэрэгцээг тодорхойлсон.
- Одоогоор эх үүсвэргүй ТХЗ-ын холбогдох үзүүлэлтүүдийг шинээр гаргах
- НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны одоогоор эх үүсвэргүй “Хохирогчийн судалгаа”-ны бүлгийг шинээр буй болгох
- Оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээг хангах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах бодлого, хөтөлбөр болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үнэлэх суурь мэдээллийг буй болгох
- Шаардлагатай тохиолдолд судалгааны асуудлаар холбогдох төрийн, төрийн бус байгууллага, судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачид, иргэдээс санал авч тусгаж, ажиллана.

1.1.2. Хэрэгцээг зөвлөлдөх, баталгаажуулах

- Мэдээллийн хэрэгцээг тодорхойлсны үр дүнд олон улсын болон үндэсний зөвлөхүүд, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажилтнууд, хэрэглэгчдийг хамруулсан хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, зөвлөлдөх баталгаажуулсан.
- Мэдээллийн хэрэгцээг тодорхойлоход НҮБ-ын Статистикийн комиссын удирдамж, зааварчилгаа, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын холбооноос эрхлэн гаргасан “Хохирогчийн судалгаа”-ны гарын авлагыг мөрдлөг мөрдлөг болгож ажиллана.
- Мөн Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг бий болгох чиглэлээр яам, агентлаг, НҮБ, түүний төрөлжсөн байгууллага, олон улсын байгууллага, судалгааны шинжээчдээс шаардлагатай тохиолдолд зөвлөмж авч хамтран ажиллана.
- Мэдээллийн хэрэгцээг судалгааны зорилготой уялдуулж, холбогдох оролцогч талуудын саналыг тусган хэлэлцүүлгээр эцэслэн баталгаажуулж ажиллана.

1.1.3. Гарцын зорилгыг тодорхойлох

- Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны зорилго нь хүн амын аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөл болон гэмт хэрэгт хохирсон байдлаар дамжуулан Монгол хүний амьдралын чанарт гарч байгаа өөрчлөлтийг судлах явдал юм.

Дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Иргэдийн амьдрах орчны нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд хоорондын харилцаа, оролцоо
- Цагдаагийн байгууллага болон гэмт хэргийн талаарх иргэдийн үзэл бодол, гэмт хэрэгт хохирох байдалд нөлөөлж буй хүчин зүйлс, айх айдас, иргэдийн гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлага,
- Гэмт хэргийн хохирогч, түүний шинж байдал, гэмт хэргийн төрлүүд, гэмт хэрэгт хохирох эрсдэл
- Гэмт хэргийн хохирол, түүнийг барагдуулахад хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хандаж буй хандлага, иргэдийн итгэх итгэл
- Тогтвортой хөгжлийн болон Алсын хараа-2050-ын холбогдох үзүүлэлтүүдийг тооцох
- Судалгааны үр дүнгийн тайлан боловсруулж, нийтэд тархаах
- Статистикийн мэдээллийн нэгдсэн санг З жил тутам судалгааны мэдээллээр баяжуулах;
- Өрх, хувь хүний нууцлал хангасан мэдээллийн баазыг нийт хэрэглэгч ашиглах боломж бүрдүүлэх;
- Бодлого боловсруулагч болон хэрэглэгчид, бусад оролцогч талуудыг хэрэгцээтэй мэдээллээр хангах

1.1.4. Ойлголт, тодорхойлолтыг тодорхойлох

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаанд нийгмийн салбарын түүвэр судалгаа, тооллогод нийтлэг байдлаар ашигладаг ойлголт, тодорхойлолтоос гадна “Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагаа”-ны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, НҮБ-ын Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллын ойлголт, тодорхойлолт, бусад олон улсын байгууллагуудын гарын авлага, зөвлөмжийн ойлголт, тодорхойлолтыг уялдуулан ашиглана.

Мөн судалгааны асуулгыг боловсруулахад НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын Холбооноос батлан гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлага, НҮБ-ын Статистикийн Комиссоос баталсан олон улсад хэрэглэж байгаа нийтлэг аргачлал, арга зүйг мөрдлөг болгоно.

1.1.5. Мэдээллийн бэлэн байдлыг шалгах

- Гэмт хэрэг, гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн хохирол, хохирол нөхөн төлүүлэлд, гэмт хэрэгтэн, хохирогчийн хамаарал, гэмт хэргээс хохироход нөлөөлж буй хүчин зүйлс болон амьдрах орчны аюулгүй байдлын талаарх үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь “Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа” юм.
Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа нь маш их өргөн мэдээллийг хамруулан судалдаг хүний эрхийг хөндсөн чухал ач холбогдол бүхий судалгаа бөгөөд тухайн судалгааг зохион байгуулж явуулахад судалгааны зорилго тодорхой байх нь маш чухал байдаг. Судалгааны хэрэгцээ, шаардлага, зорилго, зорилтыг тодорхойлсноор судалгааны түүврийн хүрээ, зорилтот бүлэг, үзэл баримтлал, асуулга, зааврыг боловсруулж, асуулгыг туршиж, мэдээлэл цуглуулах процесс явагдана. Судалгааны мэдээллийг цуглуулахад мэдээлэл цуглуулах оновчтой аргыг сонгох явдал бас чухал байдаг. Судалгааны эцсийн үр дүн мэдээлэл цуглуулалтын чанараас шууд хамаарна. Мэдээлэл цуглуулалтын чанар нь мэдээлэл цуглуулагчийг хэрхэн бэлтгэнээс ихээхэн шалтгаална.
 - Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны өгөгдлөөс олон улсын нийтлэг арга зүйд нийцсэн аргачлалын дагуу үндсэн үзүүлэлтүүдийг тооцож, үр дүнг хэрэглэгчдэд тархаана.
 - Программ хангамж ашиглан судалгааны мэдээллийн баазыг үүсгэн, SPSS/STATA/RStudio статистикийн программ хангамжийг ашиглан мэдээллийн боловсруулалтыг хийнэ.
 - Судалгаанд сонгогдсон 8000 өрхийн 14, түүнээс дээш насны гишүүдээс Өрхийн асуулга (маягт АОАБС-1), Өрхийн гишүүний асуулга (маягт АОАБС-2), Хохирсон байдлын асуулга (маягт АОАБС-3) маягтын дагуу мэдээллийг цуглуулж, мэдээллийн баазыг үүсгэнэ. Мэдээллийг нүүр тулсан ярилцлагын хэлбэрээр таблет ашиглан цуглуулна.
- Мэдээлэл цуглуулалтын үр дүнд үүссэн мэдээллийн баазыг Статистикийн мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам болон “Мэдээллийн аюулгүй байдлын журам” бусад холбогдох баримт бичгийг мөрдлөг болгон мэдээллийн үнэн зөв, уялдаа холбоог хянана.
 - Тохирлын хүснэгт -1.

1	Тохирлын шалгур үзүүлэлтүүд	Тодорхойлсон эрэлт хэрэгцээний хувьд ГХЭС-23	Одоогийн байгаа, мэдээлэл судалгааны хувьд	Зөрүүтэй байдлын үнэлгээ, дүгнэлт	Зөрүүг арилгахын тулд авах арга хэмжээ
2	Зорилго	Нийцсэн			
3	Ойлголт, тодорхойлолт	Нийцсэн			
4	Хамрах хүрээ	Тодорхойлсон зорилтын хүрээнд			
5	Хугацаа	2023.01-2024.06 сар			
6	Мэдээлт цуглуулах арга	Нүүр тулсан			
7	Зорилтот бүлэг	Гэмт хэрэгт хохирсон иргэн			
8	Насны хязгаар	Сонгогдсон өрхийн 16, түүнээс дээш насны иргэд			

1.1.6 Статистикийн үйл ажиллагааны үзэл баримтлалыг боловсруулах

- Статистикийн үйл ажиллагааны үзэл баримтлалыг боловсруулахын тулд мэдээллийн хэрэгцээнд үндэслэн судалгааны зорилго, түүврийн хүрээ, зорилтот бүлэг, хамрах хүрээ, хамрах хугацаа, насны хязгаар зэргийг хэлэлцэн тодорхойлж, асуулга, асуулгын нөхөх зааврын төслийг боловсруулсан байна.
- Судалгааны үзэл баримтлалыг боловсруулахад НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комиссоос хамтран гаргасан Хохирогчийн судалгааны гарын авлагыг мөрдлөг болгон судалгааны зорилго, мэдээллийн хамрах хүрээтэй уялдуулан үзэл баримтлалыг боловсруулсан болно.
- Мөн оролцогч талууд, хэрэглэгчдийн оролцоог ханган, удирдах зөвлөл болон ажлын хэсэг байгуулан ажилласан болно.
- Мэдээллийн хэрэгцээг хангах зорилгоор уг судалгаагаар ТХЗ-ын холбогдох үзүүлэлтийг тооцон гаргах бөгөөд уг үзүүлэлтүүдийг асуулгад тусгахдаа НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын зөвлөмжийн дагуу НҮБ-аас гаргасан ТХЗ-ын үзүүлэлтүүдийг тооцох нэгдсэн арга зүй <https://unstats.un.org/sdgs/metadata/>-г мөрдлөг болгон ажилласан. Мөн бусад <https://unstats.un.org/sdgs/metadata/> холбогдох эх үүсвэрээс судалгааны асуулгад туссан ТХЗ-ын үзүүлэлтүүд гарч байгаа давхардлыг арилгах талаар зөвшилцсөн болно. Судалгааны асуулгыг 3 жилээр асуухаас гадна 12 сараар асууна. ТХЗ-ын холбогдох үзүүлэлтүүд сүүлийн 12 сарын асуулгаас гарахаар томьёолсон.

СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ

Төлөвлөх					
2.1 Бүтээгдэхүүний гарцыг төлөвлөх	2.2 Хувьсагчдыг тодорхойлж, төлөвлөх	2.3 Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх	2.4 Түүврийн хүрээ, дизайн	2.5 Боловсруулалт, дүн шинжилгээг төлөвлөх	2.6 CYA-ны загварыг тодорхойлох

1.1.6. Бүтээгдэхүүний гарцыг төлөвлөх

ГХХЭС-ны мэдээлэл тархаах үе шатны төлөвлөлтийг хамруулна. Мэдээлэл тархаах, хэрэглэгчдэд хүргэх арга зам нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Хэвлэмэл бүтээгдэхүүн (Судалгааны тайлан, ойлголт, тодорхойлолт, арга зүйн тайлбар, танилцуулах текст, хүснэгт, график, инфографик, нугалбар);
- Вебэд суурилсан интерактив цахим бүтээгдэхүүн, хэрэглэгчдэд ашиглуулах боломжтой микро өгөгдлийн сан (хэрэглэгч өөрийн сонгосон үзүүлэлт, хувьсагчийг монгол, ангиллаар хүснэгт, график хэлбэрээр гарган авах боломжтой вебэд суурилсан интерактив цахим мэдээллийн сан /Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn, таблица дашбоард);
- Статистикийн мета мэдээллийн сан (үзүүлэлтийн ойлголт тодорхойлолт, арга зүй);
- Сурталчилгааны материалууд (инфографик, таблица дашбоард, сэдэвчилсэн танилцуулга);
- Судалгааны тайлан бэлтгэхэд шаардлагатай хүснэгтийн загвар, тооцооллын excel файл, мэдээлэл оруулах, гарах хүснэгт авах программ хангамж.
- Судалгааны зар, сурталчилгаа

1.1.7. Хувьсагчдыг тодорхойлж, төлөвлөх

Судлагдах сэдэв, үзүүлэлтууд

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны асуулга үндсэн 3 маягт (маягт-АОАБС-1-Өрхийн асуулга, маягт - АОАБС-2 - Өрхийн гишүүний асуулга, маягт-АОАБС-3-Хохирсон байдлын асуулга)-аас бүрдэнэ.

Маягт- 1: Өрхийн асуулга:

- НН1. Хаягийн хэсэг
- НН2. Өрхийн ерөнхий мэдээлэл
- НН3. Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл (оловсрол, үйлдлийн чадвар, хөдөлмөр эрхлэлт)

Маягт- 2: Өрхийн гишүүний асуулга:

- Бүлэг 1. Амьдрах орчны нөхцөл байдал
- Бүлэг 2. Иргэдийн үзэл бодол
- Бүлэг 3. Гэмт хэрэгт хохирсон байдал

Маягт- 3: Хохирсон байдлын асуулга:

- Хэсэг 1. Тээврийн хэрэгсэл хулгайлах
- Хэсэг 2. Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах
- Хэсэг 3. Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах
- Хэсэг 4. Орон байрны хулгай
- Хэсэг 5. Дээрэмдэх
- Хэсэг 6. Хулгайлах
- Хэсэг 7. Залилах
- Хэсэг 8. Хахууль
- Хэсэг 9. Хүчирхийлэл
- Хэсэг 10. Заналхийлэх
- Хэсэг 11. Мал хулгайлах
- Хэсэг 12. Цахим халдлага
- Хэсэг 13. Зам тээврийн осол
- Хэсэг 14. Ялгаварлан гадуурхалт

Хэсэг 15. Бэлгийн хучирхийлэл

Хэсэг 16. Бэлгийн дарамт учруулах

- Судалгааны мэдээллийг цуглуулахдаа таблет ашиглана.
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд гэмт хэрэг гарсан байршил, хохирсон газар, хамт байсан хүн, хэргийг үйлдсэн хэлбэр, иргэдийн итгэх итгэл, айdas зэргийг судална.
- Судалгааны мэдээлэл цуглуулалтын хүрээнд гарч болох хэрэгцээтэй бусад хувьсагчдыг тодорхойлж, тооцож ашиглана.
- Тухайн үеийн хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагаар бусад нэмэлт хувьсагчийг өгөгдлөөс гарган сэдэвчилсэн судалгаанд ашиглаж болно.

Судалгааны тов, лавлагаа хугацаа

Судалгааг 2023 оны 01 сарын 02-ноос 2024 оны 05 сарын 30-ны хооронд 21 аймаг, УБ хотын сонгогдсон 8000 өрхийг хамруулан, зохион байгуулж, үр дүнг нийтэд тархаана.

Судалгаагаар дараах гол хувьсагчдыг тодорхойлно.

- **Өрхийн асуулга:** Өрхийн гишүүдийн нас, хүйс, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, өрхийн тэргүүлэгчийн хамаарал, харьялал, суурьшлын байдал, хөгжлийн бэрхшээлийн байдал, хөдөлмөр эрхлэлтийн байдал
- **Өрхийн гишүүний асуулга:** Оршин сууж байгаа газрын бохирдол, хог, хаягдал, гэрэлтүүлэг, иргэдийн айdas, хууль дүрэм зэрчдэг хүн, бүлэглэн танхайрах, согтуу, мансуурсан хүн, замын хөдөлгөөний түгжрэл, явган хүний гарц, автобусны буудал, эзэнгүй нохой, муур, газар хөдлөлт, архи, тамхи худалдаалдаг цэг, ус сувгийн сүлжээний аюулгүй байдал, цахилгаан шугам сүлжээний аюулгүй байдал, үер усанд автах эрсдэл, хөршийн харилцаа, цагдаагийн эргүүлийн үйл ажиллагаа, гомдол мэдээллийг шийдвэрлэж байгаа байдал, иргэдийн үзэл бодол, иргэдийн хууль хяналтын байгууллагад итгэх итгэл г.м
- **Гэмт хэрэгт хохирсон байдал:** Гэмт хэрэгт хохирсон байдлыг сүүлийн 3 жил болон 12 сараар гэмт хэрэг үйлдсэн газар, байршил, үйлдэгдсэн хугацаа, гэмт хэрэг үйлдэгч хохирогчийн хамаарал болон гэмт хэргийн 16 төрлөөр тодорхойлно.
- Цуглуулсан мэдээллийн хүрээнд холбогдох бусад үзүүлэлтийг тооцож ашиглана.

1.1.8. Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 9 сарын 01-нээс 11 дүгээр сарын 10-ны дотор (ажлын 55 хоног, нийт 70 хоног)-т 21 аймаг, УБ хотын сонгогдсон 8000 өрхийг хамруулан зохион байгуулна.

Мэдээлэл цуглуулах арга

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг нүүр тулсан ярилцлагын хэлбэрээр явуулна. Өмнө дурдсанчлан судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн мэдээлэл цуглуулагч Өрхийн асуулгыг аваад дараа нь өрхийн 14, түүнээс дээш насны гишүүдээс асуулга авах зөвшөөрлийг эцэг, эх харгалзан дэмжигч, насанд хүрсэн хүнээс хүсэж, зөвшөөрсөн тохиолдолд өрхийн 14, түүнээс дээш насны гишүүнээс эхлэн өрхийн гишүүний асуулгыг авна. Эцэг, эх харгалзан дэмжигч, насанд хүрсэн хүн 14, түүнээс дээш насны гишүүнээс асуулга авахыг зөвшөөрөгүй тохиолдолд өрхийн гишүүний асуулгыг авахгүй.

Өрхийн 14, түүнээс дээш насын гишүүдээс өрхийн гишүүний асуулга авахад "Хохирсон байдал" илэрсэн бол маят АОАБС-3 буюу Хохирсон байдлыг гэмт хэргийн төрлөөр нарийвчлан асууна. Өрхийн гишүүний асуулгыг судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн 2 мэдээлэл цуглуулагч зэрэг авах бөгөөд тухайн өрхийн хувьд асуулгыг программаар нэгтгэж, кодолж судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч руу дамжуулна. Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч мэдээллийн хамралт, уялдаа холбоо, кодлолтыг хянаж, мэдээллийг YCX-ны төв серверт дамжуулна. Судалгааны мэдээлэл цуглуулагч ажил мэргэжлийн ангиллын код болон эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын кодын тохиорох сонголтоос сонгоно.

Судалгааны мэдээлэл цуглуулагч болон багийн ахлагчийг YCX-ны судалгааны нэгж арга зүй, мэргэжлийн зөвлөмжөөр ханган ажиллана.

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл

Компьютер, зөөврийн компьютер, таблет, түүнийг дагалдах хэрэгсэл (таблет гацах, царцах, цэнэг нь дууссан тохиолдолд цаасан асуулга ашиглана) багтана.

Мэдээлэл цуглуулах эрх зүйн үндэслэл, шаардлагатай баримт бичиг

Үндэслэл: "Статистикийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "м" заалт

Шаардлагатай баримт бичиг: YCX-ны даргын тушаалаар батлагдсан "Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа"-ны үзэл баримтлал, асуулга, түүнийг нөхөх заавар байна.

Судалгааны мэдээлэл цуглуулах төсөв

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь тухайн жилд судалгааг зохион байгуулахад шаардагдах төсвийн төслийг боловсруулан, YCX-ны ТГ-т хүлээлгэн өгөх бөгөөд төсвийг УИХ батлан, улсын төсвөөс бүрэн санхүүжүүлнэ.

Судалгааны мэдээлэл цуглуулах төсөв нь судалгааны зорилго болон түүврийн хүрээтэй уялдан боловсруулагдана.

Судалгааны төсвийг дараах зарцуулалтын хүрээнд тооцож боловсруулна. Үүнд:

- Судалгаанд хамрагдсан өрхөд өгөх урамшууллын зардал;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байхаар тооцсон гэрээт ажилтнуудын цалингийн зардал;
- Мэдээлэл цуглуулагчийн ажиллах байршилаас хамаарсан өдрийн хоолны мөнгө, өрхөд очих, буцах унааны мөнгө, томилолт, холбооны зардал;
- Мэдээлэл цуглуулагчийн үнэмлэх, энгэрийн зүүлтийн зардал;
- Мэдээлэл цуглуулахад шаардагдах шатахууны зардал;
- Судалгаанд сонгогдсон өрхийг олоход туслах хөтчид өгөх урамшууллын зардал;
- Мэдээлэл цуглуулах баг (ахлагч, мэдээлэл цуглуулагч)-ийг сургах сургалтын зардал (асуулгыг цаасаар нөхөх дадлага хийлгэх асуулга, нөхөх зааврыг хэвлэх зардал, бичиг хэрэг, цай, үдийн хоолны зардал, томилолт, унааны зардал);
- Мэдээллийн чанарыг анхан шатны нэгжид очиж, шалгах хяналтын ажлын зардал (томилолт, унаа, холбооны зардал);
- Судалгааны зорилго, зорилтыг олон нийтэд таниулах сурталчилгааны зардал;
- Хэвлэлтийн зардал;
- Судалгааны үр дүнгийн тайланг орчуулах, хэвлэлийн эх бэлтгүүлэх, хэвлэх,

- тархаалтын семинарыг зохион байгуулах зардал;
- Программ хангамжийг хөгжүүлэх, турших зардал;
- Шаардлагатай нэмэлт бусад зардал;
- Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсөвлөх, орон нутагт шилжүүлэх, зарцуулалтад хяналт тавих ажлыг УСХ-ны ТГ-аас хариуцан зохион байгуулна.
- Мэдээлэл цуглуулалтад хяналт, мониторинг хийх зардал

Мэдээлэл цуглуулалтад дэмжлэг үзүүлэх бусад шаардлагатай зүйлс

1. Мэдээлэл цуглуулах төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эвдэрсэн үед засварлах, солиулах арга хэмжээ авах, мэдээлэл цуглуулагчийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, сонгогдсон өрхийг олоход орон нутгийн ажилтнуудаас туслалцаа авах гэх мэт.
2. Судалгааны мэдээлэл цуглуулагчдын аюулгүй байдал, сэтгэл зүй, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтын зардал олгох.

1.1.9. Түүврийн хүрээ, дизайн

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны түүврийг үндэсний болон бүсийн, байршлын түвшинд төлөөлөх чадвартай байхаар тооцсон.

Хамрах хүрээ

Судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын нийт өрх, 14 ба түүнээс дээш насны хүн ам байна. Монгол Улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар 941.5 мянган өрхөд 14 ба түүнээс дээш насны 2.4 сая иргэн амьдарч байна. Түүврийн эх олонлог нь Монгол Улсын 2022 оны жилийн эцсийн 14 ба түүнээс дээш насны 2.4 сая хүн ам байна.

Түүврийн нэгж

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байна.

Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг, хэсэг бүлэг хүмүүс, Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл, ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Өрх нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.

Судалгаа нь өрхөд суурилсан судалгаа тул цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулахгүй. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

Судалгааны үр дүнг тархаах түвшин

Судалгааны үр дүнг үндэсний, бүсийн, байршлын хэмжээнд төлөөлөхүйц байдлаар боловсруулах зорилт тавигдсан. Иймд нарийвчлалын түвшинг нь үндэсний, бүсийн, байршлын түвшинд зөвшөөрөхүйц байхаар тооцсон.

Түүврийн хэмжээг тодорхойлох

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томьёоллын дагуу тооцно. Үүнд:

Түүврийг хэмжээг дараах үндсэн томьёогоор тооцно.

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} * deff * rr \quad (1)$$

- z = хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга
- P_0 = түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
- e = алдааны хязгаар
- $deff$ = тухайн дизайны үр ашигтай байдал /design effect/
- rr =асуулгад хариулахгүй байх байдлаар засварлагч

Дээрх томьёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлно. Үүнд:

- z — 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Өмнө нь ижил төрлийн судалгаа явж байгаагүй үед болон тодорхой төсөөлөл байхгүй үед =0.50)
- e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдааг бүсийн түвшинд 6-8 байхаар тооцсон)
- $deff$ – тооцох боломжгүй бөгөөд бид 2.0-той тэнцүү байна гэж таамагласан.
- rr – судалгаанд 10 хүн тутмын нэг буюу 10 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хариулахгүй байна гэж үзсэн. Тэгвэл rr =1.1 болно.

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг бүсийн хэмжээнд тооцож гаргасан.

Түлхүүр үзүүлэлтийн хувийг 0.5, судалгаанд хамрагдалтын хувийг 90 хувь гэж үзэн түүврийн хэмжээг бүс тус бүрийн хувьд тооцоход улсын хэмжээнд 7995 өрх гарсан.

Түүврийн хуваарилалт

Улаанбаатар хотын хувьд хороодын хэсгүүд, аймгуудын хувьд багуудыг түүврийн анхан шатны нэгж (ТАШН) гэж үзнэ. Түүврийн хамралт болон төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, алдааны магадлалыг бууруулахын тулд сонгогдсон ТАШН бүрээс 20 өрх сонгоно гэж үзэн түүврийн хэмжээг тэгшитгэсэн.

Судалгааны үр дүнг бүсийн түвшинд тархаах тул түүврийн хэмжээг бүсийн түвшинд тооцож, аймаг, дүүргийн өрхийн тооноос хамааруулан бүсийн дүнгээс аймаг, дүүргийн түүврийн хэмжээг пропорционалиар тооцсон. Мөн аймгийн хувьд түүврийн хэмжээг байршлын хувьд пропорционалиар хуваарилж түүврийн хэмжээг 8000 болгон тэгшитгэсэн.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ, бүсээр

Бүс	Өрхийн тоо (Түүврийн хэмжээ)	Түлхүүр үзүүлэлт	95%-ын итгэлцлийн түвшин дэх харьцангуй алдаа	Итгэх интервал		Стандарт алдаа
				Доод	Дээд	
Улаанбаатар	2800	0.5	0.052	0.47	0.54	0.01
Баруун	1200	0.5	0.080	0.46	0.54	0.02
Хангайн	1500	0.5	0.072	0.46	0.54	0.02
Төвийн	1500	0.5	0.072	0.46	0.54	0.02
Зүүн	1000	0.5	0.088	0.46	0.54	0.02
Нийт	8000	0.5	0.052	0.47	0.54	0.01

Хүснэгт 2. Түүврийн тэгшитгэсэн хэмжээ, аймаг, нийслэл, байршилын бүсээр (ТАШН-ээс 20 өрх)

Аймаг код	Аймаг, дүүрэг	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
11	Улаанбаатар				
01&	Багануур	140			
04&13	Багахангай				
	Налайх				
7	Баянгол	420			
10	Баянзүрх	740			
16	Сонгинохайрхан	600			
19	Сүхбаатар	260			
22	Хан-Уул	400			
25	Чингэлтэй	240			
Зүүн бүс					
21	Дорнод	200	40	120	
22	Сүхбаатар	80	100	100	
23	Хэнтий	100	100	160	
Төвийн бүс					

41	Төв	60	120	100
42	Говьсүмбэр	40		20
43	Сэлэнгэ	60	220	20
44	Дорноговь	60	120	20
45	Дархан-Уул	220	40	20
46	Өмнөговь	100	20	120
48	Дундговь	40	20	80

Хангайн бүс

61	Орхон	240		
62	Өвөрхангай	100	60	140
63	Булган	40	80	40
64	Баянхонгор	80		140
65	Архангай	40	80	120
67	Хөвсгөл	100	40	200

Баруун бүс

81	Завхан	60	40	140
82	Говь-Алтай	60	40	80
83	Баян-Өлгий	100	20	160
84	Ховд	100	40	120
85	Увс	100	40	100
	Нийт	2800	1980	1220
				2000

Судалгаанд нийт 400 ТАШН-ийг судалгаанд хамруулна.

Түүврийн жин

Үр дүнгийн тооцоо хийх, дүн шинжилгээ боловсруулахад түүврийн жинг тооцож ашиглана. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай. Үүнд:

- Кластерийн тоо;
- Сонгогдсон кластерийн өрхийн тоо;
- Сонгогдсон өрхөөс судалгаанд хамрагдах боломжтой 14 ба түүнээс дээш насны хүний тоо.

Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцно:

Нэгдүгээр шатны түүврийн жин:

$$W_{1k} = \frac{A_k}{A_{ks}}$$

A_k = k дугаар бүлгийн нийт өрхийн тоо

A_{ks} = k дугаар бүлгээс сонгогдсон s ширхэг кластерийн нийт өрхийн тоо

Хоёрдугаар шатны түүврийн жин:

$$W_{2kj} = \frac{M_{kj}}{m_{kj}}$$

M_{kj} =k бүлгийн j кластерийн нийт өрхийн тоо

m_{kj} = k бүлгийн j кластерийн судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Өрхийн түүврийн жин дээрх 2 жингийн үржвэр байна:

$$W_{kj} = \frac{A_k}{A_{ks}} \cdot \frac{M_{kj}}{m_{kj}}$$

14 ба түүнээс дээш насын хүн амын түүврийн жин нь дээрх өрхийн жинг өрхөд байгаа судалгаанд хамрагдах боломжтой 14 ба түүнээс дээш насын хүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

1.1.10. Боловсруулалт, дүн шинжилгээг төлөвлөх

Мэдээллийг цуглуулснаар судалгааны зорилгын дагуу гаргах мэдээлэлд зориулж, бодлогын даалгаврыг бэлтгэнэ. Мэдээллийг эмхэлж, цэгцэлж, нэгтгэн боловсруулахад бэлтгэнэ.

Үзүүлэлт хоорондын уялдаа, холбооны шалгалтыг гурван үе шатаар гүйцэтгэнэ. Үүнд:

Нэгдүгээрт, мэдээллийн хамралт, уялдаа холбоог шалгах

Хоёрдугаарт, тоо мэдээллийг боловсруулах

Гуравдугаарт, үр дүнг тооцож гаргах

Мэдээллийг бодлогын даалгаврын хүрээнд боловсруулсан CSPro/цахим программын дагуу шивж оруулах бөгөөд статистикийн шинжилгээний SPSS/STATA программаар боловсруулна.

Судалгааны хамрах хүрээ, зорилгоос хамаарч судалгааны мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээнд дараах ангилал, бүлэглэлтийг хэрэглэнэ. Үүнд:

A. Ангилал:

- ✓ Бүс нутгийн ангилал (Бүс нутгийн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр)
- ✓ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код;
- ✓ Монгол Улсын боловсролын түвшний ангилал, код;
- ✓ Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;
- ✓ Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал;

B. Бүлэглэлт:

- Байршилаар
- Суурьшилаар
- Бүсээр
- Хүйсээр
- Насны бүлгээр
- Гэмт хэргийн хохирогчийн шинж байдлаар
- Гэрлэлтийн байдал
- Өрхийн тэргүүлэгчийн хамаарал, харьяалал
- Хөгжлийн бэрхшээлийн байдал
- Хөдөлмөр эрхлэлтийн байдал
- Судлагдах сэдвээс шалтгаалсан бүлэглэлтээр: үйлдлийн чадамж, гэрлэлтийн байдал гэх мэт
- Амьдрах орчны нөхцөл байдал
- Иргэдийн үзэл, бодол
- Хохирсон байдлыг гэмт хэргийн төрлөөр г.м

1.2. СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (CYA)-НЫ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХ ҮЕ ШАТ

Загварчлах						
3.1 Мэдээлэл цуглуулалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх	3.2 Мэдээлэл боловсруулалтын арга зүй, систем, программ хангамжийг бүрдүүлэх	3.3 Мэдээлэл тархаалтад ашиглагдах элементүүдийг бүрдүүлэх	3.4 CYA-г загварчлах	3.5 CYA-нд ашиглагдах элементүүдийг турших	3.6 CYA-ны загварыг бухэлд нь турших	3.7 CYA-ны загварыг эцэслэх

1.2.1. Мэдээлэл цуглуулалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх

Мэдээлэл цуглуулах асуулга, асуулгын нөхөх зааврыг бэлтгэх: Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны мэдээллийг өрхийн асуулга, өрхийн гишүүний асуулга, хохирсон байдлын З бүлэг асуулгаар цуглуулна. Асуулга, нөхөх зааврыг оролцогч талууд, ажлын хэсгийн гишүүдийн оролцоотойгоор боловсруулж, YСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулж мөрдөнө. Судалгааг хариуцсан нэгж болон ажлын хэсгийн гишүүд мэдээлэл цуглуулагч болон ярилцлага өгөгчийн аюулгүй байдлыг хамгаалах зөвлөмж өгч ажиллана.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад Компьютер, зөөврийн компьютер, таблет, таблет цэнэглэгч, таблетын үзэг ашиглаж ажиллана. Таблет гацах, царцах, таблетын цэнэг нь дууссан тохиолдолд цаасан маягтаар мэдээллийг цуглуулна. Судалгааны мэдээллийн боловсруулалтад Stata/SPSS программ ашиглана.

1.2.2. Мэдээлэл боловсруулалтын арга зүй, систем, программ хангамжийг бүрдүүлэх

Энэхүү судалгааны мэдээлэл боловсруулалтын арга зүй, систем, программ хангамжийн бүрдүүлэлтийг дараах байдлаар хангана.

- Мэдээлэл цуглуулалтын явцыг хянах систем: УСХ-ны төв сервер (серверт мэдээлэл дамжуулсан байдал)
- Мэдээллийг оруулах, хүлээн авах программ хангамж: CSPro
- Мэдээллийн санд хийгдэх шалгалт, засварыг хийх программ хангамж: SPSS/STATA
- Мэдээллийг боловсруулах программ хангамж: SPSS/STATA
- Мэдээлэл дүн шинжилгээ хийх программ хангамж: SPSS/STATA

1.2.3. Мэдээлэл тархаалтад ашиглах элементүүдийг бүрдүүлэх

Мэдээлэл тархаалтад ашиглах элементүүдийг дараах байдлаар бүрдүүлнэ:

- Мета мэдээллийн сан үүсгэх аргачлалын дагуу Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа – 2023-ын холбогдох мэдээллийг www.1212.mn цахим мэдээллийн санд бэлтгэж оруулна.
- www.1212.mn цахим мэдээллийн санд оруулах хүснэгт, графикийн загварыг Excel файл дээр бэлтгэнэ.
- Судалгааны тайлангийн загварыг Word, Excel файл дээр бэлтгэж, эх бэлтгэлд шилжүүлнэ.
- Инфографикт орох хүснэгт, график, мэдээллийг Excel файл дээр бэлтгэж, эх бэлтгэлд шилжүүлнэ.
- Сурталчилгааны материалууд: Брошюр, сэдэвчилсэн танилцуулга, инфографик, дашбоард байна.
- Судалгааны үр дүнгээр контент бэлтгэн, телевиз, радио, олон нийтийн сүлжээгээр сурталчлах, тархаах

1.2.4. CYA-г загварчлах

Мэдээлэл цуглуулахаас эхлээд тархаах хүртэлх үйл ажиллагааны урсгал нь тогтсон төлөвлөлтийн дагуу хийгдэнэ.

1.2.5. CYA-нд ашиглагдах элементүүдийг турших

Мэдээлэл цуглуулахаас эхлээд мэдээлэл тархаах хүртэлх үе шатанд хэрэглэгдэж буй программ хангамж, системийг бүх дэд үе шатанд төлөвлөсний дагуу бий болгоно.

1.2.6. CYA-ны загварыг бүхэлд нь турших

CYA-ны загварын туршилтыг хийсэн байна:


- Мэдээлэл цуглуулах арга зүй болон асуулгад өөрчлөлт орсон тухай бүрд туршилтыг хийнэ. Өрхөд хийх туршилтыг хүн хүч, төсөв, хугацааг төлөвлөж, баталгаажуулна.
- АОАБС-ны туршилтын явцад гарсан хүндрэл бэрхшээл, анхаарах асуудлын талаар тайлан бичиж, баримтжуулалтыг хийнэ. Баримтжуулалт дээр үндэслэн газар, нэгжийн түвшинд хэлэлцүүлэг хийж, шаардлагатай тохиолдолд судалгааны асуулга, асуулга нөхөх заавар, мэдээлэл цуглуулалтын процессыг хянаж, сайжруулалтыг хийнэ.

1.2.7. CYA-ны загварыг эцэслэх

CYA-ны загварын дараах үйл ажиллагааг эцэслэнэ.

- CYA-ны загварын “Мэдээлэл цуглуулалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх” дэд үе шатанд хамаарах мэдээлэл цуглуулах асуулга, түүнийг нөхөх зааварт өөрчлөлт орсон тохиолдолд асуулга, асуулга нөхөх зааврыг шинэчлэн батлуулна.
- Асуулга шинэчлэгдсэн тухай бүрд мэдээлэл оруулах программ хангамжийг шинэчилнэ. Бодлогын даалгаврыг шинэчилнэ.
- Судалгааны асуулга, заавар, программ хангамж, мэдээлэл цуглуулалтад өөрчлөлт орсон тухай бүр мэдээлэл цуглуулах ажилтнуудад сургалтыг зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр ханганд ажиллана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт сургалтыг зохион байгуулна. Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд сургалтын төлөвлөгөө, илтгэлүүд, гарын авлага зэргийг бэлтгэнэ.

1.3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ҮЕ ШАТ



1.3.1. Түүврийн хүрээг бүрдүүлэх, түүвэрлэлт хийх

Монгол Улсын нийт өрх, хүн ам судалгааны түүврийн хүрээг бүрдүүлнэ. Түүврийн сонголт хийх үйл ажиллагаа нь ихэвчлэн 2 үе шаттай байна. Эхний үе шатанд Монгол Улсын бүх аймаг, дүүргийн нийт баг, хэсгийн жагсаалтаас харгалзах тооны түүврийн анхан шатны нэгж (ТАШН) буюу кластериудыг тохирох магадлалт түүврийн арга техникийг ашиглан сонголтыг хийж гүйцэтгэнэ. Энд судалгааны ТАШН-ээр аймаг, дүүргийн баг, хэсгийг сонгоно. Түүврийн хоёр дахь шатанд ТАШН-ээр сонгогдсон аймаг, дүүргийн баг, хэсгээс тодорхой тооны өрхүүдийг энгийн санамсаргүй аргаар сонгоно. Судалгаанд хамрагдах өрхийг YCX-ны судалгааны үндсэн баг Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас сар бүр түүвэрлэнэ.

Судлагдах нэгж

Судалгаа явагдах хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрийн тухайн өрхөд 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байгаа эсвэл 6 сар хүрээгүй боловч цаашид 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдрах гишүүд нь судалгааны судлагдах нэгж байна.

Дараах хүн амыг судалгаанд хамруулахгүй. Үүнд:

1. Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаадын иргэд (элчин сайдын яамд, төлөөлөгчдийн газар, олон улсын байгууллагын ажилтнууд, гэрээгээр ажиллагчид, жуулчид)
2. Хорих газарт хоригдогсод
3. Халамжийн төвүүд, асрах газарт амьдрагчид

4. Хугацаат цэргийн албан хаагчид
5. Дотуур байранд амьдардаг оюутнууд

1.3.2. Мэдээлэл цуглувалтад бэлтгэх

1. Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь уг судалгааг зохион байгуулан явуулах ба судалгааны бэлтгэл ажлыг хангах, ахлагч, мэдээлэл цуглувалгач нарт сургалт хийх, судалгааг зохион байгуулан явуулах, мэдээллийн баазыг нэгтгэн үр дүнг тооцох г.м судалгааны бүх үе шатны ажлуудыг удирдан зохион байгуулж, хянаж, гүйцэтгэнэ.
2. Судалгааны мэдээлэл цуглувалттын нэгжийн үйл ажиллагааг YСХ-ны даргын тушаалаар 2023 онд батлагдсан "Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа"-ны үзэл баримтлалын дагуу зохицуулна.

Судалгаа хариуцсан нэгж нь судалгааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох
- Судалгааг зохион байгуулж явуулах үндэслэл, хэрэгцээг тодорхойлох
- Түүврийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран төлөвлөгөөт хугацаанд түүврийн хүрээг тодорхойлсон байна.
- Судалгааны төсвийн тооцоог хийж, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- ХАӨМС хариуцсан нэгж нь түүврийн загварын дагуу өрхийн жагсаалтыг графикт хугацаанд хийж өгсөн байна.
- Судалгааны шинээр боловсруулсан үзэл баримтлал, асуулга, асуулга нөхөх зааврын төслийг YСХ-ны Арга зүйн байнгын зөвлөл, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
- Мэдээллийн оролтын программын бодлогын даалгаврыг боловсруулан, программ хангамж хариуцсан нэгжид хүлээлгэн өгөх, боловсруулсан программыг туршин, санал тусгах;
- Түүвэр хариуцсан нэгжтэй хамтран судалгааны түүврийн хэмжээ, хуваарилалтыг аймаг, дүүргээр тодорхойлох;
- Судалгааны мэдээлэл цуглувулах ажлыг зохион байгуулах талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл цуглувулах багийг чадавхжуулах;
- Мэдээлэл цуглувулах ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж, сургалтын материалыг бэлтгэж, сургалтыг зохион байгуулах зэрэг холбогдох бэлтгэл ажлуудыг хангаж ажиллана;
- Судалгааны мэдээлэл цуглувалттын үед шаардагдах шатахуун, унааны тендерийн материалыг бэлтгэн, үнэлгээний багт хүргүүлэх;
- Холбогдох дотоод ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллах

1.3.3 Мэдээлэл цуглувалттыг хэрэгжүүлэх

ХАӨМС хариуцсан нэгж нь ХАӨМС-гаас түүвэрт сонгогдсон өрхийн жагсаалтыг бэлтгэж судалгаа хариуцсан нэгжид төлөвлөгөөт хугацаанд ирүүлнэ.

Судалгаа хариуцсан нэгж нь аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэс рүү өрхийн жагсаалтыг хүргүүлж, тухайн өрх байршилдаа байгаа эсэх, өрхийн гишүүдийн утасны павлагаа, тодруулгыг мэдээлэл цуглувалттын өмнө авна.

Хэрэв үндсэн өрх тухайн байршил дээр байхгүй тохиолдолд нөөц өрхөөс мэдээллийг авна. Судалгааны нөөц өрхийг нэг нэгжид 2 нөөц өрхтэй байхаар тооцож, нөөц өрхийн жагсаалтыг бэлтгэнэ.

Нөөц өрхийг тодруулж, тодруулгын дагуу өрхийн мэдээллийг шинэчилж, жагсаалтыг бэлтгэн, эцэслэсэн өрхийн жагсаалтыг судалгааны багийн ахлагчид болон холбогдох аймаг, нийслэлийн статистикийн хэлтэст хүргүүлнэ.

Судалгааны мэдээлэл цуглуулах баг нь судалгааны 400 ТАШН-ээс мэдээллийг цуглуулна.

Судалгааны 2 мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч мэдээллийг хянаж, YСХ-ны төв серверт дамжуулна.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч мэдээллийг хянаж, YСХ-ны төв серверт дамжуулна.

1.4. МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

Загварчлах							
5.1 Мэдээл- лийг нэгтгэх	5.2 Ангилах, кодлох	5.3 Хянан баталгаа- жуулах	5.4 Засварлах, нөхөн тооцох	5.5 Шинэ хувьсагч, нэгжийг гарган авах	5.6 Жинг тооцож оруулах	5.7 Агрегат үзүүлэлтийг тооцох	5.8 Өгөгдлийн файлыг эцэслэх

1.4.1. Мэдээллийг нэгтгэх

Мэдээллийн баазыг үүсгэж, статистикийн боловсруулалтын хэрэглээний программ хангамжийн дагуу шалгах, засварлах, мэдээллийн үр дүнг нэгтгэх, боловсруулах, холбогдох үр дүнгийн хүснэгтүүдийг гаргана. Шаардлагатай тохиолдолд боловсруулалтын программд нэмэлт syntax-ыг боловсруулж, шинэчлэл хийнэ.

1.4.2. Ангилах, кодлох

Судалгааны үзүүлэлтийн ангилал, кодыг олон улсын зөвлөмж, төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодтой нийцүүлэн ашиглана. Үүнд:

- ✓ Бүс нутгийн ангилал (Бүс нутгийн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр)
- ✓ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код;
- ✓ Монгол Улсын боловсролын түвшний ангилал, код;
- ✓ Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;
- ✓ Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн ангилал;

1.4.3. Хянан баталгаажуулах

Мэдээлэл цуглуулалтыг хянан баталгаажуулах ажлыг YСХ-ны даргын тушаалаар 2023 онд батлагдсан "Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа"-ны үзэл баримтлалын дагуу зохицуулна.

Мөн Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа хариуцсан нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Хувьсагч хоорондын уялдаа холбоо, утgyн хязгаарыг мэдээлэл оруулах программд зориулсан бодлогын даалгаварт нарийвчлан тусгана.
- Нэгтгэсэн мэдээллийн баазад, үзүүлэлтүүдийн уялдаа холбоо, алдааг илрүүлэхэд syntax боловсруулан шалгана.
- Боловсруулалт хийсний дараах нэгдсэн үр дүнгээс холбогдох үзүүлэлтийг тооцон гаргаж, цаг хугацааны болон орон зайн динамик үүсгэн, харьцуулалт хийж, хэт өндөр болон бага утгыг дахин шалгана.

1.4.4. Засварлах, нөхөн тооцох

Мэдээлэлд засвар өөрчлөлт оруулах үйл ажиллагааг YСХ-ны даргын тушаалаар 2023 онд батлагдсан "Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа"-ны үзэл баримтлалын дагуу зохицуулна.

Мөн Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Мэдээллийн баазад шалгалт хийсний дараах алдаа буюу тодруулгыг эксел файлаар бэлтгэн судалгааны багийн ахлагчдад хүргүүлнэ. Шалгалт хийж буй үед багийн ахлагч зөвхөн алдаа гарсан өрхийн анхдагч мэдээллийг засварлаж, YСХ-ны серверт дахин дамжуулна.
- Тооцооны онцлогоос шалтгаалан зарим нөхөгдөөгүй хоосон үзүүлэлтэд орлуулга хийнэ.

1.4.5. Шинэ хувьсагч, нэгжийг гарган авах

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь статистикийн үйл ажиллааны үр дүн, хэрэгцээ шаардлагад үндэслэн шинэ хувьсагчийг тодорхойлж болно.

Мэдээллийн баазаас шинэ хувьсагчтай холбоотой өгөгдлийг ашиглан тооцоолол, бодолт хийж, шинэ хувьсагч үүсгэнэ.

1.4.6. Жинг тооцож оруулах

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Түүврийн жинг мэдээллийн санд оруулахдаа тухайн түүврийн нэгжийн дугаарыг түлхүүр үзүүлэлт болгож, судалгааны мэдээлэл дэх түүврийн дугаартай холбож, нэгтгэнэ.
- Судалгааны үр дүнгийн тооцоо боловсруулах, түүврийн жин, түүврийн алдаа тооцох томьёоллуудыг судалгааны түүврийн дизайны баримт бичигт тусгасан байна.

1.4.7. Нэгтгэсэн үзүүлэлтийг тооцох

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь судалгааны үр дүнг боловсруулахдаа түүврийн жин ашиглаж, эх олонлогт тархаан тооцож үзүүлэлтийг гаргана. Үүнд: судалгааны үр дүнд боловсруулалт хийх, үр дүнгийн хүснэгт тооцоход статистикийн хэрэглээний программыг ашиглана.

- Бюллетень, танилцуулгын хүснэгт
- Эмхэтгэлийн хүснэгт тооцох
- Тайлангийн хүснэгт тооцох зэрэг.

1.4.8. Өгөгдлийн файлыг эцэслэх

Судалгааг хариуцсан нэгж нь мэдээллийн санг дарааллын дагуу шалгаж, хянан баталгаажуулсны дараа нууцлалыг хангаж, эцэслэнэ:

- Мэдээллийн баазыг үүсгэхэд SPSS/STATA программ хангамжийг ашиглах бөгөөд мэдээллийг боловсруулах, анализ хийхэд SPSS/STATA программ хангамжийг ашиглана.
- Үр дүнгийн үзүүлэлт (хүснэгт)-ийг дараах түвшинд тооцно. Үүнд:
 - Улсын
 - Хот, хөдөө
 - Нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөө
 - Бүсийн түвшинд

1.5. ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Дүн шинжилгээ хийх				
6.1 Гарцын төслийг бэлтгэх	6.2 Гарцыг хянан баталгаажуулах	6.3 Гарцыг тайлбарлах	6.4 Мэдээллийн нууцлалыг хамгаалахад хяналт тавих	6.5 Гарцыг эцэслэх

1.5.1. Гарцын төслийг бэлтгэх

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь судалгааны үр дүнгээр инфографик, дашбоард, тайланд орох загварын дагуу тайлбар, текст, аргачлалын тайлбар, хүснэгт, графикуудыг бэлтгэнэ.

1.5.2. Гарцыг хянан баталгаажуулах

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг хариуцсан нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Тооцож гаргасан үр дүнгийн хүснэгтуудээс үндсэн үзүүлэлтүүдийг хянан үзэж, хэт өсөлт, бууралт, оронгийн алдаа байгаа эсэхийг мөн суурьшил, бус нутгаар зөрүүтэй үр дүн гарсан эсэхийг шалгана. Мөн гарсан үр дүнд үндэслэн, хэт ялгаатай утга гарсан эсэхийг шалгана. Шаардлагатай үед мэдээллийн санд дахин шалгалт хийж, нягтална.

- Үр дүнгийн тайлан танилцуулгыг газар, нэгжийн шат, шатны хяналтаар баталгаажуулна.

1.5.3. Гарцыг тайлбарлах

Судалгааны үр дүн, тайланда оруулдаг загварын дагуу үндсэн үзүүлэлтүүдийн ойлголт, тооцох аргачлал, гарсан үр дүнг тайлбарлах текстийг бэлтгэж, одоогийн нөхцөл байдал, ерөнхий хандлагыг тайлбарлана.

1.5.4. Мэдээллийн нууцлалыг хамгаалахад хяналт тавих

Судалгааны мэдээллийн нууцлалыг дараах хууль, журмын дагуу хамгаална.

1. Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3-т "Албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно" гэсэн заалтыг үндэслэн мэдээллийн нууцыг хадгална. Үүний дагуу хувь хүн, өрхийг таних боломжтой хувьсагчдыг микро мэдээллийн сангаас хасна.
2. YСХ-ны даргын 2019 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Мэдээллийн аюулгүй байдлын журам" болон бусад холбогдох нууцлал, аюулгүйн байдлын баримт бичгийг мөрдөнө.
3. YСХ-ны даргын тушаалаар 2023 онд батлагдсан " Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа"-ны үзэл баримтлалыг мөрдөж ажиллана.
4. Судалгаанд ажиллаж байгаа бүх шатны ажилтнууд судалгааны мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

Мэдээлэл баримт бичгийг дор дурдсан хугацаагаар хадгална.

- Асуулгыг нөхсөн маягт – үр дүнг нэгтгэн гаргаж, тархааснаас хойш 1 жил;
- Мэдээллийн үндсэн бааз, электрон хэлбэрээр – тогтмол;
- Үр дүнгийн хүснэгт, тайлан, электрон хэлбэрээр – тогтмол;
- Судалгааны датаг YСХ-ны Мэдээллийн аюулгүй байдлын журмын дагуу серверт тогтмол байршуулна.

1.5.5. Гарцыг эцэслэх

Гарцыг эцэслэхдээ гарцыг хянан баталгаажуулах, засварлах, нөхөн тооцох, мэдээллийн нууцлалыг хангах үйлдлийг бүрэн гүйцэтгэсэн эсэхийг шалгана. Гарцыг дараах дарааллын дагуу хянан, баталгаажуулснаар эцэслэнэ. Үүнд:

1. Тооцоо хийсэн мэргэжилтэн өөрөө нягтлах, харьцуулах
2. Хэлтсийн ахлах статистикч
3. Харьяалах хэлтсийн дарга
4. Харьяалах газрын дарга
5. Нэгдсэн статистикийн газрын дарга
6. Дэд дарга
7. Дарга
8. Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтэс (ХАТХ)

Дээрх 8 шалгуураар хянагдсаны дараа гарцын бүтээгдэхүүнийг тархаана.

1.6. ТАРХААХ

Тархаах				
- Гэмт хэргийн хохирогч, түүний шинж байдал, гэмт хэргийн төрлүүд, гэмт хэрэгт хохирох эрсдэл;
- Гэмт хэргийн хохирол, түүнийг барагдуулахад хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хандаж буй хандлага, иргэдийн итгэх итгэл;
- Тогтвортой хөгжлийн болон Алсын хараа-2050-ын холбогдох үзүүлэлтуудийг тооцох;
- Судалгааны үр дүнгийн тайлан боловсруулж, нийтэд тархаах;
- Статистикийн мэдээллийн нэгдсэн санг 3 жил тутам судалгааны мэдээллээр баяжуулах;
- Өрх, хувь хүний нууцлал хангасан мэдээллийн баазыг нийт хэрэглэгч ашиглах боломж бүрдүүлэх;

- Бодлого боловсруулагч болон хэрэглэгчид, бусад оролцогч талуудыг хэрэгцээтэй мэдээллээр хангах

Судалгааны ач холбогдол: Энэхүү судалгаа нь зөвхөн хохирогчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх, хохирогчийн хохирлыг хэрхэн барагдуулах вэ гэхээс гадна тухайн улс оронд хүний эрх ямар хэмжээнд хамгаалагдаж байдгийг илтгэдгээрээ олон улсад өндөр ач холбогдолтойд тооцогддог судалгаа юм.

Судалгааны түүврийн хүрээ, дизайн: Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа нь ерхөд суурилсан судалгаа бөгөөд мэдээлэл цуглуулах түүврийн анхдагч нэгж нь ерх байна.

Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны түүврийг үндэсний болон бүсийн, түвшинд төлөөлөх чадвартай байхаар тооцсон. Судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын нийт өрх, 14 ба түүнээс дээш насны хүн ам байна. Монгол Улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар 941.5 мянган өрхөд 14 ба түүнээс дээш насны 2.4 сая иргэн амьдарч байна. Түүврийн эх олонлог нь Монгол Улсын 2022 оны жилийн эцсийн 14 ба түүнээс дээш насны 2.4 сая хүн ам байна.

Судалгааны зохион байгуулалт: Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2023 оны 9 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 10-ны дотор түүвэрт сонгогдсон 8000 өрхийг хамруулан зохион байгуулж явуулна.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад 20 багийн ахлагч, 40 мэдээлэл цуглуулагчийг хуанлийн 70 хоногийн хугацаанд ажиллуулна.

Судалгааны асуулга, нөхөх заавраар 7 хоногийн сургалт явуулж, дадлага хийлгэнэ.

Мэдээлэл цуглуулалтад 20 баг ажиллах бөгөөд баг бүр 5 хүний бурэлдэхүүнтэй байна. Нэг багт 2 мэдээлэл цуглуулагч, 1 ахлагч, 1 хөтөч, 1 жолооч байна.

Багийн ахлагч, мэдээлэл цуглуулагч тус бүрийн хүлээх үүрэг, гүйцэтгэх ажлын хувьд ялгаатай байх бөгөөд энэ талаар дараагийн бүлэгт авч үзнэ.

БҮЛЭГ 1. БАГИЙН АХЛАГЧ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧИЙН ҮҮРЭГ, ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, АНХААРАХ ЗҮЙЛ

1.1. АХЛАГЧ, ХЯНАГЧ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Судалгааны мэдээлэл цуглуулагч нь мэдээлэл цуглуулалтад гол үүрэгтэй бөгөөд судалгааны эцсийн үр дүнд мэдээлэл цуглуулалтын чанар шууд нөлөөлнө.

Судалгааны мэдээллийн чанарыг сайжруулахад мэдээлэл цуглуулагч болон ахлагчдыг хамруулсан сургалтын чанар чухал нөлөөтэй. Ахлагч болон мэдээлэл цуглуулагчид нь судалгааны бүх асуулгын агуулга, уялдаа, холбоо, ойлголт, нөхөх зарчим, ангилал, кодлолтын талаар бүрэн ойлголттой болж, асуулга нөхөх мэдээлэл өгөгчтэй харилцах чадварыг бүрэн эзэмшсэн байна.

Мэдээлэл цуглуулалтын чанарт ахлагч/хянагч, мэдээлэл цуглуулагчийн ажлын арга барил, чадвар, хариуцлага, харьцаа, хандлага маш чухал бөгөөд ахлагч, мэдээлэл цуглуулагчид нь тус тусдаа өөрсдийн хийж гүйцэтгэх ажил үүргийн хуваарьтай ажиллана. Үүнд:

Багийн ахлагч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

- Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мөнгө, техник хэрэгсэл болон бусад материалыг судалгааны багаас хүлээн авч, зааврын дагуу зарцуулж, тайлагнах;
- Мэдээлэл цуглуулах багийн гишүүдтэй танилцаж, өөрийн болон багийн гишүүдийн ажил, хувийн бэлтгэлийг сайтар хангуулж, хуваарилагдсан аймаг, сумтай холбоотой шаардагдах мэдээллийг авах;
- Орон нутгийн удирдлагуудад судалгааны зорилго, ач холбогдлыг танилцуулж, дэмжлэг авч, судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Өөрийн багт хуваарилагдсан ярилцлага авах өрхийн жагсаалт, тухайн газар нутгийн байдалтай сайтар танилцаж, багийн мэдээлэл цуглуулах ерөнхий маршрутыг гаргах;
- Багийн гишүүдтэй нягт холбоотой ажиллаж, ажлын чиглэлийг тодорхойлж өгөх;
- Түүвэрлэгдсэн нэгж, судалгаанд хамрагдах өрхийг олоход туслах;
- Судлаачийн ажлыг тэгш хуваарилах;
- “Багийн ахлагчийн хяналтын хуудас”-ыг тухай бүр хөтөлж, хуваарьт ажлууд хэрхэн хийгдэж байгаад тогтмол хяналт тавих;
- Нөхөгдсөн асуулгын мэдээллийг өдөр бүр судлаачаас хүлээн авч, уялдаа холбоо, зөв нөхөгдсөн байдлыг шалгана. Буруу нөхөгдсөн тохиолдолд эргэж тодруулгыг газар дээр нь хийх;
- Мэдээлэл цуглуулагчтай нягт холбоотой ажиллаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;
- Хуваарилсан өрхийг олох, асуулгын агуулгыг ойлгох, харилцаад бэрхшээлтэй ярилцлага өгөгчтэй хэрхэн харьцах гэх мэт гарсан бэрхшээлийг шийдвэрлэхэд туслах;
- Судлаач нартай орой бүр тогтмол ярилцаж, өдрийн ярилцлага авах явцад тулгарсан аливаа бэрхшээлийн талаар заавар, зөвлөгөө өгөх;
- Асуудал гарсан үед судалгааг хариуцсан нэгжид мэдээлж, зөвлөлдөх, багийн ажлын явц, байрлалыг байнга мэдээлж байх;

- Багийн унаа автомашиныг хариуцаж, зөвхөн судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ашиглахад хяналт тавих;
- Бүрэн гүйцэд нөхөгдсөн асуулгын мэдээллийг өгөгдсөн зааврын дагуу эмхлэн цэгцэлж, судалгааны багт графикт хугацаанд нь хүргүүлэх;
- Багт эерэг уур амьсгал бий болгох, багийн гишүүдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- YCX-ны судалгаа хариуцсан ажилтнаас ирүүлсэн тодруулгын дагуу өгөгдөл, мэдээллийг мэдээлэл цуглуулагчаар шалгуулж, шаардлагатай бол өрхөөс дахин тодруулж, тайлбар, засварыг хийлгэх;
- Холбогдох санхүүгийн баримтыг хянах, баталгаажуулах;
- Бүрэн гүйцэд нөхөгдсөн асуулгын хуудсыг өгөгдсөн журмын дагуу мэдээллийн баазад хянаж, YCX-ны төв серверт графикт хугацаанд нь хүргүүлэх;
- Мэдээлэл цуглуулалтын явц, хяналт шалгалт хэрхэн хийсэн болон шалгалтын ажлын баримтжуулалтыг албажуулан тайландаа тусган 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор YCX-ны судалгаа хариуцсан нэгжид цахимаар ирүүлэх.

Мэдээлэл цуглуулагч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- Түүврийн дагуу сонгогдсон өрхүүдээр очиж, судалгааны зорилго, ач холбогдлын талаар тодорхой тайлбарлаж, асуулгын дагуу мэдээлэл цуглуулах;
- Өрхийн 14, түүнээс дээш насны гишүүдээс гишүүний асуулгыг авна. Өрхийн асуулгыг авсны дараа өрхийн 14-17 настай хүүхдийн тоог тодорхойлж, эцэг, эх асран хамгаалагчдаас нь зөвшөөрөл авсны үндсэн дээр зөвшөөрсэн тохиолдолд гишүүний асуулгыг асууна.
- Асуулгыг авахдаа эцэг, эх асран хамгаалагч нь зөвшөөрсэн тохиолдолд эхлээд 14-17 настай хүүхдүүдээс асуулгаа авч, дараа нь насанд хүрэгчдээс асуулгыг авна.
- Ярилцлага бүрийн дараа асуулгын бүх асуултыг асуусан, үнэн, зөв нөхсөн эсэхээ шалгах;
- Тодорхой шалтгаанаар эхний болон хоёр дахь удаагийн очилтоор ярилцлага авч чадаагүй бол эргэж очиж асуулгыг авна;
- Ярилцлага өгөгч асуултад анхаарлаа хандуулж, зөв мэдээлэл өгч буй эсэхийг нягтлах;
- Тохиолдсон аливаа бэрхшээл, асуудлын талаар тэмдэглэл хөтлөн, багийн ахлагчид танилцуулж, заавар, зөвлөгөө авах;
- Цаасаар авсан судалгааны материалыг шивж оруулах, хянуулах;
- Цуглуулсан мэдээллийн үзүүлэлт тус бүрээр нэг бүрчлэн шалгаж нягтлан, үзүүлэлтийн уялдаа холбоог зааврын дагуу шалгах;
- Судалгааны санхүүгийн баримтыг бүрдүүлэх;
- Судалгааны мэдээлэл цуглуулалтад зориулан олгосон таблетыг ариг гамтай хэрэглэх;
- Судалгаанд хамрагдсан өрхөд урамшууллыг тогтоосон хэмжээгээр олгох, гарын үсэг зуруулж баталгаажуулах;
- Судалгааны өрхийн асуулгагд тусгагдсан засаг захиргаа, нутаг дэвсгэр, ажил мэргэжил, үйл ажиллагааны чиглэлийн дагуу зөв кодлох;

Мэдээлэл цуглуулагчийн ажлын хуваарь:

- Мэдээлэл цуглуулагч нар сургалтад хамрагдсаны дараа сонгогдсон өрхүүдэд очиж багийн ахлагчийн зааврын дагуу ажиллана.
- Судалгааны мэдээлэл цуглуулалтын 1 баг нь хуанлийн 70 хоногийн хугацаанд 200 өрхөөс мэдээлэл цуглуулна.

1.2. ЯРИЛЦЛАГА АВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Мэдээлэл цуглуулагчийн үндсэн үүргийн нэг нь ярилцлага өгөгчтэй тааламжтай холбоо тогтоож, итгэл найдвар төрүүлэх явдал юм.

Ярилцлага өгөгчид таны талаар төрсөн анхны сэтгэгдэл нь судалгаанд оролцох эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө. Тиймээс гадаад үзэмж байдал чинь хүний нүдэнд дулаан, аятайхан байх, энгийн, цэвэрхэн төлөв хувцаслаж, өөрийгөө нөхөрсөг дулаан өнгө аясаар танилцуулахад анхаарах хэрэгтэй.

Ярилцлага өгөгчтэй уулзахдаа эхлээд өөрийнхөө нэрийг хэлж, ямар байгууллагаас явж байгаа, судалгааны зорилго юу болох, ярилцлага өгөгчөөс юу хүсэж байгаа, хувь хүний мэдээллийн нууцыг хадгалах зэргийг тодорхой танилцуулна. Судалгаатай холбоогүй асуудлаар удаан ярилцаж, цаг үрэхээс зайлсхийх хэрэгтэй.

Ярилцлага өгөгчтэй танилцсаны дараа асууж байгаа зүйлээ ойлгуулахын тулд асуултаа аажуухан бөгөөд тодорхой хэлж асууна. Асуултаа тавьсны дараа түр чимээгүй болж, ярилцлага өгөгчид бодох хугацаа олгох хэрэгтэй. Хэрэв ярилцлага өгөгчийг яруулах, бодол санаагаа төвлөрүүлэх боломж олгохгүй бол “мэдэхгүй” хэмээн хариулах, эсвэл бодит бус байдлаар хариулах магадлал их байна гэдгийг анхаарах шаардлагатай.

Асуулгын агуулга, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог судлах, зарим эзээгтэй асуулгын хариултыг хэрхэн авах талаар зөвлөгөөг багийн ахлагч болон судалгааны асуудал хариуцсан нэгжээс зөвлөмж авч болно. Та энэхүү зааврын бүлэг тус бүрийг маш анхааралтай судалж, тодорхой хугацааны дадлага хийвэл судалгааны асуулгын хариултыг үнэн зөв авахад хялбар болно.

Мэдээлэл цуглуулагч асуулгыг авахдаа зааврыг баримтална.

“Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажлыг судалгаанд сонгогдсон аймаг, нийслэл, сумд судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч хариуцаж зохион байгуулна.

- Судалгааны зорилго болон асуулга бүрийг тодорхой ойлгож байгаа эсэхийг нягтлах шаардлагатай. Энэ нь авч буй хариулт чинь хангалттай эсэхийг мэдэхэд туслах болно.
- Асуултыг асуулгад байгаа дарааллын дагуу асууна. Асуултын дарааллыг өөрчилж болохгүй.
- Асуултыг бүрэн асуух хэрэгтэй. Асуулгаас юуг ч орхиж, гээгдүүлж болохгүй. Мөн асуултын хариултад өөрийнхөө санааг тусгаж болохгүй бөгөөд хэдийгээр танд хариулт нь тодорхой юм шиг санагдавч асуултыг асууж хариултыг авна. Таны санаснаас өөрөөр хариулт өгч болно.
- Ярилцлага өгөгч хоёр асуултын хариултыг нэг дор өгсөн ч, бүх асуултыг нэг бүрчлэн тус тусад нь асууна. Бүх асуултыг нэг бүрчлэн асуух ёстой гэдгээ тайлбарлаж болно, эсвэл “Зөв санаж байгаа эсэхээ нягтлахын тулд...” гээд асуултаа лавлан асууж болно.

- Ярилцлага өгөгчид аль болох эвтэй байдал бүрдүүлэхийг хичээх хэрэгтэй ч асуултынхаа хариултыг өөрөө санал болгож болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Алгасвал зохих асуултаас бусад асуултад хариулт авахгүйгээр орхиж болохгүй. Нөхөгдөөгүй асуулт дараа нь хүндрэл учруулах бөгөөд таныг энэ асуултыг асуухаа мартаж орхисон мэт харагдуулна. Зарим асуултын хувьд “Мэдэхгүй” гэсэн хариултын код өгөгдсөн байгаа бөгөөд ярилцлага өгөгч мэдэхгүй байгаа тохиолдолд энэ хариултыг дугуйлж болно. Хариултын жагсаалтад “Мэдэхгүй” гэсэн хариулт өгөгдөөгүй асуултын хувьд ярилцлага өгөгчөөс хариултыг заавал авна. Зарим онцгой тохиолдолд хариулт авах боломжгүй бол энэ талаар асуулгадаа тэмдэглэх шаардлагатай.
- Ярилцлага өгөгч хариултыг өгсөн дор нь тэмдэглэж авах шаардлагатай.
- Тухайн айлаас гарахын өмнө асуултгыг зөв нөхсөн эсэхээ шалгаж, шаардлагатай тохиолдолд зарим тодруултгыг хийх хэрэгтэй.
- Ярилцлага дууссаны дараа ярилцлага өгөгчид цаг гарган, хамтран ажилласанд талархлаа илэрхийлнэ. Ярилцлага өгөгч хэдий найрсаг нөхөрсөг байж, таныг тухлахыг урьсан ч айлд удахаас зайлсхийх нь чухал юм.
- Ярилцлагын төгсгөлд өрхийн урамшууллыг өгч, гарын үсэг зуруулж баримтыг баталгаажуулна. Мөн санхүүгийн баримтад регистрийн дугаарыг бичнэ.

Анхнаасаа сайхан сэтгэгдэл төрүүл

Ярилцлага өгөгч таны талаарх анхны сэтгэгдлийг гадаад төрх байдлаас чинь олж авна. Таны хувцаслалт тань ярилцлагыг амжилттай явуулж чадах эсэхэд тань нөлөөлж болох учраас зохимжтой цэвэрхэн бөгөөд энгийн байдлаар хувцаслана. Ярилцлага өгөгчтэй анх уулзаж ярилцахдаа тухайн хүнд эвтэй бөгөөд аятайхан сэтгэгдэл төрүүлэх нь чухал. Та оновчтой цөөн үгээр ярилцлага өгөгчид ярилцлагын талаар зөв сэтгэгдэл төрүүлж, оюун санааг нь бэлдэж чадна. Инээмсэглэж, мэндлээд, өөрийгөө танилцуулж эхлээрэй.

Ярилцлага өгөгчид итгэл төрүүл

Ярилцлага өгөгчийн гэрт очихдоо цай, хоолны цаг зэрэг тохиромжгүй үеэр очихоос зайлсхийх нь чухал юм. Асуултад хариулах цаг зав гаргаж болохуйц үеэр очихыг хичээх хэрэгтэй.

Өөрийгөө танилцуулж үнэмлэхээ үзүүлсний дараа судалгааны зорилго болон тухайн өрхөд амьдардаг 14, түүнээс дээш насны гишүүдээс ганцаарчилсан ярилцлага авах талаар болон нууцыг хэрхэн хадгалах талаар тайлбарлаж өгнө.

Үргэлж эерэг хандлагатай байх

Үргэлж эерэг хандлагатай байх хэрэгтэй. Гэхдээ хүлцэл өчсөн хандлагатай байж болохгүй. “Та маш завгүй байна уу?” зэрэг үгсийг хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Ингэж асууснаар та шууд л татгалзсан хариу сонсох болно. Харин үүний оронд ярилцлага өгөгчид “Би танаас хэдэн асуулт асуух гэсэн юм” гэж хэлж болно.

Мэдээллийн нууцыг чандлан хадгална гэдгийг онцлон ойлгуулах

Ярилцлага өгөгчийн өгсөн мэдээлэл болон хийсэн үйл ажиллагааны нууцыг чандлан хадгална гэдгийг байнга онцлон тайлбарлах хэрэгтэй. Цуглуванс мэдээлэлд ямар ч тохиолдолд хувь хүний нэрийг хэрэглэхгүй бөгөөд бүх өрх, хүмүүсийн мэдээллийг нэгтгэн дүгнэж бүсийн болон улсын хэмжээгээр үр дүнг

тооцож гаргана гэдгийг тайлбарлана. Ярилцлага өгөгч болон бусад хүмүүсийн дэргэд бусад мэдээлэл цуглуулагч эсвэл багийн ахлагчтай ярилцлагын талаар хэлэлцэх, асуултгыг унших зэрэг үйлдэл хийж болохгүй. Энэ нь ярилцлага өгөгчийн танд итгэсэн итгэлийг шууд үгүй болгож, дараа дараагийн судалгааны мэдээлэл цуглуулалтанд сөргөөр нөлөөлнө.

Хангалттай хариулт авахын тулд тодруулж асуух:

Мэдээлэл цуглуулагч нь асуултыг асуулгад байгаагаар нь асууна. Хэрэв хариулт нь бусад хариулттай уялдахгүй, тохиорхгүй байвал уг асуултад үнэн зөв бөгөөд бүрэн хариулт авахын тулд ярилцлага өгөгчид шууд бус асуулт тавих, нэмэлт асуулт асуух замаар тодруулах шаардлагатай. Энэ үйл явц нь лавлан тодруулах ажил юм. Тодруулах зорилгоор тавьж буй асуулт нь төвийг сахисан байх ёстой бөгөөд ярилцлага өгөгчийг аль нэг зүйт чиглүүлэн залсан өнгө аясгүй байх ёстой. Эхний тавьсан асуултын утга санааг өөрчлөхгүй байхад анхаарах нь чухал юм.

Ярилцлага өгөгчид хүндрэлтэй өмнө хохирсон байдлаа санахыг хичээж байгаа бол түр хугацаа өгч, хүлээх хэрэгтэй. Шаардлагатай бол ярилцлага өгөгчөөс хариултаа тодруулж өгөхийг хүсэж болно. Та хариултыг буруу ойлгосон ч байж болно.

Ярилцлага өгөгчийн асуусан зүйлд хариулахад анхаарах зүйл:

Ярилцлага өгөх эсэх талаар шийдэхээсээ өмнө ярилцлага өгөгч судалгааны талаар, яагаад өөрийг нь судалгаанд хамруулахаар сонгосон болох, судалгаа өөрт нь ямар үр дүнтэй, ашигтай байх зэрэг янз бүрийн асуултыг танд тавьж магадгүй. Ярилцлага хэр удаан үргэлжлэх талаар ч асууж болох юм.

Судалгаанд хамрагдах өрхүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр санамсаргүйгээр сонгосон бөгөөд судалгааны үр дүнг улсын хэмжээнд бодлого, хөтөлбөрийг үнэлэх болон боловсруулахад ашиглана гэдгийг хэлэх шаардлагатай. Мөн асуулга авахад ямар хугацаа шаардлагатай болохыг хэлнэ.

Эргэлзэж байгаа ярилцлага өгөгчтэй харьцах

Ярилцлага өгөгч зүгээр л “Мэдэхгүй” гэж хэлэх, холбогдолгүй хариулт өгөх, залхсан байдалтай үйлдэл хийх эсвэл өмнөх хариултуудтайгаа зөрчилдсөн хариулт өгөх тохиолдлууд гарч болно. Ийм тохиолдолд асуултдаа аль болох сонирхлыг нь хандуулахыг хичээгээрэй. Хэдэн минут ярианыхаа сэдвийг өөрчилж, ярилцлагатай холбоогүй (амьдарч буй газрынх нь тухай, цаг агаар, өдөр тутмын аж амьдралын талаар зэрэг) өөр сэдвээр ярилцаад үзээрэй.

Анхаарах асуудал:

1. Эргэлзээтэй болон буруу, алдаатай хариултын холбогдох асуултгын ард зохих тэмдэглэлийг хийж, эргэж шалгах шаардлагатай.
2. Мэдээлэл цуглуулагч асуултгыг бүрэн авч, шалгаж дууссаны дараа асуулга авч дууссан хугацааг тэмдэглэнэ.
3. Судалгааны ахлагч уг асуултгыг хүлээн авч, хянаж дууссаны дараа нэр, гарын үсгээ зурна. Асуултгыг хянаж, холбогдох засварыг бүрэн хийх шаардлагатай.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР

Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны асуулга нь үндсэн 3 маягт (Маягт-АОАБС-1-Өрхийн асуулга, маягт - АОАБС-2 - Өрхийн гишүүний асуулга, Маягт-АОАБС-3- Хохирсон байдлын асуулга)-аас бүрдэнэ.

Маягт-АОАБС-1: Өрхийн асуулга:

НН1. Хаягийн хэсэг

НН2. Өрхийн ерөнхий мэдээлэл

НН3. Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл (боловсрол, үйлдлийн чадвар, хөдөлмөр эрхлэлт)

Маягт-АОАБС-2: Өрхийн гишүүний асуулга:

Бүлэг 1. Амьдрах орчны нөхцөл байдал

Бүлэг 2. Иргэдийн үзэл бодол

Бүлэг 3. Гэмт хэрэгт хохирсон байдал

Маягт-АОАБС-3: Хохирсон байдлын асуулга:

Хэсэг 1. Тээврийн хэрэгсэл хулгайлах

Хэсэг 2. Тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах

Хэсэг 3. Унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах

Хэсэг 4. Орон байрны хулгай

Хэсэг 5. Дээрэмдэх

Хэсэг 6. Хулгайлах

Хэсэг 7. Залилах

Хэсэг 8. Хахууль

Хэсэг 9. Хүчирхийлэл

Хэсэг 10. Заналхийлэх

Хэсэг 11. Мал хулгайлах

Хэсэг 12. Цахим халдлага

Хэсэг 13. Зам тээврийн осол

Хэсэг 14. Ялгаварлан гадуурхалт

Хэсэг 15. Бэлгийн хүчирхийлэл

Хэсэг 16. Бэлгийн дарамт учруулах

2.1. ӨРХИЙН АСУУЛГЫГ НӨХӨХ ЗААВАР (МАЯГТ-АОАБС-1)

Өрхийн асуултын зорилго нь өрх, хүн ам болон өрхийн сууц, ахуй нөхцөлийн талаарх ерөнхий мэдээллийг цуглуулахад оршино.

Энэ бүлэгт судалгаанд хамрагдаж буй өрхийн хаяг, өрхийн тэргүүлэгчийн нэр, өрхийн ам бүлийн тоо болон тухайн өрхөд б, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байгаа эсвэл б сар хүрээгүй боловч цаашид б, түүнээс дээш сарын хугацаагаар амьдрах гишүүдийн мэдээллүүдийг асууна.

2.1.1. ХАЯГИЙН ХЭСЭГ (НН)

Өрхийн хаягийн хэсэг нь 18 асуулгатай (НН1.01-НН1.18).

(НН1.01) Өрхийн бүртгэлийн дугаар

Өрхийн бүртгэлийн дугаарыг Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас өрхийн дугаарыг авч нөхнө.

(НН1.02) Түүврийн нэгжийн дугаар

Түүврийн нэгжийн дугаарыг багийн ахлагчид тусгайлан өгөх тул ахлагчийнхаа зааврын дагуу түүвэрлэгдсэн нэгжийн дугаарыг нөхнө.

(НН1.03) Өрхийн дугаар

Ахлагчийнхаа зааврын дагуу өрхийн дугаарыг нөхнө. Нэг түүвэрлэгдсэн нэгжид адилхан өрхийн дугаар байж болохгүй. Өрхийн дугаар нэг оронтой байвал 2 оронтой болгож урд нь “0”-ийг заавал бичнэ. Жишээ нь: өрхийн дугаар 8 байвал “08” гэж нөхнө.

(НН1.04-НН1.07) Аймаг/Нийслэл, сум/дүүрэг, баг/хороо, хэсгийн нэр, код

Тухайн аймаг, сум, багийн нэрийг бичиж, кодыг энэ зааврын “Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хэсгийн код” хавсралтаас харж нөхнө. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хэсгийн нэрийг бичихдээз код тавих зориулалтын дөрвөлжин нүдний өмнө давхардуулахгүйгээр бичнэ.

(НН1.08) Байршил

Тухайн өрхийн мэдээллийг цуглуулах үед оршин сууж байгаа байршлыг нь Нийслэл “1”, Аймгийн төв “2”, Сумын төв “3”, Хөдөө “4” гэж ангилан холбогдох кодыг дугуйлна. Тосгоныг сумд хамруулна.

(НН1.09) Хаяг

Тухайн өрхийн байр, хашаа, хаалганы дугаар болон өвөлжөө, хаваржaa, намаржааны нэрийг дэлгэрэнгүй бичнэ.

(НН1.10) Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр

Тухайн судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчийн нэрийг асууж овог, бүтэн нэрийг бичнэ. Өөрөөр хэлбэл, өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн 1 дүгээр мөрөнд бичигдсэн хүний нэрийг Багана “НН3.01”-оос харж нөхнө.

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь тухайн өрхөд байнга оршин суудаг бөгөөд өрхийн бусад гишүүдийн зүгээс түүнийг өрхийн тэргүүлэгч хэмээн хүлээн зөвшөөрсөн хүн байх ёстой. Өрхийн тэргүүлэгч нь тодорхойгүй нөхцөлд өрхийн тэргүүлэгчээр хэнийг сонгохыг өрхийн гишүүдийн сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгч 16, түүнээс дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүнийг тодорхойлж болно.

(НН1.11) Өрхийн ам бүлийн тоо

Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн Багана “НН3.01”-д бүртгэгдсэн өрхийн гишүүдийг тоолж нийт тоог бичнэ. Өөрөөр хэлбэл, энэ нь өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн хамгийн сүүлийн мөрөнд бичигдсэн өрхийн гишүүнийг бүртгэсэн мөрийн дугаартай ижил байна. Өрхийн ам бүлийн тоонд шилжүүлгээ хийгээгүй ч өрхөд 183 хоногоос дээш хугацаанд амьдарч байгаа өрхийн гишүүнийг хамруулна. Харин өрхөөс гадуур байгаа гишүүдийг судалгаанд хамруулахгүй .

(НН1.12) Өрхийн 14, түүнээс дээш настай гишүүний тоо

Тухайн өрхийн 14, түүнээс дээш насны гишүүдийн тоо буюу өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн Багана “НН3.16”-д “тийм” буюу “1” гэж хариулсан өрхийн

гишүүдийг тоолж нийт тоог бичнэ. Эдгээр гишүүд нь “Өрхийн гишүүний асуулга”, “Хохирсон байдлын асуулга”-д хариулбал зохих хүмүүс юм.

(НН1.13) Утасны дугаар

Тухайн өрхийн ярилцлага өгч байгаа хүний утасны 2 дугаарыг тэмдэглэнэ. Хэрэв ярилцлага өгөгчийн 2 дугаарыг тэмдэглэх боломжгүй тохиолдолд өрхийн бусад гишүүдийн холбогдох утасны дугаарыг тэмдэглэж болно.

(НН1.14) Мэдээлэл цуглуулагчийн нэр, дугаар

Өөрийн нэр болон УСХ-ны судалгааг зохион байгуулж байгаа багаас танд өгсөн дугаарыг нөхнө. Танд өгсөн дугаар 3 оронтой байвал 4 оронтой болгож өмнө нь заавал “0”-ийг бичнэ. Жишээ нь: мэдээлэл цуглуулагч Г.Доржийн дугаар 102 бол өөрийн нэрийг бичиж, үүний ард өөрийн дугаарыг “0102” гэж нөхнө.

(НН1.15) Ахлагчийн нэр, дугаар

Мэдээлэл цуглуулагч энэ зайлт хоосон орхино. Нөхөгдсөн асуултын хуудсыг багийн ахлагч шалгаж өөрийн нэр, дугаарыг нөхнө.

(НН1.16) Өрхийн түүврийн сонголт

Тухайн сонгогдсон өрх хамрагдсан бол “1” кодыг, сонгогдсон өрх нь хамрагдаагүй хаяган дээр өөр өрхийг хамруулсан бол “2” кодыг, хэрэв хаяган дээр ямар ч өрх байхгүй бол хуваарилсан нөөц өрхөөс сонгож “3” кодыг дугуйлна.

(НН1.17) Үр дүнгийн хэсэг

Мэдээлэл цуглуулагч нь судалгаа авахаар тухайн сонгогдсон өрхөд заавал очсон байх ёстой бөгөөд судалгаа авахаар очиход тухайн өрхөд асуултад хариулах хүн байхгүй, өрхийн гишүүд түр хугацаагаар эзгүй байсан, хойшлуулсан зэрэг шалтгаанаар өрхөд дахин очих хэрэгтэй.

Ярилцлагын үр дүнг дараах байдлаар ойлгож нөхнө.

- Хэрэв өрхийн асуултгыг бүрэн гүйцэд нөхсөн бол “Бүрэн” буюу “1” кодыг
- Хэрэв өрхөд хэд хэдэн удаа очсон ч ярилцлага өгөх чадвартай 14, түүнээс дээш насны гишүүд эзгүй байсан эсвэл ярилцлага өгөх өрхийн гишүүд байгаагүй бол “Өрхийн гишүүд эзгүй” буюу “2” кодыг
- Хэрэв өрхөд хэд хэдэн удаа очсон ч ярилцлага өгөх чадвартай 14, түүнээс дээш насны ярилцлага өгөх өрхийн гишүүд байгаагүй бол “Хариулт өгөх хүн байгаагүй” буюу “3” кодыг
- Хэрэв өрхөд хэд хэдэн удаа очсон ч тухайн өрх, сууц эзэнгүй байсан бол “Өрх түр эзгүй байсан” буюу “4” кодыг
- Хэрэв тухайн өрх ярилцлага өгөхөөс татгалзсан бол “Татгалзсан” буюу “5” кодыг
- Хэрэв өрх тухайн газар нутаг, засаг захэргааны нэгжид амьдардаггүй нь тодорхой болсон тохиолдолд “Өрхийг олоогүй” буюу “6” кодыг
- Харин өрхийн асуулга буюу Маягт-АОАБС-1-ийг бусад шалтгаанаар авч эсвэл дуусгаж чадаагүй бол өгөгдсөн зайд шалтгааныг бичиж, “Бусад” буюу “7” кодыг тус дугуйлна.

(НН1.18) Байршил

Өрхийн асуулга эхлэхэд байршилийн цэг авч, ярилцлага эхэлсэн цагийг тэмдэглэнэ. Ярилцлага дууссан цагийг өрхийн асуулга асууж, дууссаны дараагаар тэмдэглэнэ.

2.1.2. ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Асуулгын зөвшөөрлийн хуудас

Сайн байна уу? Миний нэргэдэг. Би Үндэсний статистикийн хорооноос судалгааны мэдээлэл цуглуулах ажлаар явж байна. Манай байгууллага энэ онд "**АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**"-ын талаарх судалгааг Монгол улсад анх удаа хуулийн дагуу зохион байгуулж байна. Танай өрх энэхүү судалгаанд мэдээлэл өгөхөөр сонгогдсон байна. Бид энэхүү судалгааг явуулснаар Монгол хүний аюулгүй амьдрах нөхцөлийг сайжруулахад тодорхой хувь нэмрээ оруулах ач холбогдолтой.

Бид таны өгсөн мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль"-ийн 5-р зүйлийн 1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгалах болно. Та ярилцлагыг зогсоох эсвэл хариулахыг хүсэхгүй байгаа бол надад хэлээрэй. Бид таны хариултыг зөв, буруу гэж шүүхгүй учир та санаа зоволгүйгээр бидний асуултад хариулаарай. Зарим нэг сэдвүүд ярилцахад хэцүү байж болох ч таны өгсөн мэдээлэл Монгол Улсын иргэдийн сайн сайханд чиглэсэн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Ярилцлага ойролцоогоор 45 минут үргэлжилнэ. Та ярилцахыг зөвшөөрч байна уу? гэж асууна.

- "Ярилцлага өгөхийг зөвшөөрөхгүй" бол "1",
- "Ярилцлага өгөхийг зөвшөөрвэл" бол "2" байна.

Ярилцлага өгөхийг зөвшөөрөөгүй буюу "1" гэсэн кодыг сонгосон тохиолдолд ярилцлагын үр дүн НН1.17-д шилжинэ.

Ярилцлага өгөхийг зөвшөөрсөн буюу "2" гэсэн кодыг сонгосон тохиолдолд асуулга цааш үргэлжилнэ.

Өрхийн ерөнхий мэдээллийн хэсэг нь 8 асуулгатай (НН2.01-НН2.08).

(НН2.01) Танай өрхийн амьдарч буй сууцны төрөл юу вэ?

Судалгаа авч байх үеэр тухайн өрхийн амьдарч байгаа бүх төрлийн орон байрыг, тухайлбал бүх төрлийн байшин, гэр, цаатны урц, оюутан сурагчид, ажиллагчдын дотуур байр болон нийтийн байр, бусад төрлийн орон байрны хэсгийг хамааруулна. Сууц нь хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус байж болно. Албан ажлын, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн гэх мэт зориулалтаар баригдсан боловч хүмүүс оршин сууж, амьдрахаар засварлаж, тохижуулсан барилга байшин, хүн амьдрал суухад ашиглаж байгаа бүх төрлийн орон байр, оромжийг сууцанд оруулна. Тухайн өрхийн амьдарч буй сууцны төрлийг дараах байдлаар ойлгож хариултын кодыг сонгоно.

Сууцны төрлүүд:

Гэр "01"- Бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг хамааруулна.

Орон сууцны байшин "2" - бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд

зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:

- (а) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй;
- (б) Сууцны дотор бие засах газартай;
- (в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- (г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх өрөө, эсвэл талбайтай байна.

Бие даасан тохилог сууц “3” - нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон, эсвэл инженерийн шугам сүлжээний холболт болон оролт нь бие даасан бөгөөд дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохэрын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татуургатай) байна. Үүнд:

- а) Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй;
- б) Орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамааруулна.
- в) Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно.

Сууцны тусдаа байшин “4” - гэдэгт ихэвчлэн гэр хорооллын хашаанд 1, түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад) “5” - ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Бүх шатны сургуулийн оюутан, сурагчдын дотуур байр, түүнтэй адилтгах бусад нийтийн байрыг хэлнэ.

- Ажиллагчдын нийтийн байр аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид хамтран буюу ганц нэгээрээ суухад зориулагдсан нийтийн байрыг хэлнэ.

- Нийтийн зориулалтын бусад байр гэдэгт амралтын газар, рашаан сувилал, эмнэлэг, асрамжийн газар, широн, цэргийн хуаран зэрэг хүмүүс бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ суух нийтийн байрыг хамааруулна. Амралтын газар гэж хот, суурин газар болон түүнээс гадагш байрласан, амралт, чөлөөт цаг өнгөрөөх хэрэгслээр тоноглогдсон үзвэр, үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг; рашаан сувиллын газар гэж эмчилгээний техник хэрэгслээр тоноглогдсон газрыг ойлгоно. Зочид буудал гэж хот, бусад суурин газарт байрласан зочид, үйлчилүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг; орон сууцны зочид буудал гэж нийтийн орон сууцанд байрласан зочид үйлчилүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг газрыг; түр хоноглох байр гэж авто буудал, дэн буудлын болон түүнтэй төстэй бусад үйл ажиллагаа явуулдаг газрыг тус тус ойлгоно.

Зориулалтын бус сууц “6” - анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан, гэхдээ судалгааны үед хүн амьдарч байгаа сууц багтана. Энэ нь сургууль, үйлдвэр, албан газар, байгууллагын хэсэг буюу өрөө тасалгаанд (зориулалтаараа аж ахуйн нэгж, байгууллага

байрлахад зориулагдсан) өрх айл, хүн ам амьдарч байвал зориулалтын бус сууц гэж үзнэ. Жишээлбэл, вагончик, амбаар, пин, агуулах, дэлгүүр, мухлаг зэрэгт өрх айл, хүн амьдарч байгаа бол зориулалтын бус сууц гэж үзнэ.

Бусад сууц “7” - судалгааны үед хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох, хүн амьдрахад тохөромжгүй байр, талбайг бусад төрөлд хамааруулна. Эдгээрт байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээний худаг (траншей), ой мод, уул хад, агуй зэрэг орно.

(НН.2.02) Та сууцныхаа эзэмшлийн хэлбэрийг хэлнэ үү. Хэрэв бусдын өмч бол тодруулж асуух: Танайх энэ сууцандaa түрээсээр суудаг уу?

Өөрийн эзэмшлийн “1”- тухайн өрх сууцаа хувьчилж авсан болон худалдаж авсан эсвэл өөрөө барьсан хувийн өмчийн сууцыг ойлгоно.

Бусдын сууцанд:

Түрээсэлж суудаг “2”- төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцыг түрээслэн амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг ойлгоно.

Түрээсгүй суудаг “3”- төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагын эсвэл бусдын хувийн өмчийн сууцанд түрээсийн хөлс төлөхгүйгээр амьдарч байгаа өрх, хүн амын сууцыг ойлгоно. Сууц ашиглалттай холбоотой төлж буй зардлыг түрээс гэж үзэхгүй.

(НН.2.03) Танай сууцны халаалтын үндсэн эх үүсвэр юу вэ? Энэ асуултаар сууцны халаалт, түүнд ашиглаж буй эрчим хүчний эх үүсвэрийн талаарх мэдээллийг цуглуулна. Сууцыг дулаан байлгах зориулалттай халаалтын системийн төрөл энд хамаарах бөгөөд байрыг бүхэлд нь халаах зориулалттай дулааны төвлөрсөн систем, нам даралтын зуух, пийшин, ердийн зуух болон бусад төрлийн халаагч байж болно. Сууцны дулааны буюу халаалтын үндсэн эх үүсвэрийн талаар асууж тохирох кодыг дугуйлна.

Төвлөрсөн халаалт “1” - Улсын болон тухайн орон нутгийн хувьд дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзнэ.

Цахилгаан халаагуур “2” - Тухайн өрхийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаах төхөөрөмжийг үүнд хамааруулна.

Нам даралтын зуух “3” - Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын сүлжээнд ашиглаж буй бага оврын зуухыг үүнд оруулна.

Сайжруулсан зуух “4” – Агаарын бохирдлыг бууруулах зорилготой төслөөр олгосон зуух буюу дээрээсээ галладаг зуухыг хэлнэ.

Энгийн зуух/пийшин “5” - Энгийнээр галлаж, халаадаг зуух, пийшинтэй бол энд хамаарна.

Бусад “6” - Хариултад тохирох сонголт байхгүй бол нөхнө.

Халаалтын эх үүсвэр байхгүй “7” – Ямар ч халаалтын эх үүсвэргүй бол сонгоно.

(НН2.04) Танай үндны усны эх үүсвэр хаана байдаг вэ? Хүн амын үндны цэвэр усны эх үүсвэрийг тодорхойлоход энэхүү асуултыг ашиглана. Үндны усаа хэд хэдэн

эх үүсвэрээс авдаг бол гол төлөв ямар эх үүсвэрээс авдгийг нь тодруулж, тохирох хариултыг сонгоно. Хэрэв тодорхой биш бол ундын усанд ихэвчлэн явдаг өрхийн гишүүнээс ус авдаг газрыг нь тодруулж асууна.

Тухайн өрхийн усны эх үүсвэр нь өөрийн сууцанд байдаг бол “1” кодыг сонгоно. Харин хашаанд байдаг бол “2”, өөр газарт байдаг бол “3” кодыг сонгоод дараагийн асуултад шилжинэ.

(НН2.05) Танайх ямар бие засах газар ашигладаг вэ? Тухайн өрхийн хэрэглэдэг ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн нөхцөлийг тодорхойлоход уг асуултыг ашиглана. Ашигладаг бие засах газрын төрлийг тодруулан, тохирох кодыг сонгоно.

Төвлөрсөн системд холбогдсон “1”- Хүний ялгадас, бохир ус зэргийг цуглуулан, гадагшлуулах, татан зайлцуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам хоолойн системд холбогдсон бие засах газрыг хамруулна. Энэ систем нь бохирыг цуглуулах, шахуургадах, ариутгах, ялгадас бохирыг устгах зориулалттай байгууламжуудаас бүрдэнэ.

Соруулдаг бохир усны цооногтой “2”- Жорлон болон гэрээс хол, газар дор байрлуулсан, ус нэвтэрдэггүй ялгадас, бохирыг хуримтлуулах савтай бохирын хоолойгоор холбогдсон бие засах газрыг ойлгоно. Хуримтлагдсан бохирыг зөөж халдвартгүйжүүлэн цэвэрлэнэ.

Битүү тунгаагууртай “3”- Бохэр усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохэр уснаас ялгах тунгаагуурыг хэлнэ. Тунасан лагийг үе үе юулж цэвэрлэнэ. /Орчин үеийн технологийн дэвшилийг ашиглан стандартын дагуу хийгдсэн, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж/

Бусад “4”- Бие засах газар сууцны дотор байрладаг боловч дээрх төрлүүдээс өөр бие засах газартайг ойлгоно.

Энгийн нүхэн жорлон “5”- Газарт ухсан нүхэнд ялгадас хуримтлагддаг бөгөөд гадаргын ус орохоос сэргийлсэн, тавцан суурь нь газраас дээш өндөрлөгдсөн нүхэн жорлонг ойлгоно. Энгийн нүхэн жорлон нь суултууртай, эсвэл суухад зориулагдсан тавцантай байна.

Сайжруулсан нүхэн жорлон “6”- Дээвэр дээрээ агааржуулах хоолой, эсвэл яндантай, хоолой болон яндангийн амсрыг ялаа, шавж орохоос хамгаалан тороор тагласан, газар ухаж хавтангаар доторлосон, суудалд тааруулж гаргасан нүхтэй, гадаргын ус орохоос хамгаалж бүх талаас нь хаалт хийсэн жорлонг ойлгоно. Мөн хагас нэвчилттэй жорлон болон нэвчилтгүй жорлонг мөн сайжруулсан нүхэн жорлонд авч үзнэ (Дотор талыг харанхуй байлгадаг).

Био жорлон ‘7’ - Нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногооны хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй бордоо хийх хуурай бие засах газрыг оруулна. Энд зөөж авч явдаг болон суурин зориулалттай аль алиныг хамруулна.

Ил задгай / тогтсон газар байхгүй “8” - Тавцан, гишгүүр, суултуургүй, ялгадас хуримтлуулах энгийн ухсан нүхийг хамруулна. (халхавчтай)

(НН2.06) Танайх ахуйн бохир усaa яаж зайлцуулдаг вэ? Ахуйн бохир ус гэдэгт бие засах газрын бохироос бусад ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус орно. Жишээ нь

усанд орох, нүүр гар, хувцас, аяга, таваг угаах гэх мэт. Дараах хариултаас тохирохыг дугуйлна.

Төвлөрсөн шугамаар “1” - Ахуйн хэрэглээнээс гарсан бохэр усыг гадагшлуулах, цуглуулах, татан зайлцуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж.

Бохир усны цооногоор “2” - Хүчитгэсэн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй, бохир усыг цуглуулан автомашинаар соруулж, зөөвөрлөх боломжтой байгууламж (ханаар бохир ус хөрсөнд нэвчихгүй).

Угаадасны нүхэнд “3” - Хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлцуулах, шаардлага хангасан хийц бүхий байгууламж.

Ил задгай “4” - Ямар нэгэн байгууламж, цооног байхгүй, ухсан нүхгүй задгай асгадаг бол энд орно.

Бусад “5” - Хариултын сонголтод дурдагдаагүй бусад газарт муу усаа зайлцуулдаг тохиолдолд бусад гэсэн хариултыг сонгоно.

(НН2.07) Танайх хатуу хог, хаягдлаа яаж зайлцуулдаг вэ?

Үйлчилгээний байгууллагаар “1” - Улсын болон тухайн орон нутгийн албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллага эсвэл бусадтай (хог ачигчтай) гэрээ хийж, хог, хаягдлыг тогтмол болон тогтсон хугацаагүй ачиж зайлцуулдаг тохиолдлыг хамааруулна. Жишээлбэл, хот, суурин газрын гол төлөв угсармал орон сууцны орц бүрд байдаг хог зайлцуулах зориулалтын хоолой эсвэл сууцны гадна байрладаг хогийн цэгээр зайлцуулдаг тохиолдлыг ойлгоно.

Зөвшөөрөгдсөн цэгт “2”- Албан ёсны тохижилт, үйлчилгээний байгууллагын зааварчилгаагаар эсвэл албан зохицуулалтгүйгээр оршин суугчид хогоо нийтийн хогийн газар болон тодорхой төвлөрсөн цэгт зайлцуулдаг тохиолдлыг хамааруулна.

Тогтсон газар байхгүй “3” - Тухайн өрх айл хог зайлцуулах тодорхой газаргүй, хогоо ил задгай хаядаг, булдаг, шатаадаг тохиолдлыг ойлгоно.

Бусад “4”- Хариултын сонголтод дурдагдаагүй бусад газарт хог хаягдлаа зайлцуулдаг тохиолдолд бусад гэсэн хариултыг сонгоно.

НН2.08. Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн сарын дундаж орлого хэд байсан бэ? (Цалин, тэтгэвэр, тэтгэмж болон бусад орлого)

Ярилцлага өгөгчөөс сүүлийн 12 сарын өрхийн сарын дундаж орлогын хэмжээг өгөгдсөн интервалаас сонгохоор асууна.

2.1.3. ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээллийн хэсэг нь 30 асуулттай (НН3.01-НН3.30).

Өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл хуудсанд “МД” буюу Мөрийн дугаар байгааг анхаарна уу. Энэ багана дугаарлагдсан байгаа тул та ямар нэг зүйл бичих шаардлагагүй. Харин тухайн өрхийн гишүүдийн талаар холбогдох мэдээллийг арын багануудад нөхнө. Өрхийн гишүүдийг бурдгэсэн мөрийн дугаар маш чухал юм. Учир нь энэ жагсаалтад бичигдсэн өрхийн гишүүд мөрийн дугаараар дугаарлагдах болно гэдгийг анхаараарай.

(НН3.01) Өрхийн тэргүүлэгчээс эхлэн өрхийн бүх гишүүдийн овог, нэрийг хэлнэ үү. Өрхөд байнга амьдардаг хүн бүрийн овог нэрийг өрхийн тэргүүлэгчээс эхлэн бичнэ. Асуултуудыг асуухад өрхийн гишүүдийн овог нэрийг ашиглах тул өрхийн бүх гишүүний овог нэрийг тэмдэглэж авах нь чухал юм. 1-р мөрөнд зөвхөн өрхийн тэргүүлэгчийн овог нэрийг бичнэ.

(НН3.02) [Нэр] нь өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ?

Мэдээлэл цуглуулагч нь өрхийн гишүүдийн нэrsийн дарааллаар тухайн гишүүн нь өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг асууна. Жагсаалтад бичигдсэн өрхийн гишүүн бүрийг өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болохыг дараах кодыг ашиглан нөхнө. Үүнд:

Өрхийн тэргүүлэгч “01” - Өрхийн тэргүүлэгч нь тодорхойгүй нөхцөлд өрхийн тэргүүлэгчээр хэнийг сонгохыг өрхийн гишүүдийн сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүлэгчид 16-аас дээш настай, хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүнийг тодорхойлж болно. Ингэхдээ өрхийн 16 нас хүрсэн гишүүдийн саналыг харгалзах хэрэгтэй.

Эхнэр/ нөхөр “02” - Гэрлэсэн буюу хамтран амьдарч буй харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг;

Хүү/ охин “03” – Төрсөн болон өргөмөл, дагавар хүү, охиныг;

Эцэг/ эх “04” – Төрсөн болон өргөж авсан болон хойд эцэг, эхийг;

Aх/ эгч/ дүү “05”- Төрсөн болон хойд эцэг, эхийн хүүхэд, өргөмөл ах, эгч, дүүг;

Хадам эцэг/ эх “06” - Өрхийн тэргүүлэгчийн эхнэр/ нөхрийн төрсөн, өргөж авсан болон хойд эцэг, эхийг;

Хүргэн/ бэр “07”- Төрсөн болон өргөмөл, дагавар охины нөхөр, хүүгийн эхнэр;

Өвөг эцэг/ эмэг эх “08” - Өрхийн тэргүүлэгчийн эмээ, өвөөг;

Ач/ зээ/ гуч “09” – Төрсөн болон өргөмөл, дагавар хүү эсвэл охины хүүхдийг;

Бусад төрөл төрөгсөд “10” - Өрхийн тэргүүлэгчийн болон түүний эхнэр/ нөхрийн авга, нагац хамаатнууд, тэдгээрийн эхнэр/ нөхөр, хүүхэд, ах, эгч, дүү, эмээ, өвөөг;

Хамааралгүй “11” - Өрхийн тэргүүлэгчтэй ураг төрлийн болон гэр бүлийн ямар нэг хамааралгүй, тусдаа өрх үүсгээгүй хүмүүсийг хамааруулна.

(НН3.03) [Нэр]-ын/ийн хүйс: Энэ асуултад бүх хүн заавал хариулсан байх ёстойг анхаарах хэрэгтэй.

Эрэгтэй бол “1” кодыг, харин эмэгтэй бол “2” кодыг бичнэ. Өрхийн гишүүний нэр, өмссөн хувцсаар нь хүйсийг нь тодорхойлж таамгаар нөхөж болохгүй. Энэ баганын мэдээллийг бэглөхгүй, хоосон орхиж болохгүй. Бусад буюу “3” гэдэгт **ЛГБТ** буюу гуравдагч хүйсийг хамааруулна.

ЛГБТ гэдэг нь эмэгтэй ижил хүйстэн хүмүүс (лесби, Lesbian), эрэгтэй ижил хүйстэн хүмүүс (гей, Gay), эр эм хүйсийн аль алинд нь татагддаг хүмүүс (бисексуал, Bisexuality), трансжендер буюу хүйсийн баримжааг илэрхийлсэн (Transgender) утга бүхий угнүүдийн эхний үсгийг аван холбосон хэллэг юм.

(НН3.04) [Нэр]-ын/ийн төрсөн он, сар, өдрийг хэлнэ үү: Өрхийн гишүүдийн төрсөн он, сар, өдрийг ярилцлага өгөгчийн хэлснээр нь тэмдэглэж авна. Гэхдээ иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гадаад паспорт, оршин суух үнэмлэх, бусад бичиг баримт бичигтэй зөрүүлэхгүй байхыг сануулах хэрэгтэй. Ярилцлага өгөгч өөрийнхөө болон өрхийн бусад гишүүдийн төрсөн он, сар, өдрийг сайн мэдэхгүй эргэлзсэн тохиолдолд өөрийнх нь зөвшөөрснөөр иргэний үнэмлэх, гадаад паспорт, төрсний гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийг үзэж болно.

1-9 дүгээр сарыг тэмдэглэхдээ өмнө нь “0”-ийг нөхнө. Жишээ нь: 7 дугаар сард төрсөн бол “07” гэж нөхнө. Хэрэв ярилцлага өгөгч төрсөн сар эсвэл өдрийг мэдэхгүй бол “Мэдэхгүй” буюу “98” гэж нөхнө. Тухайн хүний төрсөн оныг нөхөх хэрэгтэй.

(НН3.05) [Нэр] хэдэн настай вэ? (Бүтэн насаар бичнэ): Хүн бүрийн насыг бүтэн насаар буюу төрсөн он, сар, өдрөөр нь гүйцэд тодорхойлж бичнэ. Тухайн хүний бүтэн нас гүйцэхэд хэдхэн хоног дутуу байлаа ч насыг дэвшиүүлж болохгүй. Өөрөөр хэлбэл, хамгийн сүүлийн төрсөн өдрөөрөө хэдэн нас хүрснээр нь тэмдэглэнэ. Нэг нас хүрээгүй хүүхдийн насыг “00” гэж нөхнө. Харин 95, түүнээс дээш настай хүний хувьд насыг “95” гэж нөхнө.

Жишээ нь: 2023 оны 9 дүгээр сарын 25-нд ярилцлага авч байвал 1966 оны 12 дугаар сарын 10-нд төрсөн хүний насыг “56” гэж нөхнө. 5 сартай нялх хүүхэд нэг бүтэн ой хүрээгүй учир түүний насыг “00” гэж нөхнө. 1923 онд төрсөн хүний (99 настай) насыг “95” гэж нөхнө.

(НН3.06) [Нэр] нь аль улсын харьят вэ? Энэ асуулт нь тухайн хариулагчийн үндсэн харьяаллыг тодорхойлох зорилготой бөгөөд асуултын хариултыг өрхийн гишүүдийн өөрсдийнх нь хариулснаар сонгоно. Монгол улсын харьят бүх хүний хувьд “Монгол улсын иргэн” буюу “01” кодыг, харин Монголоос бусад улсын харьят бол “02” кодыг бичнэ. Зөвхөн монгол хэлээр мэдээллийг цуглуулна.

Эцэг, эх нь хоёр өөр улсын харьят бол 16-аас дээш настай иргэн эцэг, эхийнхээ харьяатын алиныг нь дагахаа өөрсдөө шийдвэрлэнэ. Харин 16-аас доош настай бол эцэг, эхийнх нь саналыг үндэслэнэ. Хэрэв эцэг, эхийнх нь санал зөрвөл эхийнх нь харьяаллыг дагуулна.

Аль ч улсын харьяалалгүй хүмүүсийг “Харьяалалгүй” буюу “03” кодыг бичнэ.

(НН3.07) [Нэр] нь одоогийн амьдарч буй аймаг/нийслэлдээ төрснөөсөө хойш амьдарч байна уу?, шилжиж ирсэн үү? Хэрэв код “01” гэж хариулсан бол НН3.09-рүү шилжинэ.

Төрснөөсөө хойш буюу “01” гэдэгт төрснөөс хойш одоогийн байнга оршин суугаа газраасаа өөр аймаг, нийслэлд 6 сар (183 хоног) ба түүнээс дээш хугацаагаар оршин сууж, ажиллаж, суралцаж, цэргийн алба хааж байгаагүй уугуул иргэдийг хамааруулна. Хэрэв “01” гэж хариулсан бол НН3.09-р асуулт руу шилжинэ.

Өөр газар байнга амьдарч байгаад буцаж ирсэн буюу “02” гэдэгт одоогийн байнга оршин суугаа газартай төрж өссөн хэдий ч уг газраас өөр аймаг, нийслэлд 6 сар (183 хоног)-аас дээш хугацаагаар оршин сууж, ажиллаж, цэргийн алба хааж, суралцаж байгаад төрсөн нутагтаа эргэж ирсэн иргэдийг хамааруулна.

Өөр газраас шилжиж ирсэн буюу “03” гэдэгт судалгааг авах үед байнга оршин суугаа аймаг, нийслэлээс өөр газар төрсөн хүнийг хамааруулна. Гэхдээ “шилжиж ирсэн” гэсэн ойлголтод заавал албан ёсоор шилжин ирснийг бус, тухайн аймаг,

нийслэлд хэдийнээс ирж суурьшсан болохыг асууж байгаа гэдгийг тайлбарлах хэрэгтэй.

(НН3.08) Та одоогийн оршин сууж буй газартаа хэр удаан амьдарч байна вэ?

Өөр газраас шилжиж ирсэн бол одоогийн оршин сууж байгаа газартаа хэдэн жил хэдэн сар амьдарч байгааг бичнэ. Хэрэв 1 жил хүрэхгүй хугацаанд бол хэдэн сар амьдарч байгааг тодруулан асууж бичнэ.

(НН3.09) [Нэр]-ыг/ийг 15, түүнээс дээш настай эсэхийг шалгана уу.

Гэрлэлтийн байдал, Хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаарх асуултыг 15, түүнээс дээш насны өрхийн гишүүдээс асуух тул насны шалгалтыг хийж байгаа болно.

(НН3.10) [Нэр]-ын/ийн гэрлэлтийн байдлыг хэлнэ үү. Энэ асуултыг өрхийн 15 ба түүнээс дээш насны бүх гишүүдээс асууна. Гэр бүлийн тухай хуулиар 18 нас хүрсэн хүн гэрлэх боловч амьдрал дээр 15-аас доош насны хүүхэд, залуус батлуулаагүй гэр бүлтэй байх тохиолдол цөөнгүй байдаг. Мэдээлэл цуглувлагч нь 18 нас хүрээгүй хүмүүсээс ялангуяа 15-17 настай хүүхдүүдээс энэ асуултыг маш болгоомжтой, тэднийг ичээж, эвгүй байдалд оруулахгүй байдлаар эвтэйхэн асуух хэрэгтэй.

Огт гэрлээгүй ‘01’: 15 ба түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамааруулна

Гэрлэсэн - Батлуулсан “02”: Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүрдгүүлсэн гэрлэлтийн баталгаатай хүнийг хамааруулна.

Гэрлэсэн - Батлуулаагүй “03”: Хэдийгээр гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүрдгүүлж, гэр бүлээ албан ёсоор батлуулаагүй хүнийг хамааруулна.

Тусгаарласан “04”: Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа хүнийг хамруулна. Гэхдээ албан ажлын улмаас 2 тусдаа амьдарч байгаа хүнийг оруулахгүй.

Цуцалсан “05”: Гэр бүлээ албан ёсоор цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр хамааруулна.

Бэлэвсэн “06”: Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр энд хамааруулна.

(НН3.11) [Нэр] нь сүүлийн 12 сард ямар нэг цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлсэн үү?

Энэ асуулт нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн цалин хөлс, орлого олох зорилготой ажил хийсэн хүмүүсийг тодорхойлох зорилготой асуулт ба хариулагчаас сайтар асууж, Тийм бол “1” кодыг бичээд дараагийн асуулт руу шилжинэ, Үгүй бол “2” кодыг бичиж НН3.15-р асуулт руу шилжинэ.

(НН3.12) [Нэр] сүүлийн 12 сард ямар ажил эрхэлсэн бэ?

Энэ асуултыг сүүлийн 12 сард хөдөлмөр эрхэлсэн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал буюу статусыг тодорхойлох зорилготой.

Хэрэв өрхийн гишүүн давхар ажил эрхэлсэн бол үндсэн ажил эрхлэлтийг тэмдэглэнэ. **Үндсэн ажил** гэдэг нь хамгийн их цаг, хугацаа зарцуулдаг ажлыг ойлгоно.

Эхний баганад хийсэн ажлын нэрийг тодорхой бичих ба 2-р баганад ажил мэргэжлийн ангиллын кодыг 4 оронтойгоор нөхнө. (Ажил, мэргэжлийн ангиллын кодыг энэхүү зааварт хавсралтаар оруулсан байгаа болно.)

(НН3.13) [Нэр] нь сүүлийн 12 сард ямар салбарт ажилласан бэ?

Эрхэлж байгаа ажил нь эдийн засгийн аль салбарт хамаарахыг асууж, холбогдох кодыг ашиглан хариултыг бичнэ. Эхний баганад ажилласан салбарын нэрийг, дараагийн баганад эдийн засгийн салбарын 4 оронтой кодыг бичнэ.

Хэрэв өрхийн гишүүн давхар ажил эрхэлсэн бол үндсэн ажил эрхлэлтийг тэмдэглэнэ. **Үндсэн ажил** гэдэг нь хамгийн их цаг, хугацаа зарцуулдаг ажлыг ойлгоно.

(НН3.14) [Нэр] -ын/ийн сүүлийн 12 сард ажилласан байгууллагын хариуцлагын хэлбэр юу вэ?

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч “1”
- Компани “2”
- Хоршоо “3” - нийгэм, эдийн засаг, соёлын нийтлэг хэрэгцээ, хүсэл эрмэлзлээ хангахын тулд гишүүд нь өмчилдөг, хянадаг, удирддаг гишүүн төвтэй байгууллага юм.
- Нөхөрлөл “4”- гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг хэлнэ.
- ТӨҮГ, ОНӨҮГ “5”- Төрийн өмчит үйлдвэрийн газар “ТӨҮГ”- дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар “ОНӨҮГ”
- Төрийн байгууллага “6”
- Төрийн бус байгууллага “7”

Бусад “8” - дээр дурдагдаагүй ажилласан байгууллагын хариуцлагын хэлбэр хэлж байгаа тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

(НН3.15) [Нэр]-ыг/ийг 14, түүнээс дээш настай эсэхийг шалгана уу.

Боловсрол, үйлдлийн чадварын асуулт болон Маягт АОБС- 2 буюу “Өрхийн гишүүний асуулга”-ыг 14, түүнээс дээш насны өрхийн гишүүдээс асуух тул насны шалгалтыг хийж байгаа болно.

БОЛОВСРОЛ

(НН3.16) [Нэр] нь сургуульд сурдаг уу? Судалгаа явагдаж байх үеийн хичээлийн жилд албан ёсны боловсрол олгох сургуульд суралцаж байгаа бол Тийм буюу “1” кодыг, суралцаад төгссөн, урьд өмнө нь сургуульд сурч байгаад завсардсан, сургуулиас чөлөө авсан болон огт суралцаагүй бол Үгүй буюу “2” кодыг бичнэ. Хэрэв Үгүй буюу “2” гэсэн бол НН3.18-р асуулт руу шилжинэ.

Ямар нэг шатны боловсрол олгодоггүй албан бус боловсролын сургалт болон алсын зайн сургалтад хамрагдагчдыг сургуульд сурдаггүйд тооцно.

Албан бус боловсролын сургалт гэж сургуулиас гадуурх зохион байгуулалттай сургалтын үйл ажиллагааг хэлэх бөгөөд үүнд, төрөл бүрийн мэргэжил олгох (жолооны, гадаад хэлний, тогоочийн, компьютерын гэх мэт) болон амьдрах ухаанд сургах (ногоо тарих, алт мөнгөний дархан зэрэг) сургалтыг хамааруулна.

(НН3.17) [Нэр] нь ямар түвшний сургуульд сурч байгаа вэ? Хэрэв ерөнхий боловсролын сургуульд сурдаг бол “01”, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сурдаг бол “02”, Бакалавр, магистр, докторын зэрэг олгох их дээд сургуульд сурдаг бол “03” гэж нөхнө.

(НН3.18) [Нэр] нь эзэмшсэн боловсролынхoo дээд түвшинг хэлнэ үү. Өрхөд байгаа 14, түүнээс дээш настай гишүүдийн эзэмшсэн боловсролын дээд түвшинг өрхийн гишүүн нэг бүрчлэн тодруулж асуугаад тохирох кодыг нөхөж бичнэ.

Боловсролгүй “01”: Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангид одоо сурч байгаа, дээрх хүснэгтэд тэмдэглэсний дагуу харгалзах антиудад сурч байгаад сургуулиа орхисон хүнийг боловсрол эзэмшээгүй хүнд хамааруулна.

Бүрэн дунд хүртэлх боловсролын түвшинг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Бүрэн дунд хүртэлх боловсролын түвшин

	Боловсролгүй “01”	Бага “02”	Суурь (Бүрэн бус дунд) “03”	Бүрэн дунд “04”
1975 хүртэлх онуудад	4-р ангийг төгсөөгүй	4-р анги төгссөн	7-р анги төгссөн	10-р анги төгссөн
1975-1996 онуудад	3-р ангийг төгсөөгүй	3-р анги төгссөн	8-р анги төгссөн	10-р анги төгссөн
1997-2004 онуудад	4-р ангийг төгсөөгүй	4-р анги төгссөн	8-р анги төгссөн	10-р анги төгссөн
2005 онд	5-р төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	10-р анги төгссөн
2006-2014 онуудад	5-р ангийг төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	11-р анги төгссөн
2015 ба түүнээс хойш онуудад	5-р ангийг төгсөөгүй	5-р анги төгссөн	9-р анги төгссөн	12-р анги төгссөн

Техникийн болон мэргэжлийн “05”: Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

Тусгай мэргэжлийн дунд “06”: Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.

Дээд “07”: Дипломын болон бакалаврын дээд боловсрол, магистр, доктор цолтой бол энд хамааруулна.

Дипломын болон бакалаврын дээд боловсрол: Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120 багц цагаас доошгүй байна. Түүнчлэн улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүнийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

Магистр: Дээд боловсрол эзэмшсэний дээр гадаад, дотоодод магистрын болон түүнээс дээш зэрэг хамгаалсан, зохих баримт бичиг бүхий хүмүүсийг хамруулна. Магистрын сургалт 150 багц цагаас доошгүй байна.

Доктор: Дээд боловсрол эзэмшсэний дээр гадаад, дотоодод докторын зэрэг хамгаалсан, зохих баримт бичиг бүхий хүмүүсийг хамруулна. Докторын сургалт 210 багц цагаас доошгүй байна.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

(НН3.19-НН3.29)-р асуултууд нь тухайн судалгаанд хамрагдагчдын хувьд эрүүл мэндийн бэрхшээлүүд байдаг эсэхийг тодорхойлох асуултууд юм. Эдгээр асуултууд нь судалгаанд хамрагдагчдын үйлдлийн чадамжийг асууж байгаа бөгөөд аливаа үйл ажиллагаанд оролцоход тохиолдож буй бэрхшээлийг тодруулна. Эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан бэрхшээл нь бусад шалтгаанаас илүүтэйгээр нөлөөлдөг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж төрөлхийн болон олдмол шалтгаанаар бие эрхтний үйл ажиллагаа, анатомийн бүтэц, бие махбод, сэтгэц, мэдрэхүйн болон оюун ухааны эмгэг өөрчлөлт нь удаан хугацаагаар үргэлжлэх хандлагатай байгаа нь зүй ёсоор тогтоогдсон, энэхүү өөрчлөлт нь өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны чадавхад нь удаан хугацаагаар ноцтой нөлөөлсөн хүнийг хэлнэ. Өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа гэдэгт биеийн хөдөлгөөн, гарын хөдөлгөөний эсвэл, биеийн тэнцвэр, өтгөн/шингэний зохицуулга, юмыг дээш өргөх, зөөж явжч явах, ярих сонсох, харах, санах, анхаарлаа төвлөрүүлэх, ойлгох, аюулаас биеэ хамгаалах мэдрэмж гэх мэт үйлдлүүд багтана.

Эрүүл мэнд гэж өвчин, амь нас, биеийн үйл ажиллагааны тогтвортой байдал зэргийн хүрээнд бие махбод болон оюун ухааны хувьд хүний ерөнхий байдлыг хэлнэ. Эрүүл мэндийн асуудал гэж хариулагчийн зүгээс бие махбод, оюун ухаан, сэтгэл хөдлөлийн хувьд сайн сайхан байдал буурч байгаа гэж үзэх байдлыг хэлнэ. Үүнд аливаа өвчин, эд эрхтэн дутуу байх болон биеийн болон сэтгэлзүйн чадавх алдагдсан байх нөхцөл байдлууд багтана. Мөн энэ тодорхойлолтод эрүүл мэндтэй холбоотой гэж үзэн насны доройтол, гүн сэтгэл гутрал, биеийн хөгжлийн болон сэтгэн бodoх чадварын хоцрогдол, аливаа бодисоос хамааралтай байх, ослын гэмтэл гэх мэт хэвийн бус байдал багтана.

Асуултуудыг асуухаас өмнө “Дараах асуултууд нь таны эрүүл мэндийн шалтгаанаар зарим нэг ажлыг хийхэд хүндрэл учирдаг эсэхийг тодорхойлох зорилготой” гэж энэ хэсгийн асуултад тайлбар өгөх хэрэгтэй.

Хэрэв эрүүл мэндийн асуудал, бэрхшээлийн хувьд ямар нэгэн бэрхшээл байхгүй бол “Үгүй, хүндрэл байхгүй” буюу “01”, бага зэргийн бэрхшээлтэй бол “Тийм, бага зэргийн хүндрэлтэй” буюу “02”, нэлээд бэрхшээлтэй бол “Тийм, их хүндрэлтэй” буюу “03”, бэрхшээлээс болж тухайн эрхтний хувьд огт үйлдэл хийж чаддаггүй бол “Тийм, огт чаддаггүй” буюу “04”, хариулж мэдэхгүй байсан болон хариулахыг хүсээгүй бол “Мэдэхгүй/хариулаагүй” буюу “98” гэсэн кодыг сонгоно.

(НН3.19) [Нэр]-ын/ийн хувьд юм харахад хүндрэлтэй байдаг уу? (Харааны шил зүүсэн ч)

Харааны бэрхшээлтэй буюу харааны шил эсвэл контакт линз зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд харахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой юм. Тухайн хүн харааны шил зүүдэг тохиолдолд **Та харааны зүүсэн ч юм харахад хүндрэлтэй байдаг уу?** гэж асуух хэрэгтэй. Нэг нүд нь хардаг хүний хувьд урагшаа харахад ямар нэг хүндрэлгүй боловч хараагүй нүдний талыг бүрэн харахад хүндрэлтэй байдаг.

(НН3.20) [Нэр]-ын/ийн хувьд юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? (Сонсголын аппарат зүүсэн ч)

Сонсголын бэрхшээлтэй, сонсголын аппарат зүүсэн эсвэл зүүдэггүй хүмүүсийн хувьд сонсоход хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Сонсгол нь эргэн тойрны дуу чимээг сонсох, мөн аюултай нөхцөл байдлаас өөрийгөө хамгаалах баримжааг олгож байдаг. Сонсох бэрхшээлд чимээ ихтэй орчин эсвэл нам гүн орчинд янз бүрийн чимээг ялгаж сонсоход нэг эсвэл 2 чихээрээ сонсоход хүндрэл тулгарч байгааг ойлгоно. Тухайн хүн сонсголын аппарат зүүдэг бол **Та сонсголын аппарат зүүсэн ч юм сонсоход хүндрэлтэй байдаг уу?** гэж асуух хэрэгтэй.

(НН3.21) [Нэр]-ын/ийн хувьд тэгш гадаргуу дээр алхах, налуу гадаргуу дээр өгсөх, уруудаход хүндрэлтэй байдаг уу?

Алхахдаа ямар нэгэн хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. **Алхах** гэдэг нь хөлийг нэг цэгээс нөгөөд зөөх хөдөлгөөн юм. Ямар нэгэн дэмжлэг болох төхөөрөмж (тэргэнцэр, таяг, алхуулагч гэх мэт) эсвэл хэн нэгний туслалцаагүйгээр алхаж чадаж байвал алхаж чаддаг гэж үзнэ.

- Богино зайд (ойролцоогоор 100 метр) эсвэл хол зайд (ойролцоогоор 500 метр) алхахад тулгарч байгаа хүндрэлийг оруулна.
- Замдаа амрахгүй зогсохгүйгээр зорих газартай алхаад очиход бэрхшээлтэй байгаа тохиолдлыг оруулна.
- Алхахад хүндрэлтэй гэдэгт алхсанаас эсвэл шатаар дээш, доош алхсанаас шалтгаалж бие сулрах, тэнцвэр алдах, эсвэл бусад тулгуур эрхтэн тогтолцооны бус хүндрэл тохиолдож байгааг оруулна.

(НН3.22) [Нэр]-ын/ийн хувьд аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг уу?

Энэ асуулгын зорилго нь ямар нэгэн юмыг санахад бэрхшээлтэй, өдөр тутмын үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж гүйцэтгэхэд хүндрэл учирдгийг тодорхойлоно. Эргэн санах гэж өнгөрсөн үйл явдлыг эргэж санахыг ойлгоно. Аливаа зүйлийг эргэн санах нь цээжлэх, ой тогтоолттой ижил биш. **Анхаарлаа төвлөрүүлэх** гэдэг нь

аливаа зүйлийг хийхэд оюуны чадамжaa ашиглах явдал юм. Тухайлбал, ном унших, тоо бодох, аливаа зүйлийг сурахад хүн оюуны чадамжaa ашиглаж байдаг. Аливаа зүйлийг гүйцэд хийж гүйцэтгэхэд л зөвхөн голчлон анхаарах юм. Зам харгуй олох, аливаа асуудалд анхаарлаа хандуулж чадахгүй байх, хаана байгаагаа эсвэл он сараа мартах зэргийг бэрхшээлтэй гэж үзнэ. Мөн хэн нэгний хэлсэн ярьсныг санахгүй байх, будилах, ихэнх зүйлсээс айх зэргийг хүндрэлтэйд тооцно.

Тэмдэглэл: Ажлын ачаалал, стресс бухимдал, эмийн нөлөөний улмаас үүссэн санах, анхаарлаа төвлөрүүлэхтэй холбоотой хүндрэлийг ХҮНДРЭЛТЭЙ ГЭЖ ҮЗЭХГҮЙ.

(НН3.23) [Нэр]-ын/ийн хувьд бие даан өөрөө усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлахад хүндрэлтэй байдаг уу?

Энэ асуулт нь бие даан өөрийгөө халамжлах, анхаарахад хүндрэлтэй хүмүүсийг илрүүлэх зорилготой. Усанд орох гэдэг нь биеэ угаах (савандаж угаах)-ыг ойлгоно. Саван, шампунь, бие угаагч, ус зэрэг шаардлагатай зүйлийг хэрэглэн үсээ, хөлөө угааж чаддаг бол оруулна. Хувцаслах гэдэгт өмд, цамцаа өмсөх, гутлаа өөрөө өмсөхийг ойлгоно. Мөн хувцасны шүүгэнээс хувцсаа авах, товчоо товчлох, үдээс үдэх, цахилгаан татах гэх зэргийг оруулна. Угаах, хувцаслах өдөр тутамдаа хийгддэг үйл ажиллагаа юм.

(НН3.24) [Нэр]-ын/ийн хувьд төрөлх хэлээрээ бусадтай ярилцахад ямар нэгэн хүндрэл гардаг уу?

Энэ хэсэг нь ярих, сонсох, бусдыг ойлгох, бусдад өөрийгөө ойлгуулахад ямар нэг хүндрэлтэй байдаг хүмүүсийг илрүүлэх зорилготой. Ярилцах гэдэг нь хүмүүсийг аливаа нэг хэлээр бусадтай мэдээлэл болон өөрийн үзэл санаагаа солилцох үйл явц юм. Харилцааны хүндрэл нь олон зүйлээс шалтгаалж байдаг. Тухайлбал, сонсгол эсвэл хэл ярианы бэрхшээлээс шалтгаалж бусадтай харилцах чадахгүй байх, эсвэл дуу чимээг хүлээн авах чадвартай холбоотой буюу авиа ялгаж сонсдоггүй байж болно. Мэдээлэл солилцохдоо дохио зангаа хэрэглэдэг (дохионы хэл орно), бичгээр эсвэл дуу авиа ашигладаг бол харилцааны бэрхшээлтэй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, бусдад өөрийгөө ойлгуулахдаа эсвэл бусдын яриаг ойлгоходоо харилцааны өөр арга хэрэглэж байгаа тохиолдлыг ойлгоно.

(НН3.25) [Нэр] нь хөгжлийн бэрхшээлийн асуудлаар эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагад бүрдгэлтэй юу?

Энэ асуултыг тухайн ярилцлага өгөгчийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлаар эрүүл мэнд болон нийгмийн халамжийн байгууллагад бүрдгэлтэй (үнэмлэх/ баримт бичигтэй) эсэхийг тодруулан асууна. Хэрвээ ярилцлага өгөгч хөгжлийн бэрхшээлийн асуудлаар эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагад бүрдгэлтэй бол “Тийм” буюу “01”, бүрдгэлгүй бол “Үгүй” “02” гэсэн кодыг сонгож НН3.30-рүү шилжинэ.

Дотор эрхтэн, мэс засал зэрэг эмнэлгийн заалтаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдлыг энд хамруулахгүй.

(НН3.26) [Нэр]-ын/ийн хөгжлийн бэрхшээлийнхээ төрлийг хэлнэ үү.

Энэ асуултад хөгжлийн бэрхшээлийн асуудлаар эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагад бүрдгэлтэй буюу НН3.25-р асуултад “Тийм” гэж хариулсан 14, түүнээс дээш настай хүн хариулна.

Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэнэ. Хөгжлийн бэрхшээлийн төрөлд хөгжлийн бэрхшээлийн үүсэл, гарлыг хамааруулна.

“Төрөлхийн” буюу “01” хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшилын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.

“Төрөлхийн” буюу “01” гэсэн хариултыг сонгосон бол НН3.28-р асуулт руу шилжинэ.

“Олдмол” буюу “02” хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчиний улмаас бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ.

(НН3.27) [Нэр]-ын/ийн хөгжлийн бэрхшээл /үндсэн/-ийн шалтгаан нь юу вэ?

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй тохиолдолд бэрхшээлтэй болсон шалтгааныг тодруулах зорилготой асуулт юм. Зам тээврийн осол бол “01”, Үйлдвэрлэлийн осол бол “02”, Мэргэжлээс шалтгаалах өвчин бол “03”, Ахуйн осол “04”, Ердийн өвчин бол “05”, Хавсарсан байдлаар бол “06”, Бусад шалтгаанаар бол “07” гэсэн кодыг сонгоно.

(НН3.28) [Нэр]-ын/ийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр юу вэ?

Ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодруулан асууж Харааны бэрхшээлтэй бол “01”, Хэл ярианы бэрхшээлтэй бол “02”, Сонголын бэрхшээлтэй бол “03”, Хөдөлгөөний бэрхшээлтэй бол “04”, Сэтгэцийн бэрхшээлтэй бол “05”, Хавсарсан бол “06”, кодыг сонгож хариултыг бичнэ. Хавсарсан гэдэгт дээр дурдсан тохиолдууд 1-ээс дээш давтагдсан тохиолдолд энд хамруулна.

(НН3.29) [Нэр] нь тэргэнцэр хэрэглэдэг үү?

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тэргэнцэр хэрэглэдэг эсэхийг асууна. Хэрэв тийм бол “01”, Үгүй бол “02” кодыг сонгоно

(НН3.30) 14-17 настай эсэхийг шалгана уу. (НН3.05-аас шалгана)

- НН3.05-аас тухайн хүний насыг 14-17 настай хүүхэд эсэхийг шалгах асуулт юм. Тийм буюу “1” гэсэн кодыг сонгосон тохиолдолд 14-17 настай хүүхэд хэд байгаа тоог оруулна.

ӨРХИЙН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

14-17 настай хүүхэдтэй өрхөөс энэхүү зөвшөөрлийн хуудсаар 14-17 настай хүүхдээс нь асуулга авч болох эсэхийг асууж зөвшөөрөл авна. Хэрэв эцэг эх, асран хамгаалагч нь зөвшөөрөөгүй бол тухайн хүүхдээс Маягт-АОАБС-2 асуулгыг авахгүй.

2.2. ӨРХИЙН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫГ НӨХӨХ ЗААВАР (МАЯГТ-АОАБС-2)

Санамж: Өрхийн гишүүний асуулгыг авахдаа эцэг, эх асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авсны үндсэн дээр “14-17 настай хүүхэд”-ээс эхэлж асуухыг анхаарна уу?”

Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны өрхийн гишүүний асуулга нь доорх 4 багц асуулга болон 3 лавлах хүснэгтээс бүрдэнэ.

1. “Амьдрах орчны нөхцөл байдал LC1-LC4”,
2. “Иргэдийн үзэл бодол CO1-CO11”,
3. “Гэмт хэрэгт хохирсон байдал-сүүлийн 3 жилд CV1-CV26”,
4. “Гэмт хэрэгт хохирсон байдал-сүүлийн 12 сард CV27-CV45” гэсэн 4 багц асуулга,
5. “Сүүлийн 3 жилд гэмт хэрэгт хохирсон байдлыг лавлах хүснэгт INTV-1”,
6. “Гэмт хэргийн гаралтыг лавлах хүснэгт INTV-2”
7. “Орчны аюулгүй байдлын түвшинг лавлах хүснэгт INTV-3” гэсэн 3 лавлах хүснэгтээс бүрдэнэ.

2.2.1. ХЭСЭГ 1. АМЬДРАХ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Quality of Life (QOL) буюу амьдралын чанарыг “Хувь хүний амьдралын байр суурийг тэдний амьдарч буй соёл, үнэт зүйлсийн тогтолцооны хүрээнд, тэдний зорилго, хүлээлт, стандарттай уялдуулах тухай ойлголт” хэмээн тодорхойлсон. Амьдралын чанарын стандарт үзүүлэлтүүдэд эд баялаг, ажил эрхлэлт, хүрээлэн буй орчин, бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд, боловсрол, амралт, чөлөөт цаг, нийгмийн харьяалал, шашны итгэл үнэмшил, аюулгүй байдал, эрх чөлөө зэрэг үзүүлэлтүүд багтана.

Амьдарч буй орчны нөхцөл байдал нь иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэгч чухал хүчин зүйл юм. Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн (МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал).

Энэхүү бүлэг асуулгаар ярилцлага өгөгчийн үзэл бодол, итгэл үнэмшлийг тодруулах байдлаар асууж, хариултыг Ликертийн шатлалын Огт санал нийлэхгүй байна “1”, Санал нийлэхгүй байна “2”, Санал нийлж байна “3”, Санал бүрэн нийлж байна “4”, Мэдэхгүй / Хариулахгүй “98” гэсэн 5 хувилбараас тохирохыг сонгоно.

(LC1.) Амьдарч буй орчны нөхцөл байдал нь иргэдийн тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэгч чухал хүчин зүйл юм. Дараах асуултууд нь таны оршин сууж байгаа газрын нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг агуулсан болно. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Амьдрах орчны нөхцөл байдал нь орчны эмх замбараагүй байдлаас шууд шалтгаална. Эмх замбараагүй байдал нь биет хэлбэрийн болон олон нийтийн амьдралын хэв маягийн гэсэн хоёр чухал хүчин зүйлээс бүрддэг.

Олон нийтийн амьдралын хэв маягийн эмх замбараагүй байдал нь архидан согтуурах, гудамж талбайд хэрэлдэх, зодолдох, биеэ үнэлэх, хууль бусаар архи, тамхи борлуулах гэх мэт нийтэд хор уршигтай үйлдэл, үзэгдлийг хэлнэ.

Биет хэлбэрийн эмх замбараагүй байдалд хог хаягдал, эзэнгүй байр, гарааш, подвал, эвдэrsэн гэрэлтүүлэгтэй орчин, графити бичиглэл, зураг зэрэг нийтийн дунд эмх цэгцгүй байдлыг бий болгогч зүйлсийг хамруулан үздэг.

Хүрээлэн буй орчны эмх замбараагүй байдал, амьдралын буруу хэв маяг нь олон нийтийн дунд гэмт хэрэг, зөрчлийн гаралт, иргэдийн гэмт хэргээс айх айдсын хүчин зүйлийг бий болгох, нэмэгдүүлэх шалтгаан нөхцөл нь болдог. LC1.1-LC1-19 дугаар асуултууд нь дээрх нөхцөл байдлын талаарх иргэдийн үзэл бодол, итгэл үнэмшлийг тодруулах зорилготой болно.

(LC1.1) Таны оршин сууж байгаа газар орчны бохирдол, хог хаягдал ихтэй юу? Энэ асуулгаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл байдалд орчны хог хаягдал, бохирдол хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлно.

(LC1.2) Таны оршин сууж байгаа газар харанхуй, гэрэлтүүлэг муутай, ганцаараа явахад айдас төрөхүйц байдаг уу? (Зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна) Иргэдийн аюулгүй амьдрах нөхцөл байдалд орчны гэрэлтүүлэг, ганцаараа явахад айдас төрүүлэхүйц байдаг эсэхийг тодорхойлно.

(LC1.3) Таны оршин сууж байгаа газар эзэнгүй, орхигдсон хашаа, саравч, байшин, подвал, хүн орогнох боломжтой хаягдал автомашин, гарааш, траншейн, гуу жалга гэх мэт зүйлс байдаг уу? Асуулгаар иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дээрх таагүй орчин нөлөөлж байгаа эсэхийг илэрхийлнэ.

(LC1.4) Таны оршин сууж байгаа газар тогтоосон эрх зүйн хэм хэмжээ, хууль, дүрэм, журам зөрчдөг хүн олон байдаг уу? (Тухайлбал: Замын хөдөлгөөний дүрэм зөрчих, хориглосон газар автомашинаа байрлуулах, гудамжинд архи уух, тамхи татах, бие засах гэх мэт) Нийтийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлд тогтоосон эрх зүйн хэм хэмжээ зөрчдөг иргэд хэрхэн хүндрэл учруулж байдаг болохыг уг асуулгаар тодорхойлно.

(LC1.5) Таны оршин сууж байгаа газарт бүлэглэн танхайрах явдал ажиглагддаг уу? Хоёр буюу түүнээс дээш тооны этгээд нэгдэн бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчих үйлдлийг бүлэглэн танхайрах явдал гэж ойлгоно. Ярилцлага өгөгчөөс оршин сууж байгаа газарт нь бүлгээр танхайрч иргэдийн аюулгүй, амар тайван амьдрахад сөргөөр нөлөөлдөг бүлэглэл байгаа эсэхийг асууна.

(LC1.6) Та согтуу, мансуурсан, чанга дуугаар хэрэлдэж эсвэл зодолдож байгаа хүмүүсийг байнга хардаг уу? Нийтийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлд согтуу, мансуурсан, чанга дуугаар хэрэлдэж, зодолдож байгаа иргэд хэрхэн нөлөөлж байдгийг уг асуулгаар тодорхойлно.

(LC1.7) Таны оршин сууж байгаа газарт замын хөдөлгөөний түгжрэл ихтэй юу? (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна) Энэ асуултыг зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг сонгогдсон өрхийн гишүүдээс асууна. Иргэдийн амьдралын чанарт замын хөдөлгөөний түгжрэл хэрхэн сөргөөр нөлөөлж буйг асуулгаар судална.

(LC1.8) Таны оршин сууж байгаа газарт ойрхон явган хүний гарц, автобусны буудал байдаг уу? (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна) Энэ асуулгаар ойролцоо явган хүний гарц, автобусны буудал иргэн хүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгаа болон нөгөөтээгүүр хот төлөвлөлтийн оновчтой бодлого, шийдвэр хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлно.

(LC1.9) Таны оршин сууж байгаа газарт эзэнгүй нохой, муур их байдаг уу? Энэ асуулгаар иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд эзэнгүй нохой, муур хэрхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг тодорхойлох боломжтой.

(LC1.10) Таны амьдарч буй орон сууц газар хөдлөлтөд тэсвэртэй гэж боддог уу? (Зөвхөн орон сууцанд амьдардаг хүнээс асууна) Энэ асуулгыг зөвхөн орон сууцанд амьдардаг хүнээс асуух бөгөөд ярилцлага өгөгч хувь хүн болон өрхийнхөө аюулгүй байдлыг хамгаалах үүднээс газар хөдлөлтөд тэсвэртэй орон байр сонгож байгаа эсэхийг асууна. Орон сууцанд бие даасан тохилог сууц, нийтийн орон сууц, хажуу өрөө, нийтийн байрыг хамруулна.

Орон сууц гэж бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй суурин барилгын доторх сууцыг ойлгоно. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна.

Нийтийн орон сууц гэж бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрд зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь бүх төрлийн дэд бүтцээр хангагдсан, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд: (а) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй; (б) Сууцны дотор бие засах газартай; (в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй; (г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх талбайтай байна.

Бие даасан тохилог сууц гэж бие даасан тохилог сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, Сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй мөн мансардтай болон мансардгүй байж болно.

Хажуу өрөө гэж бусдын байр сууцанд нэг өрөө, тасалгаанд нь түрээстэй болон түрээсгүйгээр амьдарч байгаа аль ч нөхцөлийг энд хамааруулна.

Нийтийн байр гэж иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй, судалгаа авах үед хүн амьдарч байгаа сууцыг нийтийн байранд хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн нийтийн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр, түүнтэй адилтгах бусад байр орно.

(LC1.11) Таны оршин сууж байгаа газарт хууль бусаар архи, тамхи худалдаалдаг айл, дэлгүүр, ТҮЦ, иргэд байдаг уу? Хууль бусаар архи, тамхи худалдаалдаг цэгүүд нь иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлд сөрөг нөлөөтэй байх магадлалтай тул энэ асуултаар судална.

(LC1.12) Таны оршин сууж байгаа газар үер, усанд автых эрсдэлтэй байдаг уу? (Ус зайлцуулах суваг, шуудуу байдаг эсэх) Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлд “үер усанд автых эрсдэл” тохиолддог учраас энэ асуултаар үер усны иргэдийн амьдралын чанарт үзүүлэх эрсдэл хэр байдгийг тодорхойлох зорилготой.

(LC1.13) Таны оршин сууж байгаа газрын цахилгаан шугам сүлжээ аюулгүй байдаг уу? (Зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна) Иргэний амьдрах орчны аюулгүй байдлыг тодорхойлоход цахилгаан, шугам сүлжээний аюул хэр нөлөөтэй байгааг тодорхойлох зорилготой асуулт юм.

(LC1.14) Таны оршин сууж байгаа газар амьдрах орчны таатай нөхцөлийг хангадаг гэж үздэг үү? (Авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, тохижилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц гэх мэт) (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна) Энэхүү асуултаар иргэдийн амьдрах орчны таатай нөхцөлийн наад захын хэрэгцээг хангах авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, тохижилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарцаар хангаж байгаа байдлыг судална.

(LC1.15) Таны оршин сууж байгаа газарт түргэн тусламж, гал түймэр унтраах, аврах тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх боломж байдаг уу? (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна) Иргэдэд яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд чөлөөтэй нэвтрэх боломж хэр байдгийг судлах зорилготой асуулт юм.

(LC1.16) Таны оршин суугаа газар уул уурхайн олборлолт, эрдэс бодисын үйлдвэр болон хүнд үйлдвэрлэл явагддаг үү? Энэ асуултаар иргэдийн амьдарч буй газарт уул уурхай, ашигт малтмалын олборлолт явагддаг эсэхийг тодорхойлно. Уул уурхай, ашигт малтмалын олборлолтын улмаас орон нутгийн иргэдийн амьдралд сөрөг үр дагавар үүсэх магадлал ихтэй тул энэхүү асуултаар тодруулан асууна.

- Тийм “1”,
- Үгүй “2”,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” - хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Хэрэв Нийслэл, Аймгийн төвд оршин суудаг иргэнээс асуухад “Тийм” гэсэн бол LC2.1-рүү шилжих ба харин сумын төв, хөдөөгийн иргэнээс асуухад “Тийм” гэсэн бол LC1.17-рүү шилжинэ.

Хэрэв Нийслэл, Аймгийн төвд оршин суудаг иргэнээс асуухад “Үгүй” гэсэн бол LC2.1-рүү шилжих ба харин сумын төв, хөдөөгийн иргэнээс асуухад “Үгүй” гэсэн бол LC1.18-рүү шилжинэ.

(LC1.17) Уул уурхай, ашигт малтмал олборлолтын улмаас таны оршин сууж байгаа газрын байгаль, экологийн тэнцвэрт байдал алдагдсан гэж үздэг үү? (Зөвхөн сумын төв, хөдөө оршин суудаг иргэдээс асууна) Иргэдийн эрүүл

аюулгүй, амар тайван амьдрахад нь байгаль экологийн тэнцвэрт байдал чухал нөлөөтэй тул энэ асуултаар тодруулан асууна.

(LC1.18) Таны оршин сууж байгаа нутагт малын бэлчээрийн даац хэтэрсэн гэж үздэг үү? (Зөвхөн сумын төв, хөдөө оршин суудаг иргэдээс асууна) Малчдын амьжирагааны гол эх үүсвэр нь болсон малын ашиг шим, үр өгөөжид малын бэлчээрийн даацын асуудал чухал юм. Малын бэлчээрийн даац хэтрэх нь малчдын амьдралын чанарт сөрөг нөлөөтэй учраас иргэдийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрт малын бэлчээрийн даац хэтэрсэн эсэхийг асууна.

- Тийм “1”,
- Үгүй “2”,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” - хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Үгүй, Мэдэхгүй / Хариулаагүй гэж хариулсан тохиолдолд LC2.1-рүү шилжинэ.

(LC1.19) Бэлчээрийн даац хэтэрсэн нь таны амьдралын хэв маяг, амьдралын түвшинд сэргээр нөлөөлсөн гэж үздэг үү? (Зөвхөн сумын төв, хөдөө оршин суудаг иргэдээс асууна) Бэлчээрийн даац хэтрэх нь иргэдийн амьдрах орчны аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. Өөрөөр хэлбэл иргэд өөрсдөө бэлчээр сайтай газар руу отор, нүүдэл хийх шаардлага тулгарахаас гадна, малын идэх, өвс усны асуудал, мал болон малчдад хүндрэл тохиолдоно.

(LC.2) Иргэд хоорондын харилцаа нь аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй байдаг. Дараах асуултууд нь таны оршин сууж байгаа газар дахь иргэд хоорондын харилцааны талаарх зарим мэдээллийг агуулсан болно. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэд хоорондын харилцаа нь аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй байх бөгөөд иргэд хоорондын харилцааг олон нийтийн хяналтаар хэмждэг. Олон нийтийн хяналт супрахад амьдрах орчинд эмх замбараагүй, тогтвортгүй байдал бий болж, иргэдийн харилцаа, хамтын ажиллагаа, хандлага, ёс суртахууны доройтол нэмэгддэг. LC2.1-LC2.5 дугаар асуултууд иргэд амьдарч буй орчиндоо хоорондоо хэрхэн харилцан ойлголцож, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд яаж хамтран ажилладаг хандлагыг тодорхойлох зорилготой болно.

(LC2.1) Та хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүсээ сайн мэддэг гэдэгтэй санал нийлэх үү? Энэ асуулгаар хөрш болон саахалт айлуудын харилцааг судална. Хөдөөд хөршийн холбоог саахалт айлаар төлөөлнө. Монгол хэлний тайлбар тольд зааснаар саахалт гэдгийг “саах зөрүүлэхээр ойролцоо буусан айл”-ыг ойлгоно гэжээ. Монголчуудын эртний уламжлалаас харахад 1-3 км-т ойролцоо буусан айлуудыг “саахалтын айл” гэж гэж нэрлэн саахны хурга ишиг буюу ишиг, хургыг зөрүүлдэг айлуудыг саахалтын айл гэж нэрлэдэг.

(LC2.2) Танай хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүс ямар нэгэн асуудал, хүндрэл үүссэн үед нэгэндээ туслалцаа үзүүлдэг гэдэгтэй санал нийлэх үү? Хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүс хүндрэлтэй асуудал гарсан тохиолдолд бие биедээ тусламж, дэмжлэг үзүүлдэг эсэхийг тодорхойлох зорилготой. Хөршүүдийн найрсаг хамтын ажиллагаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй.

(LC2.3) Танай хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүс бусдын халдлагад өртөж буй хүүхдэд туслахад бэлэн байdag гэдэгтэй санал нийлэх

үү? Танай хөрш, саахалт айлууд хөршийнхөө бусдад хүчирхийлүүлж, бусдын халдлагад өртөж байгаа бага насны хүүхдүүдэд туслахад бэлэн байдаг эсэхийг асууна. Энэ нь нэг талаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх нийтийн үйл ажиллагаанд иргэд иргэнийхээ хувьд хэрхэн оролцож буй оролцоог нөгөөтээгүүр хүүхэд хамгаалах ажиллагаанд насандаа хүрэгчдийн оролцоо хэр байгааг тодорхойлно.

(LC2.4) Танай хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүс гэмт хэргийг харсан даруйдаа цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг гэдэгтэй санал нийлэх үү? Хөрш, саахалтууд гэмт хэргийг харсан даруйд Цагдаа болон хэрэг бүрдгэх байгууллагад мэдэгддэг эсэхийг лавлаж нэг талаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх нийтийн үйл ажиллагаанд иргэд иргэнийхээ хувьд хэрхэн оролцож буй оролцоог тодорхойлно.

(LC2.5) Танай хөрш оршин суугчид болон саахалт айлын хүмүүс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын арга хэмжээнд оролцоход бэлэн байдаг гэдэгтэй санал нийлэх үү? Хөршүүд, саахалтууд нийгмийн сайн сайхны төлөө иргэнийхээ үүргийг биелүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сайн дураараа оролцож байгаа эсэхийг тодорхойлно.

(LC3) Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэдэг. Дараах асуултууд нь таны оршин сууж байгаа газар дахь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх таны үзэл бодлыг асууна. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэдийн цагдаад итгэх итгэлийн талаар үнэн бодитой мэдээллийг авснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг оновчтой тодорхойлох боломж бүрддэг. Иргэдийн цагдаад итгэх итгэлийг тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг, хандлага, ёс зүй, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллөөр хэмждэг.

(LC3.1) Цагдаагийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүлийн үйл ажиллагааг маш сайн гүйцэтгэдэг гэдэгтэй санал нийлэх үү? Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрахад Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаа чухал нөлөөтэй. Тиймээс оршин сууж байгаа газрынхаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх тэдний сэтгэгдлийг асууна. Энэ нь иргэдийн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг юм.

(LC3.2) Цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэрэг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу хурдан шуурхай шалгаж шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлэх үү? Энэ нь иргэдээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд Цагдаагийн үйл ажиллагаа хуулийн дагуу, хурдан шуурхай явагддаг эсэхийг ярилцлага өгөгч иргэдийн үзэл бодлыг асууж дүгнэнэ.

(LC3.3) Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэдлэг, чадвартай гэдэгтэй санал нийлэх үү? Энэ нь иргэдийн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд иргэдийн Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ур чадварыг үнэлэх үнэлэмжийг тодорхойлно.

(LC3.4) Цагдаа та бидний аюулгүй байдлыг хангаж чадна гэдэгтэй санал нийлэх үү? Энэ нь иргэдийн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн

иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах үндсэн үүргээ хэрхэн биелүүлж ажиллаж байгаа, иргэдийн Цагдаад итгэх итгэлийг ярилцлага өгөгчийн үнэлэмжээр илэрхийлнэ.

(LC3.5) Цагдаагийн алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ иргэдтэй соёлтой, ёс зүйтэй харилцдаг гэдэгтэй санал нийлэх үү? Энэ үзүүлэлт нь иргэд болон Цагдаагийн байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг илэрхийлэх чухал үзүүлэлт бөгөөд Иргэдийн Цагдаагийн алба хаагчдын ёс зүй, хандлагын талаарх сэтгэгдлийг асууна.

(LC4) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн гэмт гэмт хэргийн талаарх үзэл бодол чухал байр суурийг эзэлдэг. Дараах асуулт нь гэмт хэргийн гаралтын чиг хандлагын талаарх таны үзэл бодол, төсөөллийн талаар асуух болно. Та гэмт хэргийн гаралтын чиг хандлагыг өнгөрсөн жилийнхтэй харьцуулбал хэрхэн төсөөлж байна вэ?

Гэмт хэргийн гаралт, шалтгааны талаарх иргэдийн үзэл бодол, төсөөллийг асууна.

(LC4.1) Улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт хэрхэн өөрчлөгднө гэж бодож байна вэ? Аль ч нийгмийн үед иргэдийн амьдралын чанарыг хэмжих үндсэн үзүүлэлтуүдийн нэг нь тухайн нийгэмд гэмт хэргийн чиг хандлага нь өсөлт бууралт хэр байгаагаар илэрхийлэгддэг ба өөрөөр хэлбэл нийгэм хямарч ажилгүйдэл, ядуурал ихсэж, инфляц өсөхийн хэрээр гэмт хэргийн гаралт өсөж байдаг зүй тогтолтой. Тиймээс гэмт хэргийн статистик бол нийгмийн амьдралын сөрөг үр дагаврын илэрхийлэл юм. Энэ утгаар нь Иргэдээс нийгмийн амьдралын өнөөгийн түвшинд гэмт хэрэг өсөх, буурах ямар хандлага харагдаж байгааг асууна.

- Буурна “1”
- Хэвэндээ байна “2”
- Өснө “3”
- Мэдэхгүй/Хариулаагүй “98” - хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Хэрэв Буурна “1”, Хэвэндээ байна “2”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэж хариулсан тохиолдолд LC4.3-руу шилжинэ.

(LC4.2) Та улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт өсөх шалтгаан нь юу гэж үзэж байна вэ? (Олон сонголттой байж болно) Нийгмийн амьдралын өнөөгийн түвшинд улсын хэмжээнд гэмт хэргийн гаралт юунаас шалтгаалж өснө гэж үзэж байгаа талаар иргэдийн үзэл бодлыг шалтгаанаар нь тодорхойлон харуулна.

- Үнийн өсөлт “A”
- Ажилгүйдэл “B”
- Ядуурал “C”
- Орчны эмх, замбараагүй байдал “D”
- Шударга бус байдал “E”
- Архидалт “F”
- Бусад () “G”- дээр дурдагдаагүй газрын байршлыг хэлж байгаа тохиолдолд энэ сонголтыг сонгох ба мэдээлэл цуглуулагч нь ярилцлага өгөгчийн хариултыг бичнэ.

(LC4.3) Таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн гаралт хэрхэн өөрчлөгднө гэж бодож байна вэ? Ярилцлага өгөгч өөрийн оршин сууж

байгаа нутаг дэвсгэртгэмт хэргийн гаралт хэрхэн өөрлөгдөнө гэж үзэж байгаа сэтгэгдлийг асууна.

- Буурна “1”
- Хэвэндээ байна “2”
- Өснө “3”
- Мэдэхгүй/Хариулаагүй “98” - хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Хэрэв Буурна “1”, Хэвэндээ байна “2”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн хариулсан тохиолдолд СО1.1-рүү шилжинэ.

(LC4.4) Та оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн гаралт өсөх шалтгаан нь юу гэж үзэж байна вэ? (Олон сонголттой байж болно)
Оршин сууж байгаа нутаг дэвсгэртээ гэмт хэргийн гаралт юунаас шалтгаалж өснө гэж үзэж байгаа талаар иргэдийн үзэл бодлыг шалтгаанаар нь тодорхойлон харуулна.

- Үнийн өсөлт “A”
- Ажилгүйдэл “B”
- Ядуурал “C”
- Орчны эмх, замбараагүй байдал “D”
- Шударга бус байдал “E”
- Архидалт “F”
- Бусад () “G”- дээр дурдагдаагүй газрын байршлыг хэлж байгаа тохиолдолд энэ сонголтыг сонгох ба мэдээлэл цуглуулагч нь ярилцлага өгөгчийн хариултыг бичнэ.

2.2.2. ХЭСЭГ 2. ИРГЭДИЙН ҮЗЭЛ БОДОЛ

(СО1) Дараах асуултууд нь таны гэмт хэргээс сээрэмжлэх ерөнхий хандлагыг илэрхийлэх болно. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Энэ хэсэг нь иргэдийн гэмт хэргээс сээрэмжлэх ерөнхий хандлагыг илэрхийлэх бөгөөд иргэдийн гэмт хэргээс айх айдсын хүчин зүйлийг тодруулах зорилготой юм. Иргэдийн гэмт хэргээс айх айдас нь гэмт хэргийн хохирогч болж болзошгүй гэсэн сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл бөгөөд гэмт хэргийн хохирогч болох эсвэл аюулд өртөж байна гэсэн итгэл үнэмшилээр өөрийгөө хязгаарлах ойлголт юм. Энэ мэдрэмж нь яагаад төрөх болов, түүнд нөлөөлж буй хүчин зүйл нь юу байна, хэрхэн урьдчилан сэргийлж иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангах вэ гэдэг нь нийгмийн өмнө тулгамдаж буй чухал асуудлын нэг бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын “АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ” бүлэгт тодорхойлон тусгасан билээ. Дор дурдсан нөхцөлүүд танд хэр аюулгүй санагддаг вэ? гэсэн үндсэн асуултаар асууж Үнэхээр аюулгүй “1”, Аюулгүй “2”, Аюултай “3”, Маш аюултай “4”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн сонголтоос хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно.

(СО1.1) Танд үдэш, шөнө гэртээ ганцаараа байхад хэр аюулгүй санагддаг вэ?
Энэ нь иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд иргэд амьдарч буй орчиндоо орой, үдэш, шөнийн цагаар

гэртээ ганцаараа байхдаа “аюулгүй” гэж үзэж байгаа эсэх талаарх сэтгэгдлийг асууна. Энэ нь ТХЗ-ын 16.1.4-ийн шалгуур үзүүлэлтийн нэг юм.

(СО1.2) Танд оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ гудамжаар шөнийн цагаар ганцаараа алхаад хэр аюулгүй санагддаг вэ? (Зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна) Энэ нь ТХЗ-ын 16.1.4-ийн шалгуур үзүүлэлтийн нэг бөгөөд иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийгилэрхийлэх үндсэн үзүүлэлтуүдийн нэг юм. Ярилцлага өгөгч иргэн амьдарч буй нутаг дэвсгэрийнхээ гудамжаар шөнийн цагаар алхаадаа “аюулгүй” гэж үзэж байгаа эсэх талаарх сэтгэгдлийг асууна. Энэ асуулгыг зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна.

(СО1.3) Танд ажлын байр, ажлын байрны орчинд хэр аюулгүй санагддаг вэ? (Зөвхөн хөдөлмөр эрхэлдэг иргэдээс асууна) (НН3.11-с шалгана) Энэхүү асуулгыг зөвхөн хөдөлмөр эрхэлдэг иргэдээс асууна. Ярилцлага өгөгчөөс ажилладаг ажлын байрных нь хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрных нь орчин хэр аюулгүй байдаг талаарх сэтгэгдлийг асууна.

(СО1.4) Танд сургууль, сургуулийн орчинд хэр аюулгүй санагддаг вэ? Ярилцлага өгөгчийн үзэл бодол, итгэл үнэмшлийг тодруулах байдлаар асууна. Сургууль, сургуулийн орчны аюулгүй байдлын талаарх асуулгыг ярилцлага өгөгч сургуульд сурдаггүй байхаас үл шалтгаалан, эцэг, эх, асран хамгаалагчийн хувьд хүүхдүүдийнхээ сургууль, сургуулийн орчинд аюулгүй байдлыг хэрхэн хангагдаж байгаа талаарх сэтгэгдлийг асууна.

(СО1.5) Танд олон нийтийн газар (худалдаа, үзвэр, үйлчилгээ, цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газар гэх мэт) хэр аюулгүй санагддаг вэ? Дээр дурдсан олон нийтийн газрын талаарх ярилцлага өгөгчийн үзэл бодлыг тодруулах байдлаар асууна.

(СО1.6) Танд нийтийн тээврийн хэрэгсэл (автобус, троллейбус, такси, галт тэрэг)-ээр зорчиход хэр аюулгүй санагддаг вэ? (Зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна) Нийтийн тээврийн хэрэгсэлд автобус, троллейбус, такси, галт тэргийг хамруулна. Нийтийн тээвэр гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн үйлчилгээний замын чиглэл, цагийн хуваарийн дагуу болон зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа зорчигч тээвэрлэлт, таксийн үйлчилгээг хэлнэ. Тээврийн хэрэгслийн зорчигч гэж тээврийн хэрэгсэл дээр байгаа буюу түүний бүхээг дотор байгаа жолоочоос бусад хүнийг хэлнэ. **Такси үйлчилгээ** гэж нийтийн таксигаар зорчих, үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангасан үйлчилгээг ойлгоно. Ярилцлага өгөгчийн нийтийн тээврээр үйлчлүүлэхэд аюулгүй байдал нь хэрхэн хангагдаж байгаа талаарх сэтгэгдлийг асууна.

(СО1.7) Танд банк, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх үед (АТМ оролцуулна) хэр аюулгүй санагддаг вэ? Банк, санхүүгийн үйлчилгээний аюулгүй байдлын талаарх ярилцлага өгөгчийн үзэл бодлыг асууна. “Банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монгол банкны зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг ойлгоно. **Санхүүгийн байгууллага** гэж санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг, санхүүгийн зуучлагчдыг хэлэх бөгөөд эдгээр нь зээл олгох, мөнгөн хөрөнгийг хадгалах, төлбөр тооцоо хийх, Монгол банк, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг.

(CO2) Хүн бүр гэмт хэргийн хохирогч болохоос болгоомжилдог. Дараах асуултууд нь гэмт хэрэгт хохирох байдлаас шалтгаалан таны өдөр тутмын амьдралд үүсэж болох айдсын хүчин зүйлийг илэрхийлэх болно. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэд гэмт хэргийн хохирогч болохоос болгоомжилдог бөгөөд үүнээс шалтгаалан өдөр тутмын амьдралд нь ямар нэг хэмжээгээр айдас бий болох үзэгдэл түгээмэл байдаг. Гэмт хэрэгт хохирох байдлаас болгоомжлох айдсын хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор дараах асуултуудыг асууна. Огт айдаггүй “1”, Айдаггүй “2”, Айдаг “3”, Маш их айдаг “4”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн сонголтоос хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно.

Айдас гэж аюул заналхийлж буй үзэгдэл, нөхцөл байдалд хүний бие организм, мэдрэмж болон бодлын үзүүлж буй хариу үйлдэл юм. Айдас нь ямар нэг аюул нүүрлээд буйг, ямар нэг зүйл хэвийн бус байгааг сануулсан дохиоллын систем юм. Айдсаар дамжуулж аливаа аюулыг хурдан илүү сайн илрүүлдэг. Айдсын үед ихэвчлэн зүрх дэлсэх, амьсгал түргэсэх, цусны даралт ихсэх, хodoод эвгүйрхэх, гүйлгэх, ойр ойрхон шээх, чичрэх, толгой эргэх, дотор муухай оргих, хөлрөх, улайх, цонхийх, нойр хүрэхгүй байх, хоолойгоор юм орохгүй байх зэрэг хариу үйлдлүүд илэрнэ.

(CO2.1) Хэн нэгэн таны мөнгө, үнэт эдлэл, эд хөрөнгийг хулгайлна гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн мөнгө, үнэт зүйлээ хулгайд алдах бий гэсэн айдсыг 4 сонголтын дагуу тодруулж асууна.

(CO2.2) Хэн нэгэн таны мөнгө, үнэт эдлэл, эд хөрөнгийг хүч хэрэглэж авна гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн мөнгө, үнэт эдлэлийг хүч хэрэглэх замаар авна гэх айдсыг тодруулж асууна.

(CO2.3) Таны амь нас, эрүүл мэндэд хэн нэгэн халдаж хохироож болзошгүй гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн амь нас, эрүүл мэндэд хэн нэгэн халдаж болзошгүй гэх айдсыг тодруулж асууна.

(CO2.4) Хэн нэгэн таны эд хөрөнгийг залилан мэхэлж авна гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн эд хөрөнгөө хэн нэгэнд залилуулах бий гэх айдсыг тодруулж асууна.

(CO2.5) Та хэн нэгний бэлгийн хүчирхийлэлд өртөнө гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн бэлгийн хүчирхийлэлд өртөх бий гэх айдсын талаар үзэл бодлыг тодруулах байдлаар асууна. Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг ойлгоно.

(CO2.6) Хэн нэгэн таны эд хөрөнгийг санаатай устгаж, гэмтээж болзошгүй гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн хэн нэгэнд эд хөрөнгөө устгуулж, гэмтээлгэх бий гэж айх айдсыг асууна.

(CO2.7) Хэн нэгэн таны орон байранд хууль бусаар нэвтэрч орно гэж айдаг уу? Ярилцлага өгөгч иргэний хэн нэгэн орон байранд нь хууль бусаар нэвтэрч орно гэж айх айдсыг асууна.

(СО2.8) Хэн нэгэн таныг мөшгөх эсвэл утсаар сэтгэл санааны дарамтад оруулна гэж айдаг уу? Ярилцлага өгөгч иргэний хэн нэгэн өөрийг нь мөшгөх, утсаар сэтгэл санааны дарамтад оруулах бий гэх айдсыг асууна.

(СО2.9) Үндэслэлгүй баривчлагдана гэж айдаг уу? Ярилцлага өгөгчийн хувьд гэмт хэрэгт хэлсээр гутгэгдэх замаар хэлсээр үндэслэлгүй Цагдаад баривчлагдах бий гэх айдсыг асууж тодорхойлно.

(СО3) Иргэд гэмт хэргийн хохирогч болохгүй байхын тулд өөртөө төдийгүй гэр бүлийн гишүүддээ онцгой анхаарал хандуулдаг. Дараах асуултууд нь таны гэмт хэргээс сэргийлэх байдлыг илэрхийлсэн агуулгатай юм. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу. Гэмт хэргээс болгоомжлох, сэргийлэх үзэл бодол, хандлагыг тодорхойлоход чиглэгдэнэ. Огт айдаггүй “1”, Айдаггүй “2”, Айдаг “3”, Маш их айдаг “4”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн сонголтоос хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно.

Гэмт хэргийн хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно. (МУ-ЫН ЭХХШХ).

(СО3.1) Та ямар нэг гэмт хэргийн улмаас хохирохоос айдаг уу? Ярилцлага өгөгчийн гэмт хэргийн хохирогч болохоос болгоомжлох, айдсын түвшинг асууна.

(СО3.2) Та гэр бүлийн гишүүддээ (эхнэр/нөхөр, хамтран амьдралч, гэр бүлийн бусад гишүүн) ямар нэг гэмт хэргийн улмаас хохирохоос айдаг уу? (НН1.11<>1 тохиолдолд асууна)

Өрхийн ам бүл 1 бол энэ асуултыг асуухгүй. 1-ээс олон ам бүлтэй бол гэр бүлийн гишүүддээ ямар нэг гэмт хэргээс хохирохоос айдаг эсэхийг асууна.

(СО4) Иргэд гэмт хэрэгт хохирохоос болгоомжлох нь элбэг байдаг. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэд гэмт хэргийн улмаас хохирохоос болгоомжлох байдлыг илрүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой явуулахад чухал байр суурийг илэрхийлэх хүчин зүйл болдог. Болгоомжлох үзэгдлийг илрүүлэхэд өөрийгөө гэмт хэрэгт хохирох эрсдэлтэй гэж үзэх, хэн нэгэн халдсан тохиолдолд өөрийгөө хамгаалах чадамжтай эсэх гэсэн хүчин зүйлсийг судалдаг. Болгоомжлох гэж аюулаас сэргийлэх, аиж болгоомжлох, сайтар болгоомжлох гэсэн утгатай. Огт үгүй “1”, Үгүй “2”, Дунд “3”, Их “4”, Маш их “5” гэсэн сонголтоос хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно.

(СО4.1) Та өөрийгөө бусад хүнээс илүү гэмт хэрэгт хохирох магадлалтай гэж боддог уу? Тухайн ярилцлага өгөгч иргэний өөрийгөө гэмт хэрэгт хохирох эрсдэлтэй гэж үзэх үзэл бодлыг асууна.

(СО4.2) Хэн нэгэн тан руу халдсан тохиолдолд та өөрийгөө хамгаалж чадна гэж боддог уу? Тухайн ярилцлага өгөгч өөрийнх нь аюулгүй байдалд хэн нэгэн халдсан тохиолдолд биеэ хамгаалж, чадах эсэхийг тодорхойлж, асууна.

(СО5) Дараах асуултууд нь гэмт хэргийн улмаас шууд бусаар хохирсон байдлын талаар асуух болно. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэд гэмт хэргийн улмаас шууд болон шууд бус байдлаар хохирдог. Шууд байдлаар хохирох үзэгдэл нь өөрийн биеэр хохирохыг хэлэх бөгөөд шууд бусаар хохирох байдал нь өрхийн хэн нэгэн гишүүн эсвэл ойр дотны хэн нэгэн хохирсны улмаас дам байдлаар хохирохыг ойлгоно.

(СО5.1) Сүүлийн 12 сарын хугацаанд танай гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн танил хүмүүс гэмт хэргийн улмаас хохирсон уу? Тийм “1”, Үгүй “2”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн сонголтын аль нэгийг сонгоно. Үгүй, Мэдэхгүй / Хариулаагүй хариултыг сонгосон тохиолдолд СОБ.1-ийг асууна. Гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, саданы хүнийг ойлгоно. **Төрлийн хүн** гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг ойлгоно. **Саданы хүн** гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг ойлгоно.

(СО5.2) Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн танил хүмүүсийн тань хэн нэгэн ямар хэлбэрээр хохирч байсан бэ? (Олон сонголттой байж болно)

- Бие махбодын “А” - Хүний эрүүл мэндэд гэм хор учруулснаас үүсэх бие махбодын шаналал, өвдөлт, зовиур зэрэг сөрөг үр дагаварыг хэлнэ.
- Эд хөрөнгийн “В” - Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсний улмаас үүссэн хохирлыг ойлгоно.
- Сэтгэл санааны “С” - Гэмт хэргийн хохирогч болсны улмаас сэтгэл санаа нь байнгын айdas түгшүүрт автаж, эргээд зан төлөвт нь сөргөөр нөлөөлөх, нийгэмд бие даан амьдрах чадвараа алдах гэх мэт үр дагаврууд үүсэх эрсдэлийг сэтгэл санааны хохирол гэж үзнэ.
- Эдийн засгийн “D”- Гэмт хэргийн улмаас мөнгө, санхүүгийн хувьд хохирсон байдлыг эдийн засгийн хохирол гэж үзнэ.

(СО6) Дараах асуултууд нь таны өдөр тутмын амьдралын хэв маягтай холбоотой асуулт байна. Хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу. Иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маяг нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлтэй шууд хамааралтай байдаг бөгөөд нийтийн тээврийн хэрэгслийг ашиглах, гэрээ эзгүй орхих байдал, согтууруулах ундааны хэрэглээ, өдөр тутмын амьдралын сэтгэл ханамжийн хүчин зүйл зэрэг нь чухал нөлөөтэй гэж үздэг.

(СО6.1) Та сүүлийн 12 сарын хугацаанд 7 хоногт дунджаар хэдэн удаа нийтийн тээврийн хэрэгсэл (автобус, троллейбус, такси, галт тэрэг)-ээр зорчсон бэ? (Зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна) Энэ асуултыг зөвхөн нийслэл, аймгийн төв, сумын төвд оршин суудаг иргэдээс асууна. **Нийтийн тээвэр** гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн үйлчилгээний замын чиглэл, цагийн хуваарийн дагуу болон зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа зорчигч тээвэрлэлт, таксийн үйлчилгээг хэлнэ. Нийтийн тээвэрт автобус, троллейбус, такси, галт тэргийг хамруулна. Өдөр бүр “1”, Долоо хоногт 3-4 удаа “2”, Долоо хоногт 1-2 удаа “3”, Ашиглаагүй “4” гэсэн сонголтоос тохирохыг сонгоно.

(СО6.2) Та сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар хэдэн удаа гэртээ оройтож (ойролцоогоор 22 цагаас хойш) ирсэн бэ? Өдөр бүр “1”, Долоо хоногт 2-3 удаа “2”, Долоо хоногт 1 удаа “3”, 15 хоногт 1 удаа “4”, Сард 1 удаа “5”, Оройтож ирээгүй “6” гэсэн сонголтоос тохирохыг сонгоно. Ярилцлага өгөгч иргэний сүүлийн 12 сард

оройтож ирсэн хугацааг тодорхойлох нь гэмт хэрэгт хохирох эрсдэлийг тооцох үзүүлэлтийн нэг юм.

(СО6.3) Та сүүлийн 12 сарын хугацаанд дунджаар хэдэн удаа гэртээ согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай ирсэн бэ? Энэ үзүүлэлт нь ярилцлага өгөгч иргэний гэмт хэрэгт хохирох эрсдэлийг тодорхойлох суурь үзүүлэлтүүдийн нэг юм. Өдөр бүр “1”, Долоо хоногт 2-3 удаа “2”, Долоо хоногт 1 удаа “3”, 15 хоногт 1 удаа “4”, Сард 1 удаа “5”, Оройтож ирээгүй “6” гэсэн сонголтоос тохирохыг сонгоно.

(СО6.4) Та сүүлийн 12 сарын хугацаанд өдөрт дунджаар хэдэн цагаар гэрээ зээнгүй орхиж байсан бэ? (Ажилдаа явах болон бусад шалтгаанаар) Энэ нь гэмт хэрэгт хохирох эрсдэлийг тодорхойлох үндсэн үзүүлэлтүүдийн нэг юм. Эзэнгүй орхиж байгаагүй “1”, 4 хүртэлх цагаар “2”, 4-8 хүртэлх цагаар “3”, 8-12 хүртэлх цагаар “4”, 12 ба түүнээс дээш цагаар “5” гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО6.5) Та өөрийнхөө өдөр тутмын амьдралд хэр сэтгэл ханамжтай байдаг бэ?

Хүний эрүүл мэнд, бие махбодын байдлаас үл хамааран хувь хүний орлого, боловсрол, амьдрах орчин гэх мэт субъектив ойлголтууд нь хүний амьдралд чухал байдгийг бид сайн мэнднэ. Амьдралын сэтгэл ханамж нь тухайн хүний сайн сайхан байдлын түвшинг хэмжих хэмжүүр үзүүлэлт бөгөөд хүний тухайн үеийн орлого, эд хөрөнгөөс үл хамаарна. Сэтгэл ханамж нь аз жаргалтай харьцуулахад илүү урт удаан хугацааны асуудлыг хамардаг гэж үздэг байна. Энэ үзүүлэлт нь ярилцлага өгөгчийн хувьд өдөр тутмын амьдралдаа хэр сэтгэл ханамжтай байгааг дараах сонголтуудаар илэрхийлнэ.

Огт сэтгэл ханамжгүй “1”, Сэтгэл ханамжгүй “2”, Дунд зэрэг “3”, Сэтгэл ханамжтай “4”, Маш их сэтгэл ханамжтай “5” гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО7) Иргэд гэмт хэргийн улмаас хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор өөрийгөө болон эд хөрөнгөө хамгаалах үйлдлийг хийдэг. Дараах үйлдлүүдээс хамгийн оновчтой гэж үзэж байгаа нэг хариултыг сонгоно уу.

Иргэд гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор өөрийгөө болон өрхийн гишүүн, эд хөрөнгөө хамгаалах үйлдлийг хийдэг. Өөрийгөө болон өрхийн гишүүнээ хамгаалах үйлдэлд унтахаасаа өмнө хаалга болон цонхoo шалгах, бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл биедээ авч явах, оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явахыг хүсэх, аюултай газраар явахгүй байх, оройн цагаар гадуур гарах болон оройн цагаар ганцаараа явах үедээ такси барихаас зайлсхийх, оршин сууж буй нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар нэгэн ажил сайн дураараа хийх, хүүхдээ гэртээ ганцаараа нь орхих эсвэл ганцаараа нь гаргах зэргийг хамруулна. Эд хөрөнгөө хамгаалах үйлдэлд унтахаасаа өмнө хаалга болон цонхoo шалгах, гэрээсээ хол явах үедээ хөршөөсөө гэрээ харж байхыг хүсэх, брэнд хувцас, үнэт эдлэл хэрэглэж гадуур явах, их хэмжээний бэлэн мөнгө эсвэл төлбөрийн карт биедээ авч явахаас зайлсхийх, оршин сууж буй нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар нэгэн ажил сайн дураараа хийх зэргийг хамруулна. Үгүй “1”, Заримдаа “2”, Ихэвчлэн “3”, Тогтмол “4” гэсэн сонголтуудаас тохирохыг сонгоно.

(СО7.1) Та унтахаасаа өмнө хаалга болон цонхoo шалгадаг уу? Энэ үзүүлэлт нь иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлж, өөрийгөө болон гэр бүл эд хөрөнгөө хамгаалах үйлдлийн нэг юм. Ярилцлага өгөгчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж,

өөрийгөө болон гэр бүл, эд хөрөнгөө хамгаалж унтахын өмнө хаалга, цонхoo шалгадаг эсэхийг асууна.

(СО7.2) Та өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг уу? Ярилцлага өгөгч биеэ хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохионы хэрэгсэл биедээ авч явдаг эсэхийг асууна.

(СО7.3) Та оройн цагаар гадуур гараадаа хэн нэгнээс хамт явах талаар тусlamж хүсдэг үү? Ярилцлага өгөгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувь хүний аюулгүй байдлаа хамгаалах үүднээс оройн цагаар гадуур гараадаа хэн нэгнээс хамт явах талаар тусlamж хүсдэг эсэхийг асууна.

(СО7.4) Та хохирогч болохгүй байх үүднээс аюултай газраар явахаас зайлсхийдэг үү? Гэмт хэрэгт хохирох эрсдэлээс өөрийгөө хамгаалах үүднээс аюултай газраар явахаас зайлсхийдэг эсэхийг асууна.

(СО7.5) Та оройн цагаар ганцаараа явах үедээ такси барихаас зайлсхийдэг үү? (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна)

Энэ асуулгыг зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг сонгогдсон өрхийн 14, түүнээс дээш насны иргэдээс асууна.

(СО7.6) Та оршин сууж буй нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар нэгэн ажил сайн дураараа хийдэг үү? Энэ нь иргэдийн иргэний үүргээ биелүүлж, нийтийн сайн сайхны төлөө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үйл ажиллагаанд оролцдог эсэхийг асууна.

(СО7.7) Та хэдэн өдрөөр гэрээсээ хол явах тохиолдолд хөрш болон саахалт айлаасаа гэрээ харж байхыг хүсдэг үү? Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зорилгоор иргэд гэрээсээ хол явах үедээ хөрш болон саахалт айлуудаасаа гэрээ харж байхыг хүсдэг эсэхийг асууна.

(СО7.8) Та бага насны хүүхдээ гэртээ ганцааранг нь орхиж гардаг уу?(0-11 насны хүүхэдгүй бол хариулах боломжгүй хувилбарыг сонгоно уу)

Бага насны хүүхдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах үүднээс гэртээ ганцаараа орхиж гардаг эсэхийг асууна. Хэрэв 11-ээс доош насны хүүхэдгүй бол "Хариулах боломжгүй" хувилбарыг сонгоно. 11-ээс доош насны хүүхдийг бага насны хүүхдэд хамруулна.

(СО7.9) Та бага насны хүүхдээ ганцааранг нь гадуур гаргадаг уу?

(0-11 насны хүүхэдгүй бол хариулах боломжгүй хувилбарыг сонгоно уу)

Ярилцлага өгөгч хүүхдээ гэмт хэрэгт хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор ганцааранг нь гадуур гаргахаас зайлсхийдэг эсэхийг асууна. Хэрэв 11-ээс доош насны хүүхэдгүй бол "Хариулах боломжгүй" хувилбарыг сонгоно.

(СО7.10) Та үнэтэй хувцас, эдлэл хэрэглэж гадуур явахаас зайлсхийдэг үү? Үнэтэй хувцас, эдлэл хэрэглэж гадуур явах нь гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийн нэг гэж үздэг. Ярилцлага өгөгч үнэтэй хувцас, эдлэл хэрэглэж гадуур явдаг эсэхийг асууна.

(СО7.11) Та задгай хувцаслаж гадуур явахаас зайлсхийдэг үү? (НН3.03=2 тохиолдолд асууна) Хэтэрхий богино юбка өмсөх, энгэр задгай даашинз өмсөх, богино шорт өмсөх гэх мэт олон нийтийн газар хэт хүний анхаарал татсан байдлаар

хувцаслаж гадуур явах нь гэмт хэрэгт хохирох эрсдэл үүсгэх магадлалтай гэж үздэг тул энэ үйлдлээс зайлсхийдэг эсэхийг асууна.

(СО7.12) Та их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явахаас зайлсхийдэг үү? Иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хамгаалах үүднээс их хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явахаас зайлсхийдэг. Ярилцлага өгөгч аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор их хэмжээний мөнгө биедээ авч явдаг эсэхийг асууна.

(СО8) Иргэд эд хөрөнгөө хамгаалах зорилгоор төрөл бүрийн арга хэмжээг авдаг. Та сүүлийн 12 сард дараах арга хэмжээг авсан уу? (Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна)

Иргэд эд хөрөнгөө хамгаалахдаа техник технологийн дэвшил, биет хамгаалалт, хүн, амьтны хүчийг ашиглах арга хэмжээг үр дүнтэй гэж үздэг. Биет хамгаалалт гэдэг нь хаалга, цонхны төмөр хамгаалалт, давхар цоож, дохиоллын болон хяналтын систем, галт зэвсэг зэргийг ойлгоно. Хүн, амьтныг хамгаалах хүчин зүйлд хамгаалалтын ажилтан, харуул хамгаалалтын чиглэлээр бэлтгэгдсэн эсвэл ийм зорилгоор ашиглах нохойг авч үзнэ. Зөвхөн нийслэл, аймгийн төвд оршин суудаг иргэдээс асууна.

(СО8.1) Хаалгандаа төмөр хамгаалалт хийсэн үү? Ярилцлага өгөгч эд хөрөнгөө хамгаалах үүднээс хаалгандаа төмөр хамгаалалт хийсэн эсэхийг асууна. Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.2) Цонхондоо хамгаалалт хийсэн үү? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.3) Давхар эсвэл дижитал цоож суулгасан уу? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.4) Дохиоллын систем суурилуулсан уу? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.5) Хяналтын камер суурилуулсан уу? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.6) Нохойтой юу? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.7) Хамгаалалтын ажилтан хөлсөлсөн үү? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

(СО8.8) Галт зэвсэг худалдан авсан уу? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно.

Иргэдийн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэлийн талаарх мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг оновчтой тодорхойлох, албаны үйл ажиллагааг сайжруулахад ач холбогдолтой байдаг.

(СО9) Та дараах эрх бүхий байгууллагыг мэдэх үү? Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгоно. Эрх бүхий байгууллагад Цагдаагийн байгууллага, Прокурорын байгууллага, Шүүн таслах байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Шүүх шинжилгээний байгууллагыг хамааруулан ойлгох бөгөөд байгууллага тус бүр хуулиар хүлээсэн өөр өөр чиг үүрэгтэй.

(СО10) Та дараах эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг хэр үр дүнтэй гэж үздэг вэ ? Ярилцлагын өгөгчийн төсөөллөөр дээрх хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг хэр дүнтэй байдаг талаарх үнэлэмжийг тодорхойлно. Дараах сонголтоос тохирохыг байгууллага тус бүр дээр тохирохыг сонгоно.

- Mash үр дүнтэй “1”
- Зарим талаар үр дүнтэй “2”
- Үр дүнгүй “3”
- Огт үр дүнгүй “4”
- Мэдэхгүй / Хариулаагүй “98”

(СО11) Та дараах эрх бүхий байгууллагад итгэдэг үү? Ярилцлага өгөгчийн үзэл бодол, итгэл үнэмшлийг тодруулах байдлаар асууна. Ликертийн Шатлалын маш их итгэдэг “1”, Зарим талаар итгэдэг “2”, Итгэдэггүй “3”, Огт итгэдэггүй “4”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн 5 хувилбаруудаас аль нэгийг байгууллага тус бүр дээр сонгоно.

2.2.3. ХЭСЭГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН БАЙДАЛ (Сүүлийн 3 жилээр)

(CV1) Сүүлийн 3 жилийн хугацаанд та тээврийн хэрэгсэлтэй байсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд тээврийн хэрэгсэлтэй байсан бол Тийм буюу “1”, байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэж хариулсан тохиолдолд CV4 хэсэгт шилжинэ.

Тээврийн хэрэгсэл гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгсэл, мотоцикл, мопедыг ойлгоно.

(CV2) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таны тээврийн хэрэгсэл (мотоцикл, мопедыг оруулан)-ийг хулгайлсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд тээврийн хэрэгслээ хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1”, алдаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV27, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 1-ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV3) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таны тээврийн хэрэгслийн эд анги (гэрэл, дугуй, цонх, толь зэрэг)-ийг хулгайлсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд тээврийн хэрэгслийн эд ангия хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1”, алдаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV28, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 2-ыг гэдгийг анхаарна уу.

(CV4) Сүүлийн 3 жилийн хугацаанд та унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэлтэй байсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэлтэй байсан бол Тийм буюу “1”, байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэсэн хариултыг сонговол CV6 хэсэгт шилжинэ. **Хөдөлгөөнт хэрэгсэлд** ердийн болон цахилгаан скутер, скейт, цахилгаан дугуйг оролцуулж ойлгоно.

(CV5) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таны унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслийг хулгайлсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслээ хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1”, алдаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа

тохиолдсоныг бичиж CV29, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 3-ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV6) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн танай гэр, орон сууц руу зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг оролдсон уу? Жишээлбэл: хаалга, цоож эвдэх, цонх хагалах зэрэг. Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд гэр орон сууц руу зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг оролдсон тохиолдолд Тийм буюу “1”, тохиолдоогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Жишээлбэл: хаалга, цоож эвдэх, цонх хагалах зэрэг. Гэр гэж бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг ойлгоно. **Орон сууцны байшин** гэж бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй суурин барилгын доторх сууцыг ойлгоно.

(CV7) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн танай гэрээс ямар нэгэн эд зүйл хулгайлсан эсвэл хулгайлахыг завдсан уу? (Тусдаа агуулах, гарвашийг оруулахгүй) Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд танай гэрээс ямар нэгэн эд зүйл хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1”, тохиолдоогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV30, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 4-ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV8) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн танаас ямар нэг зүйлийг булаах эсвэл хүчээр авахыг оролдсон уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд танаас ямар нэг зүйлийг булаах эсвэл хүчээр авахыг оролдсон тохиолдолд Тийм буюу “1”, тохиолдоогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэсэн хариултыг сонговол CV10 хэсэгт шилжинэ.

(CV9) Тэр хүн ямар нэг зүйлийг тань сүрдүүлж эсвэл хүч хэрэглэж авсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд таныг сүрдүүлж эсвэл хүч хэрэглэж авсан тохиолдолд Тийм буюу “1”, хүч хэрэглэж аваагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV31, Маягт 3-ын Хэсэг 5-ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV10) Сүүлийн 3 жилийн хугацаанд та халаасны хулгайн (түрийвч, цаг, үнэт зүйл, гар утас зэрэг) гэмт хэргийн улмаас хохирсон уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд хулгайн гэмт хэргийн улмаас хохирсон тохиолдолд Тийм буюу “1”, хохироогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV32, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 6-г нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV11) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэнд залилуулсан уу? Энэ нь биечлэн, утсаар, интернэтээр тохиолдсон байж болно. Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэнд залилуулсан тохиолдолд Тийм буюу “1”, залилуулаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV33, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 7-г нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV12) Та сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн байгууллагаас үйлчилгээ, мэдээлэл авах хүсэлт гаргасан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн байгууллагаас үйлчилгээ, мэдээлэл авах хүсэлт гаргасан тохиолдолд Тийм буюу “1”, хүсэлт гаргаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэсэн хариултыг сонговол CV14 хэсэгт шилжинэ.

Энэ асуултад цахим үйлчилгээ хамаarahгүй. Тодруулбал: Өрхийн эмнэлгээр үйлчлүүлэх, сургууль, дамжаанд суралцах, иргэний үнэмлэх авах г.м.

(CV13) Сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн байгууллагын албан хаагч үйлчилгээ үзүүлэхдээ танаас үйлчилгээний төлбөрөөс гадна мөнгө, эд зүйл авсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн байгууллагын албан хаагч үйлчилгээ үзүүлэхдээ танаас үйлчилгээний төлбөрөөс гадна мөнгө, эд зүйл авсан тохиолдолд Тийм буюу “1”, аваагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV34, Маятг-АОАБС-3-ын Хэсэг 8-ийг нөхнө гэдгийг анхаарна уу. Энэ асуултад цахим үйлчилгээ хамаарахгүй.

Мөнгө (төгрөг, гадаад валютыг бэлнээр эсвэл дансаар), эд зүйл (тодорхой үнэ шингэсэн хүний хэрэгцээ хангахуйц материаллаг эд зүйлс)-ийг өөрийн биээр болон бусдаар дамжуулан авсан үйлдлийг хамруулан ойлгоно.

CV14-16, CV24-р асуултад дараах тайлбарыг заавал хэлнэ.

- **Нийгэмд багагүй хүчирхийллийн хэрэг гарч байна. Одоо би танаас хүчирхийлэлд өртсөн эсэх талаар хэдэн асуулт асууна. Та эмзгээр хүлээж авалгүйгээр үнэн зөв хариулаарай..**

(CV14) Сүүлийн 3 жилийн хугацаанд та махбодын хүчирхийлэлд өртсөн үү? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Тийм буюу “1”, өртөөгүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV35, Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

Бие махбодын хүчирхийлэл гэж хүний эрүүл мэндэд гэм хор учруулах, бие махбодын шаналал, өвдөлт, зовиур зэрэг сөрөг үр дагавар үүсгэхийг ойлгоно.

(CV15) Сүүлийн 3 жилийн хугацаанд та сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн үү?

Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Тийм буюу “1”, өртөөгүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV36, Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

Сэтгэл санааны хүчирхийлэл, зарим тохиолдолд сэтгэл зүйн гэж дурдагдах хүчирхийллийг хэлэх бөгөөд хэл, амаар доромжилох, бусдын өмнө доромжилж, эвгүй байдалд оруулах, айлгахын тулд хашгирах, эд зүйлс эвдэх, үг хэлээр айлган сүрдүүлэх, заналхийлэх зэрэг үйлдлийг ойлгоно.

(CV16) Сүүлийн 3 жилийн хугацаанд та эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн үү? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд бие сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Тийм буюу “1”, өртөөгүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV37, Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

Эдийн засгийн хүчирхийлэл гэж хамтрагчаа аливаа орлого олох үйл ажиллагаанд оролцохыг хориглох, олсон мөнгийг дур мэдэн авах, гэр бүлдээ зарцуулах мөнгө өгөхгүй атлаа өөрөө архи, тамхинд мөнгө зарцуулах, гэр бүлийн төсвийг захиран зарцуулахыг хориглох, дарамтлах зэрэг нь хамтрагчийн үйлдэж буй эдийн засгийн хүчирхийлэл юм. Гэр бүлийн хүчирхийлэл гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг,

эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдийн зүгээс гэр бүлийн хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

(CV17) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таныг гэрт тань эсвэл бусад газар хүч хэрэглэхээр заналхийлсэн үү? (Бие махбодын хүчирхийлэлд өртсөнийг оруулахгүй, бусад газар гэдэгт жишээлбэл: баар, гудамж, сургууль, нийтийн тээврийн хэрэгсэл эсвэл ажлын байр гэх мэт)

Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таныг гэрт тань эсвэл бусад газар хүч хэрэглэхээр заналхийлсэн тохиолдолд Тийм буюу “1”, заналхийлээгүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Бие махбодын хүчирхийлэлд өртсөнийг оруулахгүй. Бусад газар гэдэгт баар, гудамж, сургууль, нийтийн тээврийн хэрэгсэл эсвэл ажил гэх мэтийг ойлгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV38 Маят-АОАБС-3-ын Хэсэг 10 -ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV18) Сүүлийн 3 жилийн хугацаанд та өөрийн эзэмшлийн малтай байсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн эзэмшлийн малтай байсан тохиолдолд Тийм буюу “1”, байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэсэн хариултыг сонговол CV20-р асуулт руу шилжинэ.

Мал нь адuu, үхэр, тэмээ, хонь, ямаа гэсэн төрөлтэй.

(CV19) Сүүлийн 3 жилийн хугацаанд та малаа хулгайд алдсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд малаа хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1”, алдаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV39, Маят-АОАБС-3-ын Хэсэг 11 -ийг нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV20) Сүүлийн 3 жилийн хугацаанд та цахим орчинд ухаалаг төхөөрөмжийг ашигласан уу?

Тухайлбал:

1. Суурин компьютер
2. Зөөврийн компьютер
3. Интернэт холболттой ухаалаг утас, таблет
4. Нийтийн хэрэглээний компьютер (интернэт кафе, буудал, номын сан, их сургуулийн гэх мэт)
5. Ухаалаг зурагт
6. Ухаалаг тоглоом
7. Бусад (.....)

Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд цахим орчинд ухаалаг төхөөрөмж ашигласан тохиолдолд Тийм буюу “1”, ашиглаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Үгүй гэсэн хариултыг сонговол CV22-р асуулт руу шилжинэ.

Суурин компьютер, зөөврийн компьютер, интернэт холболттой ухаалаг утас, таблет, нийтийн хэрэглээний компьютер (интернэт кафе, буудал, номын сан, их сургуулийн гэх мэт), ухаалаг зурагт, ухаалаг тоглоом, бусад. Бусад гэдэгт дээр дурдагдаагүй цахим орчинд ашиглах төхөөрөмжийг хэлнэ.

(CV21) Сүүлийн 3 жилийн хугацаанд та цахим орчинд ямар нэгэн хэлбэрээр хохирсон уу?

Тухайлбал:

1. Цахим дарамтад орсон
2. Хувийн цахим шуудан халдлагад өртсөн
3. Олон нийтийн сүлжээний халдлагад өртсөн
4. Хувийн мэдээллээ алдсан
5. Төхөөрөмжид вирус суусан
6. Вирусийн улмаас өөрийн цахим хаяг, олон нийтийн сүлжээний хаяг, банкны аппликеийшн зэргийг ашиглах боломжгүй болсон.

Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд цахим орчинд ямар нэгэн хэлбэрээр хохирсон тохиолдолд Тийм буюу “1”, хохироогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV40 Маягт-АОАБС-3-ын Хэсэг 12-ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

Цахим дарамт (Cyberbullying) гэдэг нь хэн нэгэн таныг гомдоох, ичээх, сэтгэл санааны хор хөнөөл учруулах зорилгоор цахим шуудан, олон нийтийн сүлжээ, цахим хуудас болон үүрэн холбооны үйлчилгээг ашиглан ямар нэг бичвэр, зураг, видеог цахим хэлбэрээр илгээсэн буюу нийтэлсэн үйлдлийг хэлнэ.

Цахим шуудангийн хаягийг хакердах (Email hacking) гэдэг нь хэн нэгэн зөвшөөрөлгүйгээр таны цахим шуудангийн хаягт нэвтэрч таны харилцагчдад (найз нөхөд/гэр бүл) танаас илгээгээгүй мэдээллийг хүлээн авахад хүргэсэн үйлдлийг хэлнэ.

Олон нийтийн сүлжээг хакердах (Social media hacking) гэдэг нь хэн нэгэн зөвшөөрөлгүйгээр таны Facebook, Twitter, Instagram, LinkedIn, блог гэх мэт олон нийтийн сүлжээнд нэвтэрч танаас илгээгээгүй мэдээллийг нийтэлсэн үйлдлийг хэлнэ.

Хувийн мэдээллийг хулгайлах (Identity theft/impersonation) гэдэг нь хэн нэгэн таны мэдээллийг (иргэний үнэмлэх, тоон гарын үсэг, хэрэглэгчийн нэр, нууц үг, гадаад паспортын дугаар зэрэг) цахим орчинд хулгайлан зөвшөөрөлгүйгээр таны өмнөөс ашигласан үйлдлийг хэлнэ.

Вирус бүхий программ (Malware) гэдэг нь таны ухаалаг төхөөрөмжид мэдээллийг устгах, файл эсвэл хүсээгүй программыг татах, ажиллуулах чадвартай, өөрийгөө хувилж хувилсан хувилбаруудаа төхөөрөмжийн өгөгдлийн хэсгүүдэд тархаадаг трояны морь, ворм, спайвейр гэх мэт вирус суусан үйлдлийг хэлнэ.

Рансомвейр (Ransomware) гэдэг нь таны ухаалаг төхөөрөмж, өгөгдөл хандах хандалтыг хааж (хортой программ) хандалтыг сэргээхэд төлбөр төлөхийг хүсэх үйлдлийг хэлнэ.

(CV22) Сүүлийн 3 жилийн хугацаанд та болон танай өрхийн хэн нэгэн гишүүн зам тээврийн ослын улмаас хохирсон уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд зам тээврийн аслын улмаас хохирсон тохиолдолд Тийм буюу “1”, хохироогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV41, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 13-ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.

(CV23) Сүүлийн 5 жилийн хугацаанд та дараах нөхцөлөөр хувь хүн талаасаа ялгаварлан гадуурхалт, доромжлол мэдэрсэн үү?

1. Үндэс угсаа
2. Хүйс
3. Бэлгийн чиг баримжаа
4. Нас
5. Шашин шүтлэг
6. Хөгжлийн бэрхшээл
7. Нутаг ус
8. Хот хөдөө
9. Амьжиргааны түвшин
10. Амьдарч байгаа газар
11. Боловсролын түвшин
12. Үзэл бодол
13. Гадна төрх
14. Бусад

Энд, сүүлийн 5 жилийн хугацаанд хувь хүн талаасаа ялгаварлан гадуурхалт, доромжлол мэдэрсэн тохиолдолд Тийм буюу “1”, мэдрээгүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV42, Маягт-АОАБС-З-ын Хэсэг 14 -ийг нөхнө гэдгийг анхаарна уу. Үүнд: үндэс угсаа, хүйс, бэлгийн чиг хандлага, нас, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нутаг ус, хот хөдөө, амьжиргааны түвшин, амьдарч байгаа газар, боловсролын түвшин, үзэл бодол, гадна төрх, бусад. Энэ нь **ТХЗ-16.5.1**-ийн шалгуур үзүүлэлт юм.

Ялгаварлан гадуурхалт гэж аливаа хүнийг арьс өнгө, хэл соёл, угсаа гарвал, нас, хүйс, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, үзэл бодлоор нь ялгаварлан харьцах үзлийг хэлнэ.

- Үндэс угсаа: халх, баяд, дөрвөд, буриад, казах гэх мэт;
- Хүйс: эр, эм;
- Бэлгийн чиг хандлага: гетеросекс (өөрөөсөө эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн), гомосекс (өөртэйгээ ижил хүйсийн хүнд татагддаг хүн), бисекс (өөрөөсөө эсрэг болон ижил хүйсийн хүнд татагддаг хүн), пансекс (аль нэг хүйсэнд баригдалгүйгээр бүх бэлгийн чиг баримжаатай хүмүүст татагддаг хүн), асекс (бэлгийн дур хүслийг мэдэрдэггүй буюу бэлгийн чиг баримжаагүй хүн), трансжендер (өөрийн байгалиас заясан хүйстэй өөрийн сэтгэл санааны хүйс хоёр хоорондоо тааран зохицохгүй зөрчилдөх улмаар өөрийнхөө хүйсийг солих, эсрэг хүйстэн шигээ биеэ авч явах, тэдэн шиг хувцаслахыг хүсдэг);
- Нас: Ярилцлага өгөгчийн бүтэн нас;
- Шашин шүтлэг: итгэл үнэмшлийн нэг хэлбэр. Жишээлбэл: буддын, бөөгийн, христос, исламын гэх мэт.
- Хөгжлийн бэрхшээл: бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан байдал;
- Нутаг ус: өссөн, төрсөн нутаг усны гарвалаар ялгаварлах байдал;
- Хот, хөдөө: хот хөдөөгийн гарвалиар ялгаварлах;
- Амьжиргааны түвшин: хэрэглээний түвшин;
- Амьдарч байгаа газар: амьдарч буй орчин, нөхцөл, хүрээлэл;
- Боловсролын түвшин: тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандарттаар тогтоосон мэдлэгийн хэмжээ;
- Үзэл бодол: төлөвшин тогтсон санаа, өөрийн байр суурь;
- Гадна төрх: гадна үзэмж, хувцаслалт, зүс царай;
- Бусад: дээр дурдагдаагүй бусад шалтгаан.

(CV24) Иргэд 18 хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэхгүй өнгөрөх явдал байдаг. Та 18 нас хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан уу? Энд, сүүлийн 3 жилийн хугацаанд 18 нас хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдолд Тийм буюу “1”, өртөж байгаагүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV43, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 15-ыг нөхнө гэдгийг анхаарна уу. Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг хэлнэ. Энэ үзүүлэлт нь ТХЗ-16.2.3-ийг үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

(CV25) Сүүлийн 3 жилийн хугацаанд та бэлгийн дарамтад өртсөн үү?

Хохирогчийг хүсээгүй үед хүчиндэхээс бусад төрлийн бэлгийн шинжтэй харилцаа холбоо үүсгэх, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх эсвэл хийхийг завдах үйлдлийг **бэлгийн дарамт** гэж ойлгоно. Тийм буюу “1”, тохиолдоогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV44, Маягт-АОАБС-3-ын Хэсэг 16-г нөхнө гэдгийг анхаарна уу.

(CV26) Сүүлийн 3 жилийн хугацаанд та дээр дурдсанаас бусад ямар нэг төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон уу? Энд, дээр дурдсанаас бусад төрлийн гэмт хэрэгт хохирч байсан тохиолдолд Тийм буюу “1”, хохироогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Тийм гэсэн хариултыг сонговол гэмт хэргийн төрлийг нэрлэхийг хүсэх ба хэдэн удаа тохиолдсоныг бичиж CV45 -ыг нөхнө гэдгийг анхаарна уу.

(INTV1) СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТЫГ ЛАВЛАХ ХҮСНЭГТ

/Мэдээлэл цуглувлагч нөхнө/

Мэдээлэл цуглувлагч сүүлийн 3 жилийн гэмт хэргийн гаралтыг лавлах хүснэгтийг бөглөнө. Сүүлийн 3 жилийн хугацаанд дараах гэмт хэргээс хохирсон эсэхийг тэмдэглэнэ. Хэрэв хохирсон бол хүснэгтэд харгалзах асуулт руу шилжинэ. Харгалзах асуултыг асуусны дараа Маягт АОАБС-3-ын харгалзах Хэсгийг асууна

Тээврийн хэрэгсэл хулгайллах, тээврийн хэрэгслийн эд анги хулгайллах, унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайллах, орон байрны хулгай, дээрэмдэх, хулгайллах, залилах, зам тээврийн осол, хахууль, хүчирхийлэл, заналхийлэх, мал хулгайллах, цахим халдлага, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт учруулах, бусад зэрэг гэмт хэргийн гаралтыг төрөл тус бүрээр тэмдэглэнэ. Тийм, үгүй гэсэн сонголтын аль нэгийг сонгож хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохирсон тохиолдолд хэдэн удаа тохиолдсоныг бичнэ. Тайлбар/ажиглалт хэсгийг мэдээлэл цуглувлагч нэмэлт тодотгох тэмдэглэлийг хөтөлнө.

- 2.2.4. ХЭСЭГ 4. ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРСОН БАЙДАЛ (Сүүлийн 12 сараар)

(CV27-45) Одоо би танд тохиолдсон гэмт хэргийн талаар илүү дэлгэрэнгүй асуулт асуух болно. Зөвхөн сүүлийн 12 сарын дотор, өөрөөр хэлбэл 2023 оны [ярилцлага авч буй сар] сараас өмнөх 12 сарын хугацаанд болсон үйл явдлыг оруулна.

Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа нь ерөнхийгөөс тусгайд чиглэсэн арга зүйг баримтлах бөгөөд иргэдийн гэмт хэрэгт хохирсон байдлын талаар асуухдаа энэ зарчмыг баримтална. Энэ хэсэгт хариулагч болон ярилцлага өгөгчийн өрхийн хэн нэгэн гишүүн сүүлийн 12 сард тээврийн хэрэгсэл хулгайлах, тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах, унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах, орон байрны хулгай, дээрэмдэх, хулгайлах, залиах, зам тээврийн осол, хахууль, хүчирхийлэл, заналхийлэл, мал хулгайлах, цахим халдлага, зам тээврийн осол, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт учруулах гэмт хэргийн улмаас хохирсон байдлын талаар асууна.

(CV27) Сүүлийн 3 жилийн хугацаанд та тээврийн хэрэгслээ хулгайд алдсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд тээврийн хэрэгслээ хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж маягт АОАБС-3-ын Хэсэг 1-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV28) Сүүлийн 3 жилийн хугацаанд та тээврийн хэрэгслийн эд ангия хулгайд алдсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд тээврийн хэрэгслийн эд ангия хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт 3-ын Хэсэг 2-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV29) Сүүлийн 3 жилийн хугацаанд та унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслээ хулгайд алдсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгслээ хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 3-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

Хөдөлгөөнт хэрэгсэлд ердийн болон цахилгаан скутер, скейт, цахилгаан дугуйг ойлгоно.

(CV30) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн танай гэр, орон сууц руу зөвшөөрөлгүй нэвтэрч ямар нэгэн зүйл хулгайлах эсвэл хулгайлахыг завдсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэгэн таны гэр, орон сууц руу зөвшөөрөлгүй нэвтэрч ямар нэгэн зүйл хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 4-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол алдаагүй Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV31) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таны эд хөрөнгийг хүч хэрэглэн дээрэмдсэн тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэгэн таны эд хөрөнгийг хүч хэрэглэн дээрэмдсэн тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 5-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV32) Сүүлийн 3 жилийн хугацаанд та халаасны хулгайн хохирогч болсон тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?

Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэгэн таны эд зүйлийг хүч хэрэглэх эсвэл сүрдүүлэхгүйгээр хулгайлсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 6 -г нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV33) Сүүлийн 3 жилийн хугацаанд та хэн нэгэнд залилуулсан тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэгэнд залилуулсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 7 -г нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV34) Сүүлийн 3 жилийн хугацаанд ямар нэг байгууллагын албан хаагч үйлчилгээ үзүүлэхдээ танаас үйлчилгээний төлбөрөөс гадна мөнгө, эд зүйл авсан тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэг байгууллагын албан хаагч үйлчилгээ үзүүлэхдээ танаас үйлчилгээний төлбөрөөс гадна мөнгө, эд зүйл авсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 8-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаас **ТХЗ 16.5.1**-ийн шалгуур үзүүлэлтийг гаргаж авна.

(CV35) Сүүлийн 3 жилийн хугацаанд та бие махбодын хүчирхийлэлд өртсөн тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаас **ТХЗ 16.1.3**-ийн шалгуур үзүүлэлтийг гаргаж авна.

(CV36) Сүүлийн 3 жилийн хугацаанд та сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн бол Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаас **ТХЗ 16.1.3**-ийн шалгуур үзүүлэлтийг гаргаж авна.

(CV37) Сүүлийн 3 жилийн хугацаанд та эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн бол Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 9-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаас **ТХЗ 16.1.3**-ийн шалгуур үзүүлэлтийг гаргаж авна.

(CV38) Сүүлийн 3 жилийн хугацаанд хэн нэгэн таныг гэрт тань эсвэл бусад газар хүч хэрэглэхээр заналхийлсэн тухай дурдсан. Энэ үйл явдал **сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу?** Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хэн нэгэн таныг гэрт тань эсвэл бусад газар хүч хэрэглэхээр заналхийлсэн тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маятг-АОАБС-3-ын Хэсэг 10-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. **Бие махбодын хүчирхийлэлд**

өртсөнийг оруулахгүй. Бусад газар гэдэгт баар, гудамж, сургууль, нийтийн тээврийн хэрэгсэл эсвэл ажил зэргийг ойлгоно.

(CV39) Сүүлийн 3 жилийн хугацаанд та өөрийн эзэмшлийн малаа хулгайд алдсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд малаа хулгайд алдсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж маягт АОАБС-3-ын Хэсэг 11-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Мал нь хонь, ямаа, тэмээ, үхэр, морь зэрэг болно.

(CV40) Сүүлийн 3 жилийн хугацаанд цахим халдлагын хохирогч болсон тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд цахим халдлагын хохирогч болсон тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 12-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV41) Сүүлийн 3 жилийн хугацаанд та болон танай өрхийн хэн нэгэн гишүүн зам тээврийн ослын улмаас хохирсон тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын өрхийн хэн нэгэн гишүүн зам тээврийн ослын улмаас хохирсон тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 13-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаар гарах үзүүлэлтээр ТХЗ-3.6.1-ийн шалгуур үзүүлэлтийг тооцох боломжтой.

(CV42) Сүүлийн 5 жилийн хугацаанд та хувь хүн талаасаа ялгаварлан гадуурхалт, доромжлол мэдэrsэн тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд хувь хүн талаасаа ялгаварлан гадуурхалт, доромжлол мэдэrsэн тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 14-ийг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаар ТХЗ-16.b.1-ийн шалгуур үзүүлэлтийг тооцох боломжтой.

Үүнд: үндэс угсаа, хүйс, бэлгийн чиг хандлага, нас, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нутаг ус, хот хөдөө, амьжиргааны түвшин, амьдарч байгаа газар, боловсролын түвшин, үзэл бодол, гадна төрх, бусад.

(CV43) Та 18 нас хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд 18 нас хүртэлх насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 15-ыг нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно. Энэ асуултаар ТХЗ-16.2.3-ийн шалгуур үзүүлэлтийг гаргана.

(CV44) Сүүлийн 3 жилийн хугацаанд та бэлгийн дарамтад өртсөн тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн дарамтад өртөж байсан тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичиж Маягт-АОАБС-3-ын Хэсэг 16-г нөхнө. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(CV45) Сүүлийн 3 жилийн хугацаанд та дээр дурдсанаас бусад ямар нэг төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон тухай дурдсан. Энэ үйл явдал сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон уу? Энд, сүүлийн 12 сарын хугацаанд дээр дурдсанаас бусад ямар нэг төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон тохиолдолд Тийм буюу “1” хариултыг сонгож, хэдэн удаа тохиолдсоныг бичнэ. Хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдоогүй бол Үгүй, өмнө нь тохиолдсон буюу “2” гэсэн хариултыг сонгоно.

(INTV2) ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТЫН ЛАВЛАХ ХҮСНЭГТ (Мэдээлэл цуглуулагч нөхнө)

Гэмт хэргийн гаралтыг лавлах хүснэгтийг мэдээлэл цуглуулагч нэгтгэх байдлаар бөглөнө. Тээврийн хэрэгсэл хулгайлах, тээврийн хэрэгслийн эд анги хулгайлах, унадаг дугуй, хөдөлгөөнт хэрэгсэл хулгайлах, орон байрны хулгай, дээрэмдэх, халаасны хулгай, залиах, зам тээврийн осол, хахууль, хүчирхийлэл, заналхийлэх, мал хулгайлах, цахим халдлага, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт учруулах, бусад зэрэг гэмт хэргийн гаралтыг төрөл тус бүрээр тэмдэглэнэ. Сүүлийн 3 жилийн хугацаанд болон сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохирсон байдлыг тэмдэглэж хэрэв сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохирсон тохиолдолд хэдэн удаа тохиолдсоныг бичнэ.

Сүүлийн 3 жил болон сүүлийн 12 сарын хугацаанд гэмт хэрэгт хохирсон тохиолдолд гэмт хэргийн төрөл тус бүрд Хэсэг 1-16 хүртэлх маягтаар асуулгаа үргэлжлүүлнэ.

(INTV.3) Орчны аюулгүй байдлын түвшинг лавлах хүснэгт: Мэдээлэл цуглуулагч нь судалгаанд оролцогчийн амьдарч байгаа газрын эргэн тойрныг ажиглаж нөхнө. Үүнд: хаалга цонхондоо давхар цоож эсвэл дижитал цоож суурилуулсан эсэх, хаалга, цонхондоо хамгаалалтын сараалж суурилуулсан эсэх, дохиоллын систем, домофон, чип, картын системтэй эсэх, хамгаалагчтай эсэх, 20 м радиуст хяналтын камер байрладаг эсэх, 20 м радиуст гудамжны гэрэлтүүлэгтэй эсэх, 100 м радиуст баар, ресторан, паб, зочид буудал байдаг эсэх, 100 м радиуст барилга угсралтын ажил явагдаж байгаа эсэх, 100 м радиуст үйлдвэрийн газар байдаг эсэх зэрэг болно. Тийм буюу “1”, Үгүй буюу “2” гэсэн хариултаас тохиорохыг сонгоно.

2.3. ХОХИРСОН БАЙДЛЫН АСУУЛГЫГ НӨХӨХ ЗААВАР (МАЯГТ-АОАБС-3)

Хохирсон байдлын асуулгын зорилго нь Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны үндсэн зорилгыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, Амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны үндсэн судлагдахуун нь иргэдийн гэмт хэрэгт хохирсон байдал, гэмт хэрэгт хохироход нөлөөсөн орчны аюулгүй байдлыг энэхүү асуулгаар нарийвчлан судална.

Хохирсон байдлын асуулгаар тухайн иргэн гэмт хэргийн улмаас хохирсноо хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад мэдэгдсэн эсэх, мэдэгдсэний дагуу хэрхэн арга хэмжээ авсан, хохирлыг хэрхэн барагдуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гэмт хэрэгт хохирох эрсдэл, орчны аюулгүй байдал, иргэн эрх бүхий байгууллагад хохирсноо мэдэгдээгүй бол ямар шалтгаанаар мэдэгдээгүй, ТХЗ-ын гэмт хэргийн хохирогчийн талаарх мэдээлэл, Алсын хараа-2050-ын амар тайван аюулгүй нийгмийн талаарх мэдээллийг цуглуулж, анализ дүн шинжилгээ хийж, Монгол хүний амьдралын чанарт гарч байгаа өөрчлөлтийг судална.

Гэмт хэрэг гэж Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно.

Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно (МУ-ЫН ЭХХШХ).

Учирсан хохирол гэж МУ-ЫН Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг ойлгоно (МУ-ЫН ЭХХШХ).

Хохирлын нөхөн төлүүлэлт гэж хүний эрх, эрх чөлөөний хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө байсан хэмжээнд нь сэргээхийг ойлгоно (НҮБ-ЫН тунхаглалаас)

2.3.1. ХЭСЭГ 1. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХУЛГАЙЛАХ

Тээврийн хэрэгсэл хулгайлах- Бусдын тээврийн хэрэгслийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авах үйлдлийг тээврийн хэрэгслийн хулгай гэж ойлгоно. Тээврийн хэрэгсэл гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгсэл, мотоцикл, мопедыг ойлгоно.

(M1.1) Тээврийн хэрэгслийн хулгай хэдэн сард болсон бэ? Хулгайд алдсан сарыг хариулт хэсэгт тоогоор бичнэ. Хэрэв олон удаа тохиолдсон бол сүүлийн 3 тохиолдлын сарыг тус бүр бичнэ.

(M1.2) Тээврийн хэрэгслээ хаана хулгайд алдсан бэ? Дараах хариултаас тохиорохыг сонгоно.

- Амьдарч байгаа газарт “1”- одоогийн амьдарч буй аймаг/нийслэл/суманд тохиолдсон бол,
- Өөр хот, аймаг, суманд бол “2”- Өөр хот, аймаг, суманд тохиолдсон бол,
- Өөр улсад “3”- Монгол улсаас өөр улсад тохиолдсон бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Хэрэв “Өөр улсад” сонголтыг сонгосон тохиолдолд асуулгыг дуусгана. Гэхдээ өөр төрлийн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тухайн гэмт хэргийн хэсгийг асуухыг анхаарна уу.

(M1.3) Тээврийн хэрэгслээ хулгайд алдсан газрын байршлыг тодорхой хэлнэ үү? Дараах хариултаас тохиорохыг сонгоно.

- Гудамж талбай “1”
- Гэр хорооллын гудамж “2”
- Орон сууцны хорооллын гудамж “3”
- Ил зогсоол “4”
- Гарааш “5”
- Худалдааны төв, дэлгүүр “6”
- Цэцэрлэгт хүрээлэн “7”
- Амралт, сувилал, жуулчны бааз “8”
- Үзвэр, үйлчилгээний газар “9”
- Авто, төмөр зам, нисэх онгоцны буудал “10”

- Бусад () “11” - дээр дурдагдаагүй газрын байршлыг хэлж байгаа тохиолдолд энэ сонголтыг сонгох ба мэдээлэл цуглуулагч нь ярилцлага егөгчийн хариултыг бичнэ.
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

(M1.4) Тээврийн хэрэгсэл алдагдсан газар хяналтын камер байсан уу?

Дараах хариултаас тохирохыг сонгоно.

- Тийм “1” – хяналтын камер байсан бол,
- Үгүй “2” - хяналтын камер байхгүй бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Хяналтын камер нь тодорхой нэг объектыг хянан дотоод сүлжээ болон интернэтээр хянах боломжийг олгодог тоон системийн камер юм.

(M1.5) Тээврийн хэрэгслийн хулгай хэдийд болсон бэ? Дараах хариултаас тохирохыг сонгоно.

- Өглөө “1”
- Өдөр “2”
- Үдэш “3”
- Шөнө “4”

(M1.6) Тээврийн хэрэгслийг хулгайлахдаа хүч хэрэглэсэн үү? Дараах хариултаас тохирохыг сонгоно.

- Тийм “1” – Тээврийн хэрэгслийг хулгайлахдаа хүч хэрэглэсэн бол,
- Үгүй “2” - Тээврийн хэрэгслийг хулгайлахдаа хүч хэрэглээгүй бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

(M1.7) Хулгайлалгdsan тээврийн хэрэгслээ буцааж олж авсан уу? Дараах хариултаас тохирохыг сонгоно.

- Тийм “1” – Хулгайлалгdsan тээврийн хэрэгслээ буцааж олж авсан бол,
- Тийм, гэхдээ эвдрэлтэй “2” - Хулгайлалгdsan тээврийн хэрэгслээ буцааж олж авсан, гэхдээ эвдрэлтэй бол,
- Үгүй “3” - Хулгайлалгdsan тээврийн хэрэгслээ буцааж олж аваагүй бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Тийм гэсэн хариултыг сонговол M1.9 асуулт руу шилжинэ.

(M1.8) Ямар хэмжээний хохирол учирсан бэ? Мөнгөн дүнг төгрөгөөр тооцож, дараах хариултаас тохирохыг сонгоно.

- 10,000,000 хүртэл “1”
- 10,000,001 – 30,000,000 “2”
- 30,000,001 – 60,000,000 “3”
- 60,000,001 – 100,000,000 “4”
- 100,000,001 - с дээш “5”

(M1.9) Тээврийн хэрэгслээ хулгайд алдсан талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэн үү?

Эрх бүхий байгууллагаад Цагдаагийн байгууллага, Прокурорын байгууллага, Шүүн таслах байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Шүүх шинжилгээний байгууллагыг хамааруулан ойлгох бөгөөд байгууллага тус бүр хуулиар хүлээсэн өөр өөр чиг үүрэгтэй.

Дараах хариултаас тохирохыг сонгоно. Тийм “1” – Эрх бүхий байгууллагаад мэдэгдсэн бол,

- Үгүй “2” - Эрх бүхий байгууллагаад мэдэгдээгүй бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Үгүй гэсэн хариултыг сонговол M1.14 асуулт руу шилжинэ. Мэдэхгүй / Хариулаагүй гэсэн хариултыг сонговол Хэсэг 1-ийг дуусгана.

(M1.10) Дараах эрх бүхий байгууллага мэдээллийн дагуу арга хэмжээ авсан уу?

- Тийм “1” – эрх бүхий байгууллага арга хэмжээ авсан бол,
- Үгүй “2” - эрх бүхий байгууллага арга хэмжээ аваагүй бол,
- Мэдэхгүй / Хариулаагүй “98” – хариулагч мэдэхгүй, эсвэл хариулахаас татгалзсан тохиолдолд энэ сонголтыг сонгоно.

Цагдаагийн байгууллага, Прокурорын байгууллага, Шүүхийн байгууллага тус бүрд тохирох кодыг нөхнө.

Тийм “1” гэсэн хариултыг сонговол M.1.11-р асуулт руу шилжинэ. Үгүй “2”, Мэдэхгүй / Хариулаагүй “98” гэсэн хариултыг сонговол дараагийн мөр буюу дараагийн байгууллага руу шилжинэ. Жишээ нь: Цагдаагийн байгууллага нь мэдээллийн дагуу арга хэмжээ авсан уу? гэж асуух Тийм “1” гэж хариулбал дараагийн асуулт руу шилжинэ. Харин Үгүй, мэдэхгүй / хариулаагүй тохиолдолд дараагийн мөр руу шилжих буюу Прокурорын байгууллага мэдээллийн дагуу арга хэмжээ авсан уу? гэж асууна.

(M1.11) Дараах эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хэр сэтгэл ханамжтай байсан бэ? Сонголт бүрд тохирох кодыг нөхнө.

Ярилцлага өгөгчийн үзэл бодол, итгэл үнэмшлийг тодруулах байдлаар асууна. Mash их, их, бага, маш бага, мэдэхгүй/хариулаагүй гэсэн 5 хувилбаруудаас аль нэгийг байгууллага тус бүр дээр сонгоно.

- Mash их “1”
- Их “2”
- Бага “3”
- Mash бага “4”
- Мэдэхгүй / Хариулаагүй “98”

Хэрэв маш их “1”, их “2”, Мэдэхгүй / Хариулаагүй “98”-г сонгосон бол дараагийн мөр буюу дараагийн байгууллагад хэр сэтгэл ханамжтай байсан эсэхийг асууна. Харин бага “3”, маш бага “4” хариултыг сонгосон бол M1.12-р асуулт руу шилжинэ.

(M1.12) Яагаад сэтгэл ханамжгүй байсан бэ?

- Сонголт бүрд тохирох кодыг нөхөх бөгөөд олон сонголттой байж болно. Доорх хариултыг хариулагчид урьдчилан уншиж өгөхгүйгээр хариулсан хариултад нь тохирохыг нөхнө.
- Хангалттай ажиллаагүй “А”
- Анхаарал хандуулаагүй “В”
- Гэмт хэргийг илрүүлээгүй, гэмт хэрэгтнийг олоогүй “С”
- Хохирлыг барагдуулаагүй “D”
- Шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаагүй “Е”
- Надтай хүндэтгэлгүй харьцсан “F”
- Дуудлага өгснөөс хойш их удаж ирсэн “G”
- Намайг ялгаварлаж харьцсан “H”
- Зардал, чирэгдэл их учирсан “I”
- Бусад “J”- дээр дурдагдаагүй хариулт хэлсэн бол энэ сонголтыг сонгох ба хариулсан хариултыг бичнэ.
